ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

ХУУЛЬ САХИУЛАХЫН ИХ СУРГУУЛЬ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН СУРГУУЛЬ

2016. №01 (17)

ОНОЛ-АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ





Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн сонгуулийг зохион байгуулах журам батлагдлаа

Онцгой байдлын сургуулийн “Аврагч”, Эрх зүй нийгмийн ухааны сургуулийн “Consensus”, нийт 7 шилдэг багууд оролцож оюун ухаан, авхаалж самбаагаа сорин мэтгэлцлээ.

Тэмцээнийг 2 үе шатаар хасагдах журмаар явуулж 2 дугаар шатанд шалгарсан 3 баг тойргийн журмаар мэтгэлцэн дүнг гаргахад тэргүүн байрыг Цагдаагийн сургуулийн “Соёмбо” баг /с/ч Э.Дашням, с/ч А.Дүүрэнжаргал/, 2-р байрт ШШГС-ийн “Victory” баг /т/ч М.Мягмарсүрэн, с/ч С.Бямба-Эрдэнэ/, 3-р байрт Цагдаагийн сургуулийн “Сүлд” баг /с/ч Б.Сумъяабазар, с/ч Б.Түмэннасан/ тус тус шалгарч Өргөмжлөл, Баянзүрх дүүргийн 50 жилийн ойн дурсгалын зүйлсээр шагнагдсан.

Тэмцээний шүүгчээр ХСИС-ийн Сургалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, доктор, ахмад Г.Хишигтогтох, Соёл олон нийт, хамтын ажиллагааны албаны дарга, дэд хурандаа Б.Энхболд, Эрх зүй, нийгмийн ухааны сургуулийн ахлах багш, ахмад Х.Оюунбаатар нар ажиллаж амжилттай өндөрлөсөн.



Н.ГАНТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захирал, хууль зүйн ухааны доктор, профессор, хурандаа
gantulga.n@leu.gov.mn

ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ ТОГТОЛЦООНЫ ПАРАДИГМ

Түлхүүр үг

Хорих ял, хоригдол (ялтан, хоригдогч), хорих ял эдлүүлэх (засан хүмүүжүүлэх) байгууллага, Хүний эрхийн билль, олон улсын гэрээ, олон улсын стандарт, хорих ял эдлэх нөхцөл, ялтныг нийгэмшүүлэх ажиллагаа, парадигм зэрэг.

Оршил

Энэ сэдвээр илтгэл хэлэлцүүлэх олон шалтгаан байгаагийн нэг нь хорих ял хүний үндсэн эрхийг хамгийн ихээр хөнддөг, мөн энэ ялыг эдлүүлэх явцад багагүй бэрхшээл, цөөнгүй зөрчил дутагдал гардаг байдлыг харгалзан улс орны бодит амьдралыг “**нийтийн үйлчилгээний болон хорих газар**”-аар шинжиж болно гэсэн олон улсын судлаачдын зөвлөмжийг удирдлага болгосонтой холбон ойлгож болно.

Илтгэл удирдтгал, үндсэн хэсэг, дүгнэлт-санал гэсэн бүтэцтэй.

УДИРТГАЛ

Монгол Улс 1961 онд НҮБ-д бүрэн эрхт гишүүнээр элссэн, 1988 онд Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенцид нэгдэн орсноор “**pacta sunt**

servanda”-г олон улсын болон үндэсний эрх зүйн зохицуулалтын нэг гол зарчим-хэм хэмжээ мөн гэдгийг **дахин** дэлхий дахинаа албан ёсоор нотолсон хууль зүйн үйл явдал болсон.

Мөн энэ хэм хэмжээг 1992 онд эрх зүйн хамгийн дээд хүчин чадал бүхий барим бичиг Үндсэн хуульдаа [1] хуульчлан бататгасан нь гадаадын орон, олон улсын байгууллагаас манай улсад хандах, манай улстай харилцах хамтын ажиллагааг өргөжүүлэх итгэлцлийн гүүр болсон.

Өнөөдөр Монгол Улс НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “**Хүний эрхийн билл**” гэж нэрлэдэг Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай, Нийгэм, эдийн засаг, соёлын эрхийн тухай олон улсын пактууд, шүүх эрх мэдлийн салбарын 30 гаруй олон улсын олон талт гэрээнд нэгдэн орж[2] дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж байна.

XX-XXI зуун **өмнөх** зуунуудаас цөөнгүй онцлох үйл явдлаар ялгардаг ба эдгээрт хүний эрхийн үзэл санаа, эрх зүйн зохицуулалт, шүүх, хууль зүйн практикийн хөгжил дэвшил, хүний эрхийн салбарын хамтын ажиллагааны үр дүн онцгой байрыг эзэлдэг.

Мөн энэ цаг үед глобальчлал, обьектив, субьектив бусад хүчин зүйлсийн улмаас гэмт хэргийн[3] аюул занал, хор уршиг нь хувь хүн, өрх гэр, улс орон төдийгүй дэлхий дахинаа нөлөөлж буйг тодотгохын зэрэгцээ шударга ёсыг тогтоох хүрээнд *нэг талаас* нийгэм, хохирогчийн, *нөгөө талаас* гэмт хэрэгтэн, ял эдлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах эрх зүйн механизмыг төгөлдөршүүлэх, тэнцвэртэй, зохистой орчинг бүрдүүлэх явдал улс орон, олон улсын байгууллагын анхаарлыг улам бүр татаж, энэ нь хамтын ажиллагааны тэргүүлэх чиглэл, өргөн талбар болсоор байна.

Иймээс миний бие “Хорих ял эдлүүлэх ажиллагаа” буюу “Хоригдолтой харьцах олон улсын стандарт[4]” манай орны төрийн бодлого, хууль тогтоомж, цаашдын төсөөлөлд хэрхэн бэхжин илэрхийллээ олсон талаарх өөрийн хийсэн хэсэгчлэн судалгааны [5] үр дүн, дүгнэлтийг танилцуулан цаашид үндэсний эрх зүйн механизмыг төгөлдөршүүлж зохистой орчин бүрдүүлэхэд нэн түрүүнд хууль тогтоомж, хууль зүйн практикт юу хийх шаардлагатай вэ гэсэн өнцгөөс зорилгоо харж илтгэлээ бэлтгэн байр сууриа илэрхийлллээ.

ҮНДСЭН ХЭСЭГ

Манай улсын хууль тогтоомж, шүүхийн болон хууль зүйн практик,

---

[1] 10-р зүйлийн 2 хэсэг “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, 10-р зүйлийн 3 хэсэг “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” //Төрийн мэдээлэл. УБ 1992 №01

[2] www.Legalinfo.mn; www.parlament.mn; www.mfa.gov.mn

[3] Ялангуяа хил дамнасан зохион байгуулалттай гэмт явдал

[4] Олон улсын хэмжээнд хорих ял эдлүүлэх ажиллагаа, хоригдолтой харьцах стандартыг нэг ойлголт гэж үздэг.

[5] Энэхүү судалгаанд эрх зүйн баримт бичиг, хууль зүйн практик, мэдээ мэдээлэлд дүн шинжилгээ хийх, харьцуулах, биечлэн сурвалжлах, фокус ярилцлага, ажиглалт хийх зэрэг аргыг голлон ашигласан.

судалгааны бусад эх сурвалж-материалуудад тулгуурлан шинэ цаг үеийн эрх зүйн хөгжлийн 1920-1980-аад оны гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн ялын ба ял эдлүүлэх ажиллагааны төрийн бодлого дараах үзэл санаа, практикт тулгуурлан хэрэгжиж байсныг тодотгож байна. Энэ нь:

1) Гэмт хэрэг бол буурай болон капиталист орнуудын нийгмийн үзэгдэл тул түүнийг бүрэн арилгах зорилт;

2) Эрүүгийн хариуцлага, ял нь “цээрлэлд тулгуурласан ял эдлүүлэх хугацааны болон түүнийг эдэлсний дараах эрхийн хязгаарлалтаар хэрэгжих үзэл санаа”;

3) Гэмт хэрэгтэй хийх тэмцэл илүүтэйгээр улс орны дотоодын асуудал тул салбарын хууль тогтоомжийг эхний ээлжинд хууль хэрэглэгчдэд хүргэх [6] , холбогдох харилцааг эрх зүйн дэд актуудын түвшинд [7] хэм хэмжээ тогтоон [8] нарийвчлан журамлан зохицуулах хууль зүйн практик;

4) Ялтныг хүмүүжүүлэх /засан хүмүүжүүлэх, дахин хүмүүжүүлэх/;

5) Ялтны хөдөлмөрийг улс ардын аж ахуй, үйлдвэрлэлийн төлөвлөгөөг биелүүлж “эдийн засгийн ашиг олох” арга хэрэгсэл болгон ашиглах практик мөн.

Тэгвэл 1980-аад оны сүүлчээс манай оронд өрнөсөн ардчилсан хөдөлгөөний үр дүн болон батласан 1992 оны Үндсэн хуульд “... *эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлоон хөгжүүлэх нь манай ард түмний эрхэм зорилго*” гэж хуульчлан тунхагласантай уялдан энэ үеэс **салбарын бодлогыг “үзэл баримтлал”**-ын хувьд үндсээр нь өөрчлөн, хууль тогтоомжийг шинэчилэх ажил эхэлж өнөөг хүртэл үргэлжилсээр байгаа ба хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах төрийн өнөөгийн бодлогоос онцолвол:

1) Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх[9];

2) Хоригдогчийг *хуульд заасан шаардлага,* олон улсын стандарт, жишигт нийцсэн нөхцөлд ял эдлүүлэх[10];

3) Ялтныг нийгэмшүүлэх [11] зорилтууд тус тус болно.

---

[6] Тухайлбал: БНМАУ-ын Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн 1966 оны хуулийг Ардын их хурлын тэргүүлэгчид нууцын зэрэглэлээр батлсан. //А.Лхагва “Монгол Улсын Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын эх сурвалж (уламжлал шинэчлэл)” УБ. 2013, 61-р тал

[7] ДЯЯ-ны, НАХЯ-ны сайд, УЦСЕГ-ын, Засан хүмүүжүүлэх байгууллага, Хорих ангиудыг удирдах газрын дарга нарын дангаар болон хамтран батлсан тушаалаар голлон журамлаж байсан.

[8] Хуулийн агуулгыг эрх зүйн дэд актын түвшинд өргөжүүлэн “хэм хэмжээ” тогтоох практик өргөн дэлгэр байсан.

[9] УИХ-ын 2008 оны 35-р тогтоолоор батлсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.2.11, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 193-р тогтоолоор батлсан “Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй болон хаалттай тогтолцоонд шилжүүлэх хөтөлбөр”

[10] Дурдсан УИХ, Засгийн газрын тогтоолууд болон ХЗДХ-ийн сайдын 2009 оны “Хөгжлийн стратеги, хөтөлбөр батлах тухай” 156-р тушаалын нэгдүгээр хавсралтын 3.5 хэсэг

[11] ХЗДХ-ийн сайдын 2009 оны “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөр батлах тухай” 198-р тушаал, ШШГЕГ-ын даргын 2009 оны “Ялтныг нийгэмшүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” А/91-р тушаал

ОУЭЗ-н эх сурвалжийн тогтолцоонд тулгуурлан өнөөдөр хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах “төрөлжсөн” дараах олон талт гэрээний актууд үйлчилж байгааг тодотгож байна. Энэ нь:

1) Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмүүд[12]”;

2) Хоригдлуудтай харьцах үндсэн зарчмууд[13];

3) Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц[14];

4) НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрэм /журам/[15];

5) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг конвенц[16];

6) НҮБ-ын Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх байцаан шийтгэх ажиллагаа явуулах наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/[17];

7) гэрээний бусад актууд болно.

Хэдийгээр олон улсын гэрээний[18] заалт нь “хэм хэмжээ”, “зарчим”, “зөвлөмж”-ийн хэлбэрээр батлагдаж “онол”-ын хувьд хууль зүйн янз бүрийн үр дагаврыг илэрхийлэх боломжтой боловч нэрлэсэн гэрээнүүдийн заалтуудыг “салбарын олон улсын стандарт” гэж дагаж мөрдөхөөр зөвшөөрөн, хэрэгжүүлэх практик баттай тогтсоор байна[19].

Иймд олон улсын стандартуудыг олон улсын эрх зүйн субьектуудын хамтын ажиллагаа, харилцан итгэлцэл, түүхэн хөгжлийн ололт амжилт, нийтээр хүлээн зөвшөөрсөн, тэргүүлэх үзэл санааны үр дүн, илэрхийлэл,

---

[12]Энэ баримт бичгийг 1955 онд Женев хотноо хуралдсан НҮБ-ын “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгдсдэд хандах асуудлаарх 1-р их хурлаар баталж. НҮБ-ын Эдийн засаг, Нийгмийн зөвлөлийн 1957 оны 663 С(XXIY), 1977 оны 2076 (LXII) тогтоолоор сайшаасан. Манай орны хувд энэ баримт бичгийг НҮБ-ын Хүний эрхийн төвөөс Монгол Улсад хүний эрхийн асуудлаар хэрэгжүүлж буй төслийн хүрээнд монгол хэлнээ “Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх” УБ.1996 он эмхэтгэлд хөрвүүлэн нийтлэсэн. Тайлбар эмхэтгэлд дурдсанаар түүнийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид орчуулж П.Эрдэнэбаяр хянан тохиолдуулжээ. Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмүүд нь англи хэлнээ “*Standard Minimum Rules for the Treatment of Prisoners*”, орос хэлнээ “*Минимальные стандартные правила обращения с заключенными*” гэж бичигддэг. //www.un.org/ru

[13] НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 44/111-р тогтоолоор баталсан. //дурдсан эмхэтгэл

[14] НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1988 оны 43/173-р тогтоолоор баталсан. //дурдсан эмхэтгэл

[15] НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1990 оны 45/113-р тогтоолоор баталсан. //дурдсан эмхэтгэл

[16]НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1984 оны 39/46-р тогтоолоор гарын үсэг зурах, батламжлах, нэгдэн ороход нээлттэйгээр баталсан ба 1987 оны 06-р сарын 26-аас хүчин төгөлдөр болсон. Монгол Улс энэ конвенцид 2000 оны 11-р сарын 02-ны өдөр нэгдэн орсон. //Төрийн мэдээлэл тусгай дугаар 1-р боть, 2004 он

[17] НҮБ-ын “Гэмт хэргээс урьчилан сэргийлэх ба эрх зүйн зөрчил үйлдэгдсдэд хандах асуудлаарх 7-р их хурлаас өргөн барьж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 40/33 тогтоолоор баталсан.

[18] Хэлэлцээр, протокол, пакт, конвенц, гэрээ, тунхаглал, журам, дүрэм зэрэг.

[19] II Международный пенитенциарный форум “Преступление, наказание, исправление” (к 60-летию принятия Минимальных стандартных правил обращения с заключенными и 30-летию принятия Минимальных стандартных правил, касающиеся отправления правосудия в отношении несовершеннолетних). Сборник тезисов вступлений и докладов участников. Том.1, 2. Материалы пленарного заседания. Рязань.2015

зайлшгүй биелүүлэх шаардлага гэж тодорхойлж болох бөгөөд ял оногдуулах, **ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах стандартын онцлог** нь ялын бодлогыг либеральчлах, хүмүүнлэг болгох, хүн төрөлхтөний үнэт зүйлсийг эрхэмлэх, хүний эрхийг дээдлэх, ял, ял эдлүүлэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд улс гүрнүүдийн бодлого, эрх зүйн журам, арга хэрэгсэл, үйл ажиллагааг нийцүүлэн хэрэгжүүлэх нэгдмэл үзэл санаа, хүсэл тэмүүлэлд захирагдаж байна хэмээн хэлж болно.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны стандартыг олон улсын гэрээний актуудын хууль зүйн техник, энэ харилцааны үе шат, зохион байгуулалт, төрөл, хэлбэр зэрэг онцлогт нь тулгуурлан тодорхой “институци”-ээр зааглан үздэг ба “зарим стандарт”-тай холбогдсон асуудлыг авч үзье.

А. **Хорих ялын зорилго**

Манай улсын **Эрүүгийн хуулийн** 45-р зүйлийн 45.3 хэсэгт “**Эрүүгийн хариуцлагын зорилго нь** иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг **цээрлүүлэх, хүмүүжүүлэх,** гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино”;

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 5.1-р зүйлийн 1-р хэсэгт “**Ялын зорилго нь** гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг **цээрлүүлэх**, гэмт хэргийн улмаас хөндөгдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, **гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэхэд** оршино”;

ШШГТХ-ийн 8-р зүйл, ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн 8-р зүйлийн 8.2 хэсэгт “**Хорих ял эдлүүлэх талаар хорих байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт ... ялтанд хүмүүжлийн нөлөө үзүүлэх**” үүрэг тус тусгагджээ.

Эндээс үзвэл манай орны **эрүүгийн хариуцлагын тогтолцоонд “цээрлүүлэх”** чиг үүрэг ялын зорилгын жагсаалтын 3-рт, “хүмүүжүүлэх” 4-рт, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг 5-рт эрэмблэгдсэн бол, ЭХ-ийн **шинэчилсэн найруулгад** ялын зорилгын **1-рт “цээрлүүлэх”**, 5-рт “гэмт хэрэг үйлдсэн хүнийг дахин нийгэмшүүлэх” хэмээн заажээ.

Тэгвэл “**Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм**”-ийн II хэсгийн

-57-р зүйлд “Хууль зөрчигчийг нийгэм, орчны хүрээнээс тусгаарлаж байгаа **хорих болон бусад арга хэмжээнүүд нь хүний өөрийн амьдралын хэм хэмжээг тогтоох эрхийг**[20] **хасч, эрх чөлөөгүй болгодгоороо зохих цээрлэлийг үзүүлдэг**. Иймээс хорих тогтолцоо нь энд журамласнаас бусад байдлаар хүндрүүлэн зовоох үйл ажиллагаа явуулах ёсгүй”

-58-р зүйлд “... шоронд **хорих** буюу эрх чөлөөг хасах **ялын эцсийн**

[20] Илтгэгч англи хэлний “right of self-determination”, орос хэлний “право человека на самоопределение” гэснийг “Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх” УБ.1996 он эмхэтгэлд “хүний өөрийгөө мэдэх эрх” гэж орчуулсныг ийнхүү өөрчлөн томьеолж ашиглах саналыг дэвшүүлж байгаа.

зорилго нь нийгмийг хамгаалах, нийгэмд аюултай гэмт хэргүүдийг арилгах, урьдчилан сэргийлэх явдал бөгөөд түүнд **хүрэх нөхцөл нь** гэмт хэрэгтэн хорих ялыг эдэлж нийгмийн жирийн амьдралд шилжихэд **эрх зүйн журамд захирагдаж, өөрийн амьдралыг авч явах чадвар, дадал хэвшилтэй болсон байх явдал мөн**” гэжээ.

Өөрөөр хэлбэл олон улсын стандартын шаардлагын үүднээс авч үзвэл эрүүгийн хариуцлага, ялын тогтолцоонд “**цээрлүүлэх”** тусгай чиг үүргийн тухай бус, харин нийгмийг хамгаалах, гэмт явдлыг урьдчилан сэргийлэх нь түүний **эрхэм зорилго** ба үүнд хүрэх үндсэн нөхцөлийг “**ялтныг өөрчлөн нийгэмшүүлэх**” гэснийг бид онцгойлон анхаарах ёстой.

Б. Хорих ял эдлэгсдийн ангилал, хорих байгууллагын төрөл

Манай орны хувьд ЭХ, ШШГТХ-ийн хэм хэмжээг хэрэглэн хорих ялаар шийтгүүлэгчдийг:

-тэдний үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, өмнө нь хорих ял эдэлж байсан эсэхэд **тулгуурласан** гэмт хэргийн ангилал[21],

-мөн ял эдлэгчийн нас, хүйс[22]; эрүүл мэндийн байдал[23]; зан төлөв, үйлдсэн гэмт хэргийн зарим шинжийг[24] харгалзан хорих нөхцлөөр ялгарах жирийн, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гянданд, эсхүл ижил дэглэмийн хорих ангид тусгаарлан[25] ял эдлүүлж байна.

Харин салбарын хуулийн[26] шинэчилсэн найруулгын төсөлд:

-хорих байгууллага нь сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага, насанд хүрэгчдийн нээлттэй, хаалттай хорих анги */болон цагдан хорих төв, орон нутгийн цагдан хорих байр, мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв/*-аас бүрдэх[27];

-харуул хамгаалалтын түвшингээр нээлттэй хорих анги “Б”, “В”, хаалттай хорих анги “А”, “Б”, “В” зэрэглэлээр төрөлжихөөр тусгагджээ[28].

Тэгвэл энэ харилцаанд баримталдаг **олон улсын стандартаас дурдвал:**

Хоригдлыг ангилан тусгаарлахын зорилго нь: а/ бие биедээ сөрөг муу нөлөө үзүүлэхээс сэргийлэх, б/ тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулах хоригдолтой ажиллах ажлыг хөнгөвчлөх явдал мөн[29].

1) Насанд хүрээгүй хорих ял эдлэгчийг төрөл бүлэгт хуваах үндсэн

---

[21] ЭХ-ийн 52-р зүйлийн 52.4, 52.5, 52.6, 52.7, 52.8, 52.9, 52.10, 52.11 хэсэг.

[22] ШШГТХ-ийн 118-р зүйлийн 118.1 хэсэг. Насанд хүрээгүй болон эмэгтэй, эрэгтэй ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ.

[23] Мөн хуулийн 118-р зүйлийн 118.2 хэсэг. Ил хэлбэрийн сүрьеэ өвчтэй, дархлалын олдмол хомсдол өвчнөөр халдварласан, өвчилсөн ялтныг бусад ялтнаас тусгаарлан ял эдлүүлнэ. 111-р зүйлийн 111.2 хэсэг. Жирэмсэн ... эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна.

[24] Мөн хуулийн 118-р зүйлийн 118.3 хэсэг. “Ижил дэглэмтэй хорих ангид анх удаа ял эдэлж байгаа ялтныг давтан гэмт хэрэг үйлдсэн ялтнаас, засарч хүмүүжиж байгаа ялтныг засрал олохгүй байгаа ялтнаас, түүнчлэн эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн ялтныг тус тусад нь ял эдлүүлнэ”

[25] Мөн зүйл хэсэг.

[26] Цаашид зарим газар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг ийнхүү нэрлэн бичнэ.

[27] Төслийн 104-р зүйлийн 104.1 хэсэг

[28] Төслийн 106-р зүйлийн 106.1 хэсэг, 107-р зүйлийн 107.1 хэсэг

[29] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 67-р зүйл

шалгуур нь тэдэнд үзүүлэх асрамж, онцлог хэрэгцээнд хамгийн ихээр нийцэж бие бялдрын, сэтгэл зүйн, ёс суртахууны төлөвшил, сайн сайхныг хамгаалах явдал байх ёстой[30].

2) Насанд хүрээгүй хүмүүсийн хувьд нээлттэй засан хүмүүжүүлэх газар байгуулвал зохино. Аюулгүй байдлын арга хэмжээ байхгүй юм уу, тодорхой хэмжээгээр хязгаарлагдсан байгууллагыг нээлттэй засан хүмүүжүүлэх газар гэнэ[31]. Насанд хүрээгүй хүмүүсийн засан хүмүүжүүлэх байгууллага нь төвлөрсөн бус, насанд хүрээгүй хүмүүс ба тэдний гэр бүлийн хоорондын холбоо хэлхээг тасалдуулахгүй байх хэмжээнд байна[32].

В. Хорих ял эдлэх нөхцөл, ялтны бусадтай уулзах, харилцах, хорих байгууллагаас гадна зорчих журам

Манай салбарын хуульд ялтны хорих ял эдлэх нөхцөл, бусадтай хийх түр, удаан хугацааны уулзалт, илгээмж авах, утсаар ярих, захидал илгээх тоо, хугацаа, чөлөөгөөр гарах, харуул хамгаалалтгүй ажиллах эрх нь хорих ангийн дэглэм, төрөл[33] ”, хорих ял эдэлсэн хугацаанаас[34], хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд[35] хорих ангийн харуул хамгаалалтын зэрэглэл, төрлөөс хамаарч ялгамжтай байдлаар туссан.

Тэгвэл судлаач **олон улсын дараах стандартыг** онцолж байна.

1) Хоригдлыг ял эдэлж эхлэх үеэс түүний ирээдүйн талаар бодох ёстой. Иймээс хоригдлыг ял эдэлж дуусаад суллагдсаны дараа түүнийг нийгмийн амьдралд татан оролцуулах, гэр бүлийн ашиг сонирхолыг хамгаалах хувь хүмүүс, албан газар, нэгжтэй харилцаа холбоо тогтоон бэхжүүлэхэд туслалцаа үзүүлнэ[36].

2) Хоригдлуудтай харилцахдаа нийгмээс тусгаардлагдсан байдлыг бус харин нийгмийн гишүүн хэвээр байгаа гэдгийг тодотгож харьцах хэрэгтэй. Үүний тулд тэднийг нийгмийн амьдралд буцаан оруулах зорилгоор олон нийтийн байгууллагуудын бүх боломжийг ашиглах, тус хорих газрын ажилтай холбож, хамтын ажиллагааг тогтоох хэрэгтэй[37].

3) Хоригдол, түүний гэр бүлийн хоорондын харилцааг бэхжүүлэхэд онцгой анхаарал тавина[38].

4) Эрх бүхий байгууллагууд хоригдож байгаа насанд хүрээгүй хүмүүс орон нутгийн оршин суугчидтай чөлөөтэй харилцах явдлыг

---

[30] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 28-р зүйл //Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дах хүний эрх. УБ, 1996 он, 45-46-р тал.

[31] Мөн дүрмийн 30-р зүйл

[32] Мөн дүрмийн 30-р зүйл

[33] Тус хуулийн 107-р зүйл. Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги; 108-р зүйл. Чанга, онцгой дэглэмтэй хорих анги; 109-р зүйл. Гяндан; 110-р зүйл. Насанд хүрээгүй ялтныг ял эдлүүлэх; 111-р зүйл. Эмэгтэй ялтныг ял эдлүүлэх; 119-р зүйл. Ялтан бусадтай уулзах, харилцах.

[34] Тус хуулийн 122-р зүйл. Ялтныг харуул хамгаалалтгүй ажиллуулах.

[35] Төслийн 106-р зүйл. Нээлттэй хорих анги; 107-р зүйл. Хаалттай хорих анги; 108-р зүйл. Харуул хамгаалалтын “А” зэрэглэлд ял эдлүүлэх; 109-р зүйл. Өсвөр насны ялтныг ял эдлүүлэх; 110-р зүйл. Эмэгтэй ялтныг ял эдлүүлэх;

[36] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 80-р зүйл

[37] Дурдсан жишиг дүрмийн 61-р зүйл

[38] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 79-р зүйл

урамшуулах талаар идэвхтэй арга хэмжээг авч хэрэгжүүлвэл зохино[39].

5) Насанд хүрээгүй хүнийг гадна орчинтой холбох бүх арга хэрэгслийг аль болох бүрэн ашиглах нь түүнтэй шударга, хүнлэг ёсоор харилцах эрхийг нь хэрэгжүүлж, түүнийг нийгэмд эргүүлэн оруулах бэлтгэлийг хангахад чухал ач холбогдолтой. Насанд хүрээгүй хүмүүсийг гэр бүл, найз нөхөд, сайн нөлөө үзүүлж болох байгууллагын төлөөлөгчид, бусад хүмүүстэй уулзуулах, гэрт нь чөлөөгөөр явуулах, ерөнхий болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, бусад чухал зорилгоор засан хүмүүжүүлэх байгууллагаас гадагш гарахыг зөвшөөрч байвал зохино[40].

Г. Ялтнуудад мэдээлэл өгөх, тэдний гомдол гаргах эрх

ШШГТХ, Хорих ангийн дотоод жура[41], салбарын хуулийн шинэчилэн найруулгын төсөлд: “... ялтан шүүхээс оногдуулсан ял эдлэх нөхцөл, журам болон өөрийнхөө эрх, үүрэг, хязгаарлалтын талаар мэдээлэл авах, өөрт холбогдох[42] болон хорих ангийн үйл ажиллагаа, албан хаагчдын харилцааны талаар [43] байгууллагын захиргаа, аль ч байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, хүсэлт гаргах эрхтэй”, “хорих байгууллагын ажилтан хоригдогч ангийн хориотой бүс, ялтны эрх, үүргийн талаар танилцуулах ажлыг зохион байгуулах[44] үүрэг хүлээх”-ээр туссан.

Иймд судлаач энэ харилцаанд хамаарах **олон улсын** дараах **стандартуудыг** онцолж байна.

1) Хоригдол бүрийг хорих газар хүлээн авахдаа тухайн төрлийн хоригдлуудтай харилцах журам, сахилгын шаардлага, мэдээлэл авах зөвшөөрсөн хэрэгсэл, гомдол гаргах журам болон өөрийн эрх, үүргээ мэдэх, амьдралын нөхцөлд дасахтай холбогдсон бусад асуудлаарх **мэдээллийг бичгээр өгнө**[45]; бичиг үсэг мэддэггүй хоригдолд амаар танилцуулна.

2) Хоригдол бүр **шоронгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад** хүсэлт, өргөдлөө гаргах боломжтой байх ёстой бөгөөд **тэдгээрийг агуулгын талаас хянахгүйгээр** зохих хэлбэрийн дагуу бүрдүүлж тогтоосон журмаар шоронгийн төв захиргаа, шүүх болон бусад эрх бүхий байгууллагад хүргэж байвал зохино.

3) Засан хүмүүжүүлэх байгууллагад байрласны дараа насанд хүрээгүй хүн бүрт тус байгууллагад байх журам, эрх, үүргийн бичмэл танилцуулга, гомдол гаргах бүрэн эрх бүхий байгууллага, мөн хууль зүйн туслалцаа үзүүлэх төрийн, хувийн байгууллагын хаягийг өгөх ёстой. Бичиг үсэг үл мэдэх буюу зохих хэлээр уншиж чадахгүй насанд хүрээгүй

---

[39] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 8-р зүйл

[40] Дурдсан жишиг дүрмийн 59-р зүйл

[41] Хууль зүйн сайдын 2014 оны “Журам шинэчилэн батлах тухай” А/230-р тушаал /Хорих ангийн дотоод журам/

[42] Дурдсан хуулийн 115-р зүйлийн 115.1.2

[43] Хорих ангийн дотоод журмын 14.1 хэсэг /Энэ хэм хэмжээ ШШГТХ-д тусгагдаагүй болно/

[44] Мөн журмын 2.8.1

[45] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 35.1-р зүйл

хүмүүст мэдээллийг бүрэн ойлгох боломжийг хангасан хэлбэрээр өгнө[46].

4) Хоригдлуудад хамгийн чухал мэдээг сонин, сэтгүүл, шоронгийн тусгай хэвлэлийг унших, радио сонсох, лекцэнд суух болон захиргаанаас зөвшөөрч хянагддаг аливаа хэрэгслийг ашиглах замаар хүргэж байвал зохино[47].

Д. Ялтны хөдөлмөр

ШШГТХ, салбарын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ялтны энэ харилцаатай холбоотой дараах зохицуулалт бий.

1) Хорих байгууллага ялтныг албадан хөдөлмөрлүүлж, эрхэлсэн үйлдвэрлэлийн чиглэлээр түүнд дадлага олгоно[48]. Хуулийн төслийн 8-р зүйлийн 8.2.4-д “**албадан**” гэсэн үгийг энэ хэм хэмжээнээс хассан.

2) Ялтан эрх бүхий албан тушаалтнаас даалгасан ажлыг заавал гүйцэтгэх үүрэг хүлээнэ[49].

3) Чанга, онцгой дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цагийг хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас өөрөөр тогтоож болно[50]. (Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.7-д энэ зохицуулалтыг хаалттай хорих ангид ял эдлэгсдэд хамруулсан)

4) Насанд хүрээгүй болон жирийн дэглэмтэй хорих ангийн ялтны ажил, амралтын цаг нь хөдөлмөрийн хуультай нийцсэн байна[51]. (Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.2-т нээлттэй хорих ангийн ялтанд энэ хэм хэмжээг хамруулсан)

5) Ялтнаар ажил хийлгэхдээ түүний мэргэжил, хөдөлмөрийн чадварыг харгалзах боловч мэргэжлийн ажил байхгүй нь түүнийг хөдөлмөрөөс чөлөөлөх үндэслэл болохгүй[52].

Тэгвэл ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбогдсон **олон улсын стандартын** дараах шаардлагыг дурдья.

1) Хоригдлыг ажлаар хангах нь юуны өмнө тэднийг хорих газраас суллагдсаны дараа шударга хөдөлмөр эрхлэхэд туслах, ур чадварыг бий болгох, дээшлүүлэхэд оршино[53].

2) Шоронгийн нөхцөлд үйлдвэрлэл явуулж ашиг олох явдалд хоригдлын сонирхол, мэргэжлийн сургалтыг захируулж болохгүй[54].

3) Ажлын цагийг долоо хоногт нэг удаа амралтын өдөртэй байхаар зохион байгуулах ба энэ нь хоригдлыг дахин хүмүүжүүлэх, сурах болон бусад ажиллагаа эрхлүүлэхэд зориулагдана[55].

4) Хэрэв боломжтой бол насанд хүрээгүй хүмүүсийг мэргэжлийн сургалттай нь холбоотой тухайн орон нутагт цалин хөлстэй ажил хийлгэх бололцоо олгож суллагдсаны дараах нийгмийн амьдралд хөдөлмөр эрхлэх

---

[46] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 24-р зүйл

[47] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 39-р зүйл

[48] Хуулийн 8-р зүйлийн 8.2.4; 125-р зүйлийн 125.3; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.4-т өнөөгийн хуулийн 125-р зүйлийн 125.3 хэсэгтэй адил зохицуулалт туссан.

[49] Хуулийн 115-р зүйлийн 115.2.2; Хуулийн төслийн 114-р зүйлийн 114.2.2

[50] Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.7

[51] Хуулийн 120-р зүйлийн 120.2

[52] Хуулийн 120-р зүйлийн 120.3; Хуулийн төслийн 119-р зүйлийн 119.3

[53] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 71.4

[54] Дурдсан жишиг дүрмийн 72.2

[55] Дурдсан жишиг дүрмийн 75.2

боломж нөхцөлийг нь нэмэгдүүлэх ёстой[56].

Е. Боловсрол ба сургалт

ШШГТХ, хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд ялтны сургалт, түүний зохион байгуулалт, боловсрол эзэмшихтэй холбогдсон дараах зохицуулалт бий.

1) Насанд хүрээгүй ялтныг ерөнхий боловсролын сургалтад бүрэн хамруулж, бусад ялтан бие дааж мэдлэгээ дээшлүүлэхэд хорих анги туслалцаа үзүүлнэ[57].

2) Боловсролын сургалтыг зөвхөн хорих ангийн байранд зохион байгуулна[58].

3) Хөдөлмөрийн дадлага олгох сургалтад ялтныг сайн дурын үндсэн дээр хамруулна[59].

Тэгвэл **олон улсын зарим стандартыг** онцолбол:

1) Бичиг үсэггүй буюу залуу хоригдлуудыг сургалтад **заавал** хамруулах ба үүнд хорих газар онцгой анхаарал тавих ёстой[60].

2) Заавал сурах сургалтын насны хүүхэд бүр өөрийнхөө хэрэгцээ, чадварт тохирсон, нийгэмд эргэж орох бэлтгэл хангах боловсрол эзэмших эрхтэй. Ийм боловсролыг аль болохоор **засан хүмүүжүүлэх газраас гадуур ердийн сургуулиар олгох**[61].

3) Заавал сургах сургалтын нас хэтэрсэн боловч боловсрол олох ажлаа үргэлжлүүлэх хүсэлтэй насанд хүрээгүй хүмүүст ийм боломж олгон хөхүүлэн дэмжиж, сургалтын зохих хөтөлбөрөөр хангах боломж бүхнийг ашиглавал зохино[62].

Ё. Урамшуулал, сахилгын шийтгэл

Хорих ял эдлэгсдэд үзүүлэх урамшуулал, сахилгын шийтгэлийн үндэсний тогтолцоо, механизмд социализмын үеийн үзэл санаа, хандлага бусад институцитэй харьцуулахад илүү бат бөх өнөөг хүртэл хадгалагдаж байгаагийн зэрэгцээ салбарын хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд **сахилгын шийтгэлийн журмаар ялтны сар, улирал, жилд авах түр болон удаан хугацааны уулзалтын тоог бууруулах**[63]” зохицуулалт тусжээ.

Тэгвэл энэ харилцааны олон улсын зарим стандартыг дурдвал:

1) Хоригдлыг тухайн хорих газрын үйлчилгээнд сахилгын арга хэмжээ болгон ажиллуулж болохгүй[64].

2) Ямар ч тохиолдолд хоол ундыг хасах, гэр бүлийн гишүүдтэйгээ уулзахыг хязгаарлах буюу хориглох явдал байж болохгүй. Хөдөлмөр эрхлэх нь насанд хүрээгүй хүмүүсийг нийгмийн амьдралд буцаан ороход

---

[56] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 45-р зүйл

[57] Хуулийн 125-р зүйлийн 125.1; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.1

[58] Хуулийн 125-р зүйлийн 125.2; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.2

[59] Хуулийн 125-р зүйлийн 125.4; Хуулийн төслийн 124-р зүйлийн 124.4

[60] Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн 77.1

[61] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 38-р зүйл

[62] Дурдсан дүрмийн 39-р зүйл

[63] Төслийн 127-р зүйлийн 127.1.1

[64] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 28.1

бэлтгэх, өөрийгөө хүндэтгэж сурах арга хэрэгсэл, хүмүүжлийн арга байх ёстой бөгөөд сахилгын арга хэмжээ болгон хэрэглэж болохгүй. Хамт олноор нь шийтгэхийг хориглоно[65].

Ж. Ялтныг суллахад бэлтгэх, суллагдсан хүнд үзүүлэх тусгай институци

Манай орны салбарын хуульд энэ талаарх тусгайлсан зохицуулалт байхгүй. Харин энэ харилцаанд хамаарах **олон улсын дараах стандартыг** дурдаж болно.

1) Хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгмийн жирийн амьдралд аажмаар дасаж хэвших арга хэмжээнүүдийг идэвхтэй авч хэрэгжүүлбэл сайн. Энэ зорилгоор суллагдаж байгаа хоригдлуудын онцлогийг харгалзан хорих газарт эсвэл ямар нэгэн өөр байгууллагад өвөрмөц дэглэм тогтоон итгэл өгч ажиллуулж болно эсвэл цагдаагийн биш иргэний нийгмийн хяналтад зохих болзолтойгоор сорилын хугацаагаар суллаж байна[66].

2) Суллагдсан хоригдолд туслах Засгийн газрын болон бусад байгууллага нийгэмд байх ёстой. Эдгээр байгууллага нь тухайн хүмүүст орон сууц авах, ажилд орох зэрэгт нь зайлшгүй шаардлагатай бичиг баримтыг олж авах, улирлын хувцсаар хангах, очих газрын тээврийн хөлс болон тодорхой хугацаанд хүрэлцэхүйц мөнгө олгоно. Эдгээр байгууллагын эрх бүхий төлөөлөгчид хорих ангид ирж хоригдолтой уулзаж түүний ирээдүйн амьдралын талаар зөвлөж байвал зохино[67].

3. Бусад

Эдгээрээс гадна:

-Хоригдлын өрөө тасалгаа; Хувийн ариун цэвэр;

-Хувцас, унтлагын хэрэгсэл; Хоол унд;

-Эмнэлгийн үйлчилгээ; Хоригдлын эд зүйлийг хадгалах;

-Номхруулах хэрэгсэл;

-Шашин шүтлэг;

-Хоригдлыг шилжүүлэх, Нас барсан, өвчилсөн, өөр газарт шилжсэн талаар мэдэгдэх;

-Хорих ангийн албан хаагч;

-Хяналт шалгалт зэрэг “институци”-ээр төрөлжсөн бусад стандартууд байдгыг бас дурдах ёстой.

ДҮГНЭЛТ

1. Гэмт хэрэгтэй тэмцэх салбарын манай орны хууль тогтоомжийн энэ цаг үеийн өөрчлөлт дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны онцлогийг харгалзан хийгдэж байгааг сайшаан тодотгохын зэрэгцээ зарим тохиолдолд бид өмнөх нийгмийн[68] үзэл суртал, хандлагасаа салаагүй зууралдсаар байгааг бас анхааруулах ёстой. Тухайлбал: үүнд эрүүгийн хариуцлага, ялын “**цээрлүүлэх тусгайлсан зорилго**”, мөн хорих ял эдлүүлэх салбарын шинэчлэл хамаарна.

---

[65] НҮБ-ын Хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй хүмүүсийг хамгаалах дүрмийн 67-р зүйл

[66] Дурдсан жишиг дүрмийн 60-р зүйлийн 2 хэсэг

[67] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 81-р зүйл

[68] “Социалист”

Мөн салбарын хууль тогтоомжийн зарим хэм хэмжээ [69] “олон улсын стандарт”-ын шаардлагыг харгалзаагүй, түүнчлэн бидний олон жил чиг баримжаагаа болгон нэг тогтолцоонд хамтран ирсэн хөрш орныхоо[70] хууль тогтоомж, хууль зүйн дэвшилтэт практикийг судлаагүй, түүнд хайхрамжгүй хандаж буй байдлыг нэрлэж болно.

Иймд илтгэлийн үндсэн хэсэгт тусгаагүй зарим баримтыг тодотгон дурдвал ялтныг нийгэмшүүлэх гол нөхцөл болсон “**хорих ял эдлүүлэх дэвшилтэт тогтолцоо**[71]”, “хорих ял эдлэх харьцангуй ялгамжтай орчин нөхцөл”, “ялтны хорих байгууллагаас **гадагш зорчих**”, “**чөлөө авах**”, “ялтны **хөдөлмөрийн амралт**, цалин хөлс”, “ялтны түр, удаан хугацааны уулзалт”, “ялтны захидал харилцаа”, “ялтанд үзүүлэх урамшуулал, сахилгын шийтгэл”, түүнчлэн ял эдлүүлэх **тогтолцоог либериальчлах, нийгэм, олон нийтийн хяналтад оруулах** асуудалд бид **зарчмын өөрчлөлт хийж чадаагүй, төлөвлөөгүй байна**.

2. Олон улсын болон гадаадын орнуудын эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн шинжлэх ухаан, салбарын онолууд, хууль зүйн практикаас үзвэл өнөө үед хорих ял, хорих нөхцлийн тухай “эргэлт, уулзалт, захидал, илгээмжийн тоон хязгаарлалтад тулгуурласан” үзэл баримтлал хоцорч, “**нийгэмшүүлэх үйл ажиллагаанд захирагдсан, олон нийтийн оролцоо, дэмжлэг, хяналтад түшиглэсэн**” үзэл баримтлал салбарын хөгжлийн “**парадигм**” болсныг судлаач онцлон тодотгож байна.

САНАЛ

Иймд олон улсын стандартууд болон дараах судлаачийн саналыг ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төсөлд харгалзан үзэхийг санал болгож байна. Энэ нь:

1. Салбарын хуульд эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн дараах зарчмуудыг нэмж хуульчлан, практикт тууштай хэрэгжүүлэх:

-“ял эдлүүлэх харилцааг ялтны нийгэмшүүлэх үйл ажиллагаанд захируулах[72]”;

-“ялыг ялгамжтай эдлүүлэх[73]”;

-“ялын гүйцэтгэлийг хувь хүний онцлогтой уялдуулан бодьгалчлах[74]”;

-“албадлагын арга хэмжээний үр нөлөөг эрхэмлэх[75]”;

-“ялтны эерэг зан төлөвийг бүх талаар дэмжин урамшуулах[76]”;

-“ял эдлүүлэх ажиллагааг нийгэм, олон нийтийн оролцоо, дэмжлэг,

---

[69] ЭХ, ШШГТХ, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга, УИХ-аар хэлэлцэхээр төлөвлөж буй ШШГТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн

[70] Энэ тохиолдолд хөрш ОХУ-ыг дурдсан болно.

[71] Оросоор “прогрессивная система отбывания лишения свободы” гэж нэрлэдэг.

[72] Энэ зарчмыг “ял шийтгэлийг засан сайжруулах (засан төлөвшүүлэх) үйл ажиллагаатай холбох” буюу оросоор “принцип соединения наказания с исправительным воздействием” гэж нэрлэдэг бөгөөд судлаач үүнийг ийнхүү өөрчлөн нэрлэхээр санал болгож байна.

[73] Принцип дифференциации исполнения наказания

[74] Принцип индивуализации исполнения наказания

[75] Принцип рациального применения мер принуждения

[76] Принцип стимулирования правопослушного поведения осужденных

хяналтад түшиглэн явуулах[77]” тус тус болно.

2. Салбар эрх зүйн нэрлэсэн зарчмууд, хорих ялыг ялтны харьяалах орон нутагт эдлүүлэх үзэл санааг харгалзсан хорих ялыг ялтан “ялгамжтай нөхцөл бүхий салбар-хэсгүүдтэй[78] Засан төлөвшүүлэх[79] нэг байгууллагад[80] (**үүнийг гадаадын орнуудад “мульт” буюу “гибрид” зохион байгуулалттай**) хорих ялыг эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практикийг нарийвчлан судалж манай оронд нэвтрүүлэн “**нутагшуулах**” асуудалд судлаачид төдийгүй салбарын байгууллага, хууль тогтоогч, “хууль хэрэглэгчдийн анхаарлыг нэн даруй хандуулж шийдлийг олох.

Өөрөөр хэлбэл ялтан хорих ялыг нэг байгууллага, түүний харьцангуй ялгаа бүхий нөхцөлтэй салбар-хэсэгт зан төлөвтэйгээ уялдан **“шилжин эдлэх**[81]”зохицуулалт болно.



М.ЦЭНД
ШШГЕГ-ын Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасгийн дарга, хурандаа

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежмент, мэргэжлийн ур чадвар, ялтны хөдөлмөр эрхлэлт, гэм хорын хохирол барагдуулалт, хөдөлмөрийн нөхцөл

Хураангуй

Хорих байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, ялтныг ажлаар хангаснаар тэдний бусдад учруулсан гэм хорын хохирлыг барагдуулж, хөдөлмөрийн дадлага чадвар олгож, суллагдсаны дараа нийгэмд зөв амьдрах хэвшилтэй болгох юм. Нөгөө талаасаа тэдний ажиллах хүч, хөдөлмөрлөх чадварыг дайчлан эх орны бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулж, материаллаг баялгийг бүтээж болно.

Менежмент гэдэг нь та яг юу хийхийг хүсэж байгаагаа олж мэдээд хамгийн шилдэг хүнээр хамгийн хямдаар хийлгүүлэх урлаг юм. Ф.В.Тейлор

Аль ч улс орны оршин тогтнохын нэг үндэс бол хөдөлмөр байдаг. Учир нь хүний нийгмийн материал, соёлын

---

[77] Энэ үзэл санааг судлаач зарчмын хэмжээнд үнэлэх саналыг дэвшүүлж байна.

[78] Өнөөгийн ойлголтоор “ялгаа бүхий дэглэмтэй”

[79] Боловсролын тухай хуулийн 3.1.11-д “төлөвшил гэж суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогцыг ойлгоно” (www.meds.gov.mn) гэснийг харгалзан илтгэгч хорих ял эдлүүлэх байгууллагыг “Засан төлөвшүүлэх (сайжруулах) газар” гэж нэрлэхийг санал болгож байна.

[80] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 8-р зүйл “Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад **эсхүл 1 хорих газрын өөр өөр хэсэгт байлгана**”; ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 73-р зүйл “Хорих ял эдлүүлэх байгууллага”, 74-р зүйл “Засан хүмүүжүүлэх байгууллагын төрөл”.

[81] ОХУ-ын хорих ял эдлүүлэх практикт үүнийг “социальный лифт” гэж нэрлэдэг.

хяналтад түшиглэн явуулах[77]” тус тус болно.

2. Салбар эрх зүйн нэрлэсэн зарчмууд, хорих ялыг ялтны харьяалах орон нутагт эдлүүлэх үзэл санааг харгалзсан хорих ялыг ялтан “ялгамжтай нөхцөл бүхий салбар-хэсгүүдтэй[78] Засан төлөвшүүлэх[79] нэг байгууллагад[80] (**үүнийг гадаадын орнуудад “мульт” буюу “гибрид” зохион байгуулалттай**) хорих ялыг эдлүүлэх эрх зүйн зохицуулалт, хууль зүйн практикийг нарийвчлан судалж манай оронд нэвтрүүлэн **“нутагшуулах”** асуудалд судлаачид төдийгүй салбарын байгууллага, хууль тогтоогч, “хууль хэрэглэгчдийн анхаарлыг нэн даруй хандуулж шийдлийг олох.

Өөрөөр хэлбэл ялтан хорих ялыг нэг байгууллага, түүний харьцангуй ялгаа бүхий нөхцөлтэй салбар-хэсэгт зан төлөвтэйгээ уялдан **“шилжин эдлэх**[81]”зохицуулалт болно.



М.ЦЭНД
ШШГЕГ-ын Хууль тогтоомжийн хэрэгжилт, дотоод ажлын тасгийн дарга, хурандаа

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙН ШИНЭЧЛЭЛИЙН ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежмент, мэргэжлийн ур чадвар, ялтны хөдөлмөр эрхлэлт, гэм хорын хохирол барагдуулалт, хөдөлмөрийн нөхцөл

Хураангуй

Хорих байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, ялтныг ажлаар хангаснаар тэдний бусдад учруулсан гэм хорын хохирлыг барагдуулж, хөдөлмөрийн дадлага чадвар олгож, суллагдсаны дараа нийгэмд зөв амьдрах хэвшилтэй болгох юм. Нөгөө талаасаа тэдний ажиллах хүч, хөдөлмөрлөх чадварыг дайчлан эх орны бүтээн байгуулалтад бодитой хувь нэмэр оруулж, материаллаг баялгийг бүтээж болно.

Менежмент гэдэг нь та яг юу хийхийг хүсэж байгаагаа олж мэдээд хамгийн шилдэг хүнээр хамгийн хямдаар хийлгүүлэх урлаг юм. Ф.В.Тейлор

Аль ч улс орны оршин тогтнохын нэг үндэс бол хөдөлмөр байдаг. Учир нь хүний нийгмийн материал, соёлын

---

[77] Энэ үзэл санааг судлаач зарчмын хэмжээнд үнэлэх саналыг дэвшүүлж байна.

[78] Өнөөгийн ойлголтоор “ялгаа бүхий дэглэмтэй”

[79] Боловсролын тухай хуулийн 3.1.11-д “төлөвшил гэж суралцагчийн хүмүүжил, итгэл үнэмшлийн цогцыг ойлгоно” (www.meds.gov.mn) гэснийг харгалзан илтгэгч хорих ял эдлүүлэх байгууллагыг “Засан төлөвшүүлэх (сайжруулах) газар” гэж нэрлэхийг санал болгож байна.

[80] Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрмийн 8-р зүйл “Янз бүрийн бүлгийн хоригдлуудад хүйс, нас, урьд ял шийтгэгдэж байсан эсэх, хоригдох болсон хууль зүйн шалтгаан болон тэдэнтэй харилцах зааврыг харгалзан тусдаа хорих газруудад **эсхүл 1 хорих газрын өөр өөр хэсэгт байлгана**”; ОХУ-ын Эрүүгийн ял эдлүүлэх хуулийн 73-р зүйл “Хорих ял эдлүүлэх байгууллага”, 74-р зүйл “Засан хүмүүжүүлэх байгууллагын төрөл”.

[81] ОХУ-ын хорих ял эдлүүлэх практикт үүнийг “социальный лифт” гэж нэрлэдэг.

бүх үнэт зүйл хөдөлмөрийн үр дүнд бий болдог. Нийгмийн амьдралд хүнийг бүх талаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх, амьдрах нөхцөлийг нь дээшлүүлэх чухал хүчин зүйл нь хөдөлмөр юм.

Хөдөлмөр бол хүн төрөлхтний нэн тэргүүний үндсэн нөхцөл юм [82]. Хөдөлмөр хүмүүсийн бүх талын хөгжлийг хангах хэрэгсэл, нийгмийн амьдралыг цогцлоох хүчин зүйл болохоос гадна бусдыг хүндэтгэх, сахилга, дэг журмыг сахих, хариуцлагаа ухамсарлах зэрэг шинж чанаруудыг хүмүүст төлөвшүүлдэг.

Хорих ял эдлэгч хөдөлмөр эрхэлснээрээ бусдад учруулсан гэм хорын хохирлоо барагдуулах, өөртөө мөнгөн хуримтлал бий болгох боломж бүрддэг. Хөдөлмөр эрхлэх явцад тэдний бие махбод чийрэгжихийн зэрэгцээ гэмт үзэл бодол нь эерэгээр солигдож хүмүүжлийн төлөвшил олоход чухал нөлөө үзүүлдэг байна. Оросын алдарт сурган хүмүүжүүлэгч А.С.Макаренко “Хүн зөвхөн хамтын хөдөлмөрт оролцсоноор л бусад хүмүүст хандах ёс суртахууны төлөвшил олж авдаг” [83] гэжээ.

Хорих байгууллагын үйлдвэрлэл, ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх тухай асуудал нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежментийн анхаарвал зохих чиглэл болоод байгаа юм.

Санаатай болон санамсар болгоомжгүй байдлаар гэмт хэрэг үйлдэж, олон нийтээс тусгаарлагдан хорих ял эдэлж байгаа хүмүүсийг нийгэмшүүлэх, хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэхэд хөдөлмөрийн үр нөлөө асар их болохыг манай байгууллагын түүх харуулдаг. Хорих байгууллагын эрхлэх үйлдвэрлэлийн чиглэл, байршлыг зөв тогтоож, ялтныг ажлаар хангахад төрөөс зохих анхаарал тавьж ирсэн нь энэ чиглэлээр удаа дараа гаргаж байсан эрх зүйн актуудаас харагдаж байна. Эдгээрээс дурдвал 1929 оны 06-р сарын 14-нд Засгийн газрын 09-р хурал, Улсын бага хурлын тэргүүлэгчдийн 55 дугаар хурлаар батлсан “Аливаа хэрэгтэн ялтнаар ажил үйлдвэрлэл хийлгэх тухай дүрэм”, 1960 оны 3 дугаар сарын 2-ны өдөр БНМАУ-ын СнЗ-өөс батлсан “Засан хүмүүжүүлэх байгууллагын үйлдвэрийн чиглэлийг тогтоох тухай” 86 дугаар тогтоол, СнЗ-өөс 1967 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр батлсан “Засан хүмүүжүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай” 98 дугаар тогтоол, МАХН-ын Төв Хорооны 1980 оны 206, мөн оны СнЗ-ийн 413 дугаар тогтоол зэрэг олон эрхийн актууд гарч, ялтныг уул уурхай, мод, модон материал бэлтгэл, барилга байгууламж, барилгын материал үйлдвэрлэл, газар тариалан, зам тавих зэрэг эх орны бүтээн байгуулалтын бүх салбарт ажил хөдөлмөр эрхлүүлж, хөдөлмөрийн үр нөлөөг ялтнуудад ухамсарлуулах, нийгэмшүүлэх, хөдөлмөрийн дадал чадвар олгох томоохон зорилтуудыг цогцоор нь шийдвэрлэж байлаа. Жишээлбэл: *Хүүхдийн 1 дүгээр эмнэлэг, ШШГЕГ, ТЕГ, Улсын багшийн их сургуулийн байрууд, Улсын дээд шүүхийн өргөтгөл, ХСИС-ийн*

---

[82] К. Маркс, Ф.Энгельс “Түүвэр зохиол” Ш боть Улаанбаатар 1971 74-р хуудас

[83] Макаренко А.С. Сочинение. Т 4. Стр 397

цогцолбор ажилчдын орон сууцны хамт, Улаанбаатар хотын бага тойргийн орон сууцнууд, Толгойт, Хүүшийн ам, Баянзүрх дэх ногоон зоориуд, Хүрэлтогооот, Дамбадаржаа дахь150-200 мянган [84] тонны багтаамжтай мөсөн зоориуд гэх мэт барилгын салбарын бүтээн байгуулалт, Бугант, Ерөө, Бат-Өлзийт, Хархорин, Бэрлэг, Мөнгөнморьт, Багануур зэрэг газарт мод бэлтгэл, модон материалын үйлдвэрлэл эрхэлж жилдээ 240-300 мянган куб метр мод, 15-20 сая төгрөгний зам барьж, Бороо, Цагаанчулуутын алтны уурхай жилдээ 50-75 кг алт олборлож[85], Их хайрханы вольфрам, Хар айраг, Хажуу улааны жонш 35000-40000 тонн, Бодончийн гялтгануур, Харчулуутын гянтболд, Цагаан-овоогийн альбастр, Налайх, Ганц мод, Төгрөг, Мөрөнгийн нүүрс, Гачууртын чулуу, Маанытын шохой, Авдрантын боржин чулуу олборлох зэрэг олон тооны уул уурхайн үйлдвэрлэл, Увс, Булган, Сэлэнгэ, Хэнтий аймгуудын нутагт газар тариалан, Буйр нуурт загасны үйлдвэр, Налайх-Хонхорын төмөр замыг барьж, Д.Сүхбаатарын хөшөөг ялтан зураач, архитекторч С.Чоймбол [86] бүтээн байгуулжээ.

Хорих байгууллага улсын төвлөрсөн төлөвлөгөөг байнга 100-аас дээш хувь давуулан биелүүлж, жилдээ 110-128 сая төгрөгийн үйлдвэрлэл явуулж байснаас гадна тухайн үеийн ЗХХБ-н алба хаагчдын цалин хөлс, ялтны бүх зардлыг хариуцан гаргадаг байлаа. 1976-1980 оны төлөвлөгөө буюу 6 дугаар таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь 22 хоногийн өмнө 100,4 хувиар давуулан биелүүлж 584 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 440 сая төгрөгний борлуулалт хийж, 99 сая төгрөгний ашигтай ажиллаж, 7 дугаар таван жилийн төлөвлөгөөг ч 107,5 хувиар давуулан биелүүлж байлаа.[87]

Хорих байгууллага нь ялтныг хөдөлмөрлүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилчин бэлтгэх, төрөл бүрийн мэргэжилд сургахад гол анхаарлаа хандуулж байв. Хорих ял эдлэгсдийн дундаас гавьяат, алдартнууд, хөдөлмөрийн суутнууд олноор төрөн гарсан билээ. Тухайлбал: Улсын баатар Дандар, Хөдөлмөрийн баатар, тэмээчин Маань, тариаланч Цэрэнчимэд, Бямбацогт, адуучин Ичинхорлоо, жолооч Загд, Ардын жүжигчин Дамдинсүрэн, гавьяат жүжигчин Батзаяа, Лувсанжамц, Лхагваа, гавьяат барилгачин Эмээлт, гавьяат агрономич С.Ганболд, соёлын гавьяат зүтгэлтэн С.Бирваа [88], уран барималч Чоймбол, Ардын уран зохиолч Б.Ринчин, Төрийн шагналт зохиолч Ч.Чимид, зохиолч Чойном[89], МАХН-ын УТТовчооны гишүүн, СнЗ-н орлогч дарга Рагчаа, АИХ-ын орлогч дарга

---

[84] А.Лхагваа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал" УБ. 2011.380 хуудас

[85] А.Лхагваа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын түүхэн замнал" УБ. 2011.148 хуудас

[86] Мөн тэнд 149 дүгээр хуудас

[87] "Засан хүмүүжүүлэх албаны мэдээлэл сэтгүүл" 1981 №2 15 дахь тал

[88] А.Лхагваа "Монгол Улсын ШШГБ-н түүхэн замнал" УБ 2011 165 хуудас

[89] "Тэргүүн" сонин 2007. 02 сар №4/116/

Лоохууз [90] *, Ардын боловсролын тэргүүний ажилтан Найдан зэрэг олон хүнийг дурдаж болно.*

ЗХХБ-н ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Дэндэвийн Аварзэд гуай дурсамжиндаа: “ЗХХБ манай улсын үйлдвэр аж ахуйн бараг бүх салбарын эх үндсийг тавьсан юм шүү дээ. Социализмын үеийн үзэл суртлын явцуурлаас болоод улс орны эдийн засгийн гол салбаруудын үндэс суурийг засангийнхан тавьсан болчих гээд байсан тул энэ үнэнийг дурддаггүй байсан. Онон, Хараа, Ерөө, Жаргалант гээд САА-н тулгын чулууг засангийнхан тавьсан, гар үйлдвэрлэл эрхэлж, алт олборлож, байшин барьж, мөн ч их зүйл бүтээсэн дээ” хэмээн өгүүлжээ.[91]

Ялтнаар хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн зохицуулалтын талаар дурдвал:

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” Монгол Улсын хуулийн 120 дугаар зүйлд “Ялтны хөдөлмөр, хөдөлмөрийн нөхцөл”, 121 дүгээр зүйлд “Ялтны хөдөлмөрийн хөлс”, ШШГЕГ-н даргын 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдөр А/33 дугаар тушаалаар батлагдсан “Ялтныг гэрээгээр ажиллуулахад мөрдөх заавар”, 2008 оны А/115 дугаар тушаалаар батлагдсан “Ялтныг мэргэжлийн түр сургалтанд хамруулах, шалгалт авах, мэргэжлийн чадамжийн гэрчилгээ олгох журам”, 2013 оны 02 дугаар сарын 06-ны өдөр А/32 дугаар тушаалаар батлагдсан “Ялтны хөдөлмөрийн норм, хөлсний үнэлгээг тогтоох журам”, 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдөр А/156 дугаар тушаалаар батлагдсан “Үйлдвэрлэлийг хөгжүүлэх хөтөлбөр” зэрэг болно.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2009 оны 07-р сарын 15-ны өдрийн 156 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн 3.6 дахь хэсэгт: “Үйлдвэрлэлийг хөгжүүлэн үйл ажиллагааных нь үр дүнд хорих ял эдлэгчийг ажлын байраар хангах, хорих анги, салбар нэгжийг түшиглэсэн үйлдвэр, үйлдвэрлэх бүтэгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх замаар дотоод эх үүсвэрийг бий болгох” тухай, мөн тушаалын 3-р хавсралтад “Хорих ангиудын дэргэд олон улсын жишиг үйлдвэрийн байр барих”, “Үйлдвэрлэлийг өргөтгөж, бизнесийн дотоод сүлжээг байгуулах, ялтныг ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах”, “Ялтны хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар цогц арга хэмжээ төлөвлөн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах /засгийн газарт санал оруулах, тэдний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, хөдөлмөрийн орлогоос хохирогчийн хохирол аль болох шуурхай нөхөн төлөгдөх нөхцөлийг бүрдүүлэх”, “эрчимжсэн мал аж ахуй ба газар тариалан төсөл хэрэгжүүлэх” тухай тус тус заасан байна.

Дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь анхаарал

[90] Ц.Лоохууз “Хол гишгэж ойр харж явья” /Эмхэтгэгч С.Баатар/ УБ. 2006 132 хуудас

[91] “Эрх зүй албаны мэдээлэл” сэтгүүл 1996 №2

хандуулж, тодорхой ажил зохион байгуулж байгааг бариимтаар дурдвал:

ШШГЕГ нь 2014 онд 2585 тн шохой, 5850 тн шохойн чулуу, 980,000 улаан тоосго, 2077 м2 вакум цонх, хаалга, 168106 ширхэг чулуун бүтээгдэхүүн, 29000 ширхэг нухтэй блок, 3118 м3 хөнгөн блок, 1060 тн эрдэст нунтаг зэрэг 3,180,6 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2229,5 сая төгрөгийн борлуулалт хийжээ.

Мөн онд 4375 ялтныг ажлын байраар хангаснаас 2171 ялтан тогтмол ажиллаж, 1378,7 сая төгрөгийн цалинг ялтнуудад тооцон олгожээ. Хөдөлмөр эрхэлсэн ялтан өмнөх оныхоос 0,1 хувиар, цалин бодолт 0,8 хувиар өсөж, шүүхийн төлбөр буюу гэм хорын хохиролд 1643 ялтны 296,0 сая төгрөг төлж барагдуулсан нь 2013 оныхоос 53 хувиар өссөн байна.

2015 онд 2960 ялтанг ажлын байраар хангаж, 446,9 сая төгрөгийн цалин бодогдсон байна. Ялтны хөдөлмөрийн хөлснөөс суутгасан шүүхийн төлбөрт ялтны 88,2 сая төгрөг шилжүүлэн барагдууллаа.

Хорих 409 дүгээр ангид “Гутлын үйлдвэр” байгуулахаар судалгаа хийгдэж дууссан ба БНХАУ-ын Венжоу хотын “Венжоу Импорт Экспорт” компанитай гэрээ байгуулж, 2015 оны 2 дугаар улиралд багтаан ашиглалтанд оруулсан. Уг үйлдвэр нь жилдээ 8,0-10,0 мянган ширхэг хос гутал хийх хүчин чадалтай ба үндсэн бүтээгдэхүүн нь ялтны ажлын гутал, албан хаагчдын хагас түрийтэй гутал байхаар төлөвлөж, өнөөдрийн байдлаар Хорих 409 дүгээр ангид гутлын шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулан туршилтын журмаар албан хаагчдын хагас түрүүтэй гутал 100 хос, албаны хагас түрүүтэй өвлийн гутал 100 хос, ялтны ажлын гутал 100 хос, нийт 300 хос гутал үйлдвэрлэн үйлдвэрийн үйл ажиллагааг жигдрүүллээ.

Дархан-Уул аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албанд эсгийний үйлдвэр шинээр байгуулсан бөгөөд одоогийн байдлаар 6 метрийн урттай 2 метрийн өргөнтэй нийт 22 ширхэг эсгийг үйлдвэрлээд байгаа ба нэг эсгий дунджаар 17-18 кг ахрын ноос, 5-6 кг ноосны очоос хийн бутлагч, эргүүлэгч машин ашиглан үйлдвэрлэж байна.

Хорих 407 дугаар ангид 2 үйлдвэрийн цехэд 80 ялтныг тогтмол ажлын байраар хангаж, цэргийн дүрэмт хувцас, ялтны нормын хувцас хэрэглэлийг оёж байна. Энэ үйлдвэр нь өдөрт 20-120 хос хувцас, гэрийн цагаан бүрээс 350-400, цагаан хэрэглэл 500-550 хосыг үйлдвэрлэх хүчин чадалтай юм. Энэ онд 12 аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан ажиллаж 90,623,0 төгрөгийг бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 20 орчим нэгжид бүтээгдэхүүн үйлдвэрлэл явагдаж 2,512,5 сая төгрөгний бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 2,012,0 сая төгрөгний борлуулалт хийсэн хэдий ч зарим шалтгааны улмаас төдийлөн жигд ажиллаж чадахгүй байна. Мөн ихэнх нэгжид үйлдвэрлэлээ өргөжүүлэх, шинээр үйлдвэр байгуулах санал их байгаа тул энэ асуудлыг шийдвэрлэхээр Үйлдвэр, хөдөө аж

ахуйн яамтай зөвшилцөн тодорхой тооны жижиг, дунд үйлдвэрийн төслийн зээлийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлхээр хандаад байгаа юм.

Энэ ажлын хүрээнд эхний ээлжинд хэрэгжүүлэх боломж бүхий 14 нэгжийн 6,8 тэрбум төгрөгийн жижиг, дунд үйлдвэрийн төслийг шалгаруулж, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд хүргүүлээд байна. Үүнд,

-Байгалийн болон хиймэл чулуу хийх үйлдвэр;

-Хаягдал цаас дахин боловсруулж, цаасан уут хийх үйлдвэр;

-Машины гупер, гэрлийн үйлдвэр;

-Гутлын үйлдвэр;

-Гурилын үйлдвэр;

-Гар нүүр, биеийн алчуурын төсөл;

-Оёдлын үйлдвэрийн өргөтгөлийн төсөл;

-Хагас боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх төсөл;

-Гэрийн бүрээс үйлдвэрлэх төсөл;

-Хөнгөн блокны үйлдвэрлэлийн төсөл;

-Вакум цонхны үйлдвэрлэлийн төсөл;

-Блок үйлдвэрлэх төсөл;

2015 онд албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд анхаарч БЗД-ийн 16 дугаар хороонд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдын 160 айлын орон сууц, Сүхбаатар аймаг дахь шийдвэр гүйцэтгэх албаны албан хаагчдын 16 айлын орон сууц, Цагдан хорих 461 дүгээр ангийн албан хаагчдын хүүхдийн цэцэрлэгийн барилга зэргийг ашиглалтад оруулаа.

“Монгол улсын засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т заасан:

-Ажлын байр шинээр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх;

-Барилгын материалыг эх орондоо үйлдвэрлэдэг болох;

-Уул уурхайн салбарт хэрэгжиж байгаа төслүүдэд үндэсний аж ахуйн нэгжүүд давуу эрхээр бараа, ажил, үйлчилгээ нийлүүлэх, туслан гүйцэтгэгчээр ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;

-Малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, зах зээлд нийлүүлэх зорилго бүхий хөдөө аж ахуйн биржийг байгуулах, импортоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг болох;

-Хүнсний нарийн ногооны тариалалтыг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээг хангах;

-Аймгуудад усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих;

-Боловсруулах үйлдвэр байгуулан Монгол Улсад олборлож байгаа ашигт малтмал, газрын тосны бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрт эхний ээлжид нийлүүлдэг болох;

-Улсын Их Хурлаас баталсан “Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот” хөтөлбөр, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д тусгагдсан төмөр замыг барьж байгуулах ;

-Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах зэрэг зорилт хөтөлбөрүүдэд Шүүхийн шийдвэр

гүйцэтгэх байгууллага томоохон үүрэг гүйцэтгэж чадна.

Төмөр зам, авто зам, гүүр барих, уурхай олборлох, ашигт малтмалын хайгуул хийх, газрын тос, төмрийн хүдэр болон бусад ашигт малтмал боловсруулах, хог хаягдал боловсруулан эрчим хүч гаргах үйлдвэр, нарны цэнэгээр халаах төхөөрөмжийн үйлдвэр байгуулах, барилгын материал үйлдвэрлэх зэргээр төрөл бүрийн үйлдвэрлэл эрхлэх боломжтой, чадвартай юм. Энд ганцхан зохицуулалт хэрэгтэй. Энэ нь төрөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагыг тодорхой чиглэлийн бүтээн байгуулалтын ажилд оролцуулах тухай шийдвэр гаргах асуудал юм.

Германы “Дойче Велле” агентлагийн мэдээлснээр: “Герман улс ялтнуудын хүчээр жилд 200 сая маркийн бараа бүтээгдэхүүн борлуулдаг ба wolksvagen автомашины үйлдвэр, ikea, aidi зэрэг концернуудад ажилладаг” байна.[92]

Америкийн нэгдсэн улсын хорих ангиуд Motorola, Compaq, Honeywell, Microsoft, Boeing, Nortel [93] зэрэг компаниудад ажиллаж жилдээ 398 саяас 1 тэрбум 31 сая долларын үйлдвэрлэл эрхэлдэг гэнэ.[94]

Оросын холбооны улсын төрийн думын гишүүн Александр Хинштейн “Хорих ял эдлүүлэх тухай” хуульд “Ялтныг хорих ангийн байрлалаас гадуур, төрийн болон хувийн хэвшлийн үйлдвэрлэлд хөдөлмөр эрхлүүлэх” нэмэлт өөрчлөлт оруулах санал оруулжээ. Энэ санал зөвшөөрөгдвөл хорих ангиас хэдэн зуун километр алслагдсан бүсэд хөдөлмөр эрхлэх боломж олгох юм. Мөн тэрээр 2018 онд дэлхийн хөл бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах цогцолбор барих, Сочи хотын эргэн тойрны ойг цэвэрлүүлэх, Керченскийн буланд гүүр тавих зэрэг бүтээн байгуулалтад оролцуулах төлөвлөгөө боловсруулан Төрийн думд өргөн барьжээ.[95]

Хорих ял эдлэгсдийг хөдөлмөрт хамруулан, тэднийг ажлын байраар тогтмол хангах нь нэг талаас тэднийг нийгэмшүүлэх, гэмт хэргийн замаар буюу амар хялбар аргаар мөнгө олох, хүсэл сонирхолоос татгалзуулах, ажил хөдөлмөрийн үр шимийг мэдрүүлэх, хөдөлмөрийн хүмүүжлийн нөлөөлөл үзүүлэх, ажил хөдөлмөр эрхлэх дадлага чадвар бий болгох, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, бие бялдрыг эрүүлжүүлэх, нөгөө талаас эх орны бүтээн байгуулалтын ажилд томоохон, бодитой хувь нэмэр оруулах, эдийн засгийн хэмнэлт гаргах ач холбогдолтой юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын менежментийн шинэчлэл нь:

-Хорих байгууллагын дотоодын үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өргөжүүлэхээс гадна ялтны хөдөлмөрийг улс орны бүтээн байгуулалтад түлхүү оролцуулах замаар тэдний хөдөлмөр эрхлэлтийн хувь хэмжээг нэмэгдүүлэх, нөгөө

[92] Deutsche Welle | 15 января 2014, 09:37 delfi
[93] kommersant.ru/doc/2430878
[94] Вопросик 23 июля 2015 svargaman
[95] Новая газета, 2015

талаар улсын эдийн засагт тодорхой хэмнэлт, үр ашгийг бий болгох

-Бүтээн байгуулалтын ажилд оролцож болох чиглэлийн талаар судалгаа хийх

-Гэм хорын хохирлыг тэдний хөдөлмөрийн хөлснөөс нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх

-Ялтныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр нь хөдөлмөрийн хүмүүжил буюу хөдөлмөрийн дадлага чадвар олгох явдал юм. Хөдөлмөр эрхэлснээр ажлын эв дүй, арга ухаан, тэсвэр хатуужил, хамт олны дунд биеэ зөв авч явах дадал хэвшил суухаас гадна суллагдан гарсны дараа нийгэмд эзлэх байр сууриа олоход дөхөм болно. Үүний тулд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь ШШГБ-ын менежментийн шинэчлэлийн нэг чухал асуудал юм.



Г.БАТТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдсэн үндэстний байгууллагаас 1948 онд батласан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хамгаалуулах эрхтэй”[96] гэж заажээ.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”–ыг улсуудад уриалсан[97].

---

[96] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/

[97] М,Ичинноров. “*Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн*” Хууль сахиулахын инноваци олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл
http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html

талаар улсын эдийн засагт тодорхой хэмнэлт, үр ашгийг бий болгох

-Бүтээн байгуулалтын ажилд оролцож болох чиглэлийн талаар судалгаа хийх

-Гэм хорын хохирлыг тэдний хөдөлмөрийн хөлснөөс нөхөн төлүүлэх ажиллагааг эрчимжүүлэх

-Ялтныг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын нэг хэлбэр нь хөдөлмөрийн хүмүүжил буюу хөдөлмөрийн дадлага чадвар олгох явдал юм. Хөдөлмөр эрхэлснээр ажлын эв дүй, арга ухаан, тэсвэр хатуужил, хамт олны дунд биеэ зөв авч явах дадал хэвшил суухаас гадна суллагдан гарсны дараа нийгэмд эзлэх байр сууриа олоход дөхөм болно. Үүний тулд ялтныг хөдөлмөр эрхлүүлэх хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь ШШГБ-ын менежментийн шинэчлэлийн нэг чухал асуудал юм.



Г.БАТТУЛГА
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ГЭРЧ, ХОХИРОГЧ ХАМГААЛЛЫН ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Нэгдсэн үндэстний байгууллагаас 1948 онд батласан Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын 7 дугаар зүйлд: “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаваргүйгээр хамгаалуулах эрхтэй”[96] гэж заажээ.

Мөн НҮБ-ын Ерөнхий Ассемблейн 1985 оны 40/34 дүгээр тогтоолоор “Гэмт хэрэг болон эрх мэдлээ урвуулан ашигласан үйлдлийн улмаас хохирсон хохирогчийн эрх зүйн хамгаалалтыг хангах үндсэн зарчмын тухай” тунхаглалыг батлан гаргаснаар олон улсын хэмжээнд хохирогчийн эрхийн талаар гаргасан үндсэн баримт бичиг болсон байна. Уг тунхаглалын 6 дугаар зүйлд “гэмт хэргийн хохирогчийн аюулгүй байдлыг нэн тохиромжтой нөхцөлөөр хангах, мөн заналхийлэл буй тохиолдолд гэрчийг хамгаалах”–ыг улсуудад уриалсан[97].

---

[96] Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. http://www.legalinfo.mn/law/downloadPdf/1271/

[97] М,Ичинноров. “*Гэрч, хохирогчийг төрийн нэрийн өмнөөс хамгаалах тогтолцоо бий болж байгаа нь эрх зүйн шинэтгэлийн чухал алхам мөн*” Хууль сахиулахын инноваци олон улсын эрдэм шинжилгээний бага хурал дээр тавьсан илтгэл http://ichinnorovm.blogspot.com/2014/11/blog-post.html

Иймд хүний эрхийн хамгаалалт нь төрийн зорилго, чиг үүрэг, харицуцлагатай салшгүй холбоотой [98] билээ. Нөгөө талаас хүний эрхийн асуудал нь улс төр, нийгэм, эдийн засгийн бүхий л салбартай шууд холбоотой учир Засгийн газар, олон улсын байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшил, хууль, хяналтын байгууллагын хамтын ажиллагааг уялдуулж, хамтран ажилласнаар гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх, тодорхой үр дүнд хүрэх бололцоотой юм.

Олон улсын байгууллагын гаргасан статистикийн мэдээнээс үзэхэд дэлхий дээр дөрвөн гэрчийн нэг нь байцаан шийтгэх ажиллагааны явцад өөрийн мэдүүлгээс буцдаг байна [99]. Тиймээс гэмт хэргийг хянан шийдвэрлэх явцад хэргийн бодит үнэнийг тогтоох, түргэн шуурхай илрүүлэхэд бэрхшээл учирч, хамгийн нягт нямбай мөрдсөн хэрэг ч эцсийн дүндээ үр дүнгүй болох нь ч бий.

Түүнчлэн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 58/4 дугаар тогтоолоор баталсан Авилгалын эсрэг конвенци, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2000 оны 55/25 дугаар тогтоолоор баталсан Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцид “Оролцогч улс бүр энэхүү конвенцид тогтоосон гэмт хэргийн талаар мэдүүлэг өгч буй гэрч ба шинжээч, мөн зохих тохиолдолд тэдний хамаатан садан болон бусад ойрын хүнийг өс хонзон, буюу айлган сүрдүүлгээс хамгаалах талаар зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн, боломжийн хэмжээнд авна. Оролцогч улс бүр энэхүү конвенцид хамаарах гэмт хэрэг, ялангуяа өшөө авах буюу заналхийллээс хохирогчийг хамгаалах болон түүнд туслалцаа үзүүлэх зохих арга хэмжээ авна” гэж тус тус үүрэг хүлээлгэсэн байна.

Үүнээс үүдэлтэйгээр ихэнх хөгжилтэй улс орнуудад гэмт хэргийн гэрч, хохирогчийг хамгаалах янз бүрийн хөтөлбөрийг олон арван жилийн турш хэрэгжүүлсээр иржээ. Өөрөөр хэлбэл тэдгээр улс орнуудад эрүүгийн хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд гэрч, хохирогчийн хувийн аюулгүй байдал, түүнийг хамгаалах асуудал эрх зүйн тогтолцооных нь нэг чухал хэсэг болон бүрэлдсэн гэж үзэж болно. Тухайлбал АНУ, Англи, Герман, Австрали, Итали, Канад зэрэг улсуудын гэрч, хохирогчийг хамгаалах талаарх эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг үзэхэд гэрч хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бүрдүүлснээс гадна хөрөнгө санхүү, зохион байгууллалтын арга хэмжээг цогц байдлаар нь тусгасан тусгай хөтөлбөрүүдийг батлан хэрэгжүүлж, энэ талаар ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Ер нь олон улсын түвшинд хохирогчид дэмжлэг (victim support), гэрчид хамгаалал (witness protection) гэсэн үндсэн зарчим үйлчилдэг.

Гэрч гэж хэн бэ? Гэсэн асуултанд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нөхцөл байдал, улс орнуудын эрх зүйн

---

[98] Ч.Нямсүрэн. Эрх зүй, төрийн ерөнхий онол. УБ., 2004. 407-р тал

[99] Т.Оюунчимэг.Гэрч. УБ., 2014. 33 дахь тал

тогтолцооноос шалтгаалан харилцан адилгүй утгаар хариулах боловч гэмт хэргийн гэрчийн талаарх хууль зүйн болон судлаачдын тодорхойлолтод “хэргийн талаар шүүхээс үнэн зөв, шударга, үндэслэл бүхий шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа, тэр талаар үнэн зөв мэдүүлэх чадвартай хэн ч гэрч байж” болно гэсэн нийтлэг шинжүүдийг агуулсан байна[100].

Хамгаалалтын зорилгын хувьд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх, шүүн таслах ажиллагаанд тухайн хэргийн талаар чухал ач холбогдол бүхий, үнэ цэнэтэй мэдээллийг мэдэж байгаа хүнийг мэдээллийн эх сурвалжын хэмжээнд үнэлэх бус иргэний үүргээ биелүүлж шударга шүүхийн өмнө үнэн зөв мэдүүлэг өгч буй иргэний хувьд үнэлж, түүнийг хамгаалах олон улсын чиг хандлага, арга хэмжээ улам чухлаар тавигдах болсон.

Харин НҮБ-ын 1985 оны “Гэмт хэрэг болон албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хохирогчдын талаарх хууль цаазын үндсэн зарчмын тухай” тунхаглалын гэмт хэргийн хохирогч гэсэн ойлголтод “...эрүүгийн хуулийг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйн улмаас бие махбодийн болон оюун санаа, эд хөрөнгийн хохирол учирсан, сэтгэл санааны дарамтанд орсон, эсхүл үндсэн эрх нь ноцтой зөрчигдсөн бие хүн болон хамт олныг ойлгоно”[101] гэж заажээ.

Гэрч, хохирогчийг хамгаалах асуудал олон улсын шинж чанартай болохын хэрээр гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгохыг шаардаж байна. НҮБ болон олон улсын бусад байгууллагуудаас батлан гаргасан баримт бичгүүдийн үзэл санааг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор улс орнууд эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар ихээхэн анхаарах болсон. Ялангуяа зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд энэ нь ихээхэн ач холбогдолтой бөгөөд барууны гэгдэх өндөр хөгжилтэй улсууд тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, тусгайлсан хууль тогтоомжийг батлан гаргах замаар гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бий болгосон байна. Ийм тогтолцоог бүрдүүлэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй зарим улс орнуудын туршлага, эрх зүйн зохицуулалтыг авч үзье.

Америкийн Нэгдсэн Улс

Гэрч хамгааллын асуудал нь анх 1970-аад оны дунд үеэс Америкийн нэгдсэн улсад Мафи буюу гэмт бүлэглэлүүдийг устгах хөтөлбөрийн хүрээнд хөндөгдөж байжээ. Тухайн цаг үеийг хүртэл Omerta буюу Мафийн гишүүдийн дунд “Чимээгүй байх” гэсэн бичигдээгүй хууль ноёрхож байсан бөгөөд цагдаагийн байгууллагатай хамтран ажилласан, гэмт бүлэглэлийн хууль бус үйлдлийн

[100] Т.Оюунчимэг.Гэрч. УБ., 2014. 18-20 дахь тал
[101] Хүний эрх. Шүүх эрх мэдлийн салбар дахь хүний эрх. НҮБ. УБ., 1996 174 дэх тал

талаар мэдээлэл өгөх гэсэн хэнийг ч үхлээр заналхийлж байв.

Энэ байдлаас шалтгаалаад гэрчүүд гэмт хэргийн талаар мэдүүлэг өгөхөөс татгалзах, хэргийг мөрдөн шалгах, бодит үнэнийг тогтооход ихээхэн хүндрэл гарах болжээ. Иймд АНУ-н Конгресс зохион байгуулалттай гэмт хэргийн гэрчийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх эрхийг Хууль зүйн яаманд олгож “Зохион байгуулалттай гэмт хэрэгт тавих хяналтын тухай” хууль баталсан [102] цагаас гэрч хамгаалалын тогтолцоо бүрдэж эхэлсэн гэж үздэг. Улмаар 1982 онд Когресс гэмт хэргийн “Гэрч, хохирогчийн хамгаалалах акт” [103] (The Victim and Witness Protection Act), 1984 онд “Гэрчийн аюулгүй байдлыг сайжруулах акт”[104] (Witness Security Reform Act) – ыг тус тус батлан гаргасан байна. Гэрч, хохирогчийг хамгаалах ажиллагааг Холбооны Маршалуудын алба хэрэгжүүлдэг.

Гэрч, хохирогчдыг хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлснээс хойшх 30 гаруй жилийн хугацаанд 7000 гаруй гэрч, хохирогч, тэдний гэр бүлийн 9000 гаруй гишүүд “засгийн газартай хэлцэл” хийж маршалын албаар хамгаалуулан төрийн хамгаалалтанд орсон мэдээ бий [105]. Бусад улс орны хууль тогтоогчид АНУ-ын конгрессоос баталсан хууль, засгийн газраас авч хэрэгжүүлсэн гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрүүдээс баримжаа авч өөрсдийн онцлогт тохируулан эрх зүйн актуудыг батлан гаргах, хөтөлбөр хэрэгжүүлэх зэрэг ажлыг эхлүүлсэн байдаг.

Өнөөдөр АНУ-ын муж улс бүрт гэрч, хохирогчийг хамгаалах талаар хууль тогтомжийг батлан хэрэгжүүлж байна.

Гэрчийг хамгаалалтанд авахын өмнө гэрчтэй хэлцэл хийхээр хамгаалалтанд авах гэж буй эрх бүхий субьектээс гэрчид “харилцан ойлголцох тухай санамж бичиг” (memorandum of understanding) илгээх бөгөөд түүнд хамгаалах арга хэмжээг, хэрэглэх нөхцлийг тусгана. Тухайлбал гэрч нь гэм буруутай этгээдийг илчлэх, гэмт хэргийг илрүүлэхэд чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгвөл аюулгүй байдлын хамгаалалтын ямар арга хэмжээ хэрэглэх талаар тодорхой заадаг. Мөн хамгаалуулах гэж буй этгээд санамж бичигт заасан нөхцөлийг биелүүлээгүй тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг өөрчлөх талаар тусгадаг байна.

АНУ-ын хорих байгууллагууд гэмт хэргийн хохирогчтой идэвхтэй хамтран, тэднийг дэмжин ажилладаг бөгөөд ялтныг хугацнаас өмнө суллах талаар асуудлыг шийдвэрлэхдээ тухайн этгээдийн хохирогчийн саналыг Тусгай комисс буюу Пароул комиссоор (Parole Commission/Board) дамжуулан нууцаар авах ба хохирогч ялтныг сулласан нөхцөл, хугацааны тухай мэдээллийг мөн бичгээр авдаг.

Австрали улс

Анх 1983 онд Хааны комиссоос Австралид зохион байгуулалттай гэмт

---

[102] Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 490 дэх тал.

[103] www.justice.gov/usao-wdla/programs/victim-witness

[104] https://www.justice.gov/usam/usam-9-21000-witness-security

[105] Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 491 дэх тал.

хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлсэн бөгөөд гэмт бүлэглэлийн зохион байгуулагчид, толгойлогчдын талаар мэдээлэл өгсөн, гэмт бүлэглэлийн гар хөл бологсод буюу доогуур байр эзэлдэг гишүүдэд боломж олгох талаар хөндсөн байдаг.

Энэхүү арга хэмжээ нь тодорхой үр дүнд хүрсэн бөгөөд зохион байгуулалттай гэмт хэргийг илчлэхэд тусалсан, мэдүүлэг өгсөн, хамтарч ажилласан хүнийг цагдаагийн байгууллага 24 цагийн турш хамгаалалтанд авч, тэдний бичиг баримтыг солих, нүүлгэн шилжүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлж эхэлсэн юм.

1988 онд парламентын хамтарсан хороо нэгэн дэлгэрэнгүй судалгаан дээр үндэслэн гэрч хамгааллын асуудлын талаар хэлэлцсэн бөгөөд энэхүү хэлэлцүүлгийн тайлан 2 чухал шийдвэр гаргахад нөлөөлжээ.

1. Гэрч хамгаалах тухай 1994 оны хуулийг батлан гаргаж гэрч хамгааллын тогтолцоог Хамтын нөхөрлөлийн орнуудын (Commonwealth level) түвшинд хүргэсэн

2.Австралийн үндсэн бүс нутаг болон хэд хэдэн мужуудад тухайн хуулийн дагавар хуулиуд батлагдахад хүргэсэн гэж үздэг. Уг хууль батлагдсанаар үндэсний хэмжээний гэрч хамгаалах хөтөлбөр хэрэгжиж, гэмт хэргийн гэрч олон хүн үүнд хамрагдах боломж бүрэлдсэн. Гэрч хамгаалах тухай хууль 1997, 2002 онуудад тус тус нэмэлт өөрчлөлт орж улам боловсронгуй болон мөрдөгдөж байна[106].

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Гэрч хамгаалах хөтөлбөр 1980 оноос хойш Германд хэрэгжиж эхэлсэн гэж үздэг. Тухайлбал мотоциклын бүлэглэлээс (Bikers) үйлдэгдэж буй зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор Гамбург хотын цагдаагийн газраас хэргийг илрүүлэх, мөрдөн шалгалт явуулахад хамтарч ажилласан, гэмт хэргийн талаар үнэтэй мэдээлэл өгсөн гэрчүүдийг хамгаалах анхны арга хэмжээ авчээ. Энэхүү хөтөлбөрийг баримжаа болгон Холбооны Эрүүгийн цагдаагийн газраас гэрч хамгаалах ажиллагааг бүх Герман даяар системтэйгээр хэрэгжүүлж эхэлсэн байна.

ХБНГУ Гэрч хамгаалах тухай бие даасан хуулиа 1998 онд баталсан юм. Тухай хууль батлагдан гарсантай холбогдуулан Германы ЭБШХ-д гэрчийг байцаахтай холбоотой шинэ заалт орсон байна. Мөн 1998 онд гэрчийг хамгаалах тусгай чиг үүрэг бүхий Эрүүгийн цагдаагийн тусгай хэсэг анх байгуулж, гэрч хамгаалах газартай хамтран заавар боловсруулан тусгай хөтөлбөр хэрэгжүүлж эхэлжээ.

Эрсдэлд буй гэрчийг хамгаалах тухай хууль 2001 онд батлагдах хүртэл гэрч хамгаалах заавар Германы гэрчийг хамгаалах хөтөлбөрийн гол үндэс баримт бичиг болж байв. Энэ үеэс

---

[106]Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 9. https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf

ХБНГУ-ын гэрчийг хамгаалах хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж холбооны түвшинд болон муж улс бүрт гэрч хамгаалах газар байгуулагдсан.

Улмаар Холбооны Эрүүгийн цагдаагийн газраас улс орны хэмжээнд мөрдөн шалгаж буй бүх хэргийн гэрчийг хамгаалах төдийгүй муж улсуудын болон олон улсын хэмжээнд гэрч хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах үүргийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал Гэрч хамгаалах хөтөлбөрийн жилийн тайланг бэлтгэн гаргах; гэрч хамгаалах талаар сургалт, сурталчилгаа явуулах; холбооны болон муж улсын гэрч хамгаалах албаны захирлуудын ээлжит бага хурлыг зохион байгуулах; бусад улсын холбогдох байгууллагатай хамтын ажиллагаа тогтоон хамтран ажиллах; олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх зэрэг үндсэн үүргийг хэрэгжүүлдэг[107].

Өмнөд Африкийн бүгд найрамдах улс

Өмнөд Африкт гэрч хамгаалах үйл ажиллагаа нь 1996 оны Гэмт Хэргээс урьдчилан сэргийлэх үндэсний стратегийг батлагдах хүртэл 1977 оны Гэмт хэргийн хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаж байсан. Гэрч хамгаалахтай холбоотой заалтууд нь ерөнхийдөө албадлагын шинж чанартай байсан бөгөөд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах дэглэмийн үед гэрчээс мэдүүлэг, нотлох баримт гаргаж өгөхөд албадлага хэрэглэж байв.

1996 оны Өмнөд Африкийн парламентад тус улсын засгийн газрын тавьсан тайланд аюул занал, халдалгад өртөж болзошгүй гэрчүүдээс мэдүүлэг авах, тэдний гаргасан нотлох баримтыг хамгаалах, гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрч хамгааллын асуудал чухал болохыг ойлгуулсан бөгөөд тухайн үед гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд гэрчийг хамгаалах ажиллагаа хангалтгүй байгааг хууль тогтоогчид хүлээн зөвшөөрсөн байна.

Иймд Өмнөд Африкийн парламентаас Гэрч хамгаалах тухай хуулийг 2000 онд эцэслэн баталснаар өмнөх тогтолцоог бүр мөсөн өөрчилж гэрч, хохирогчийг хамгаалах шинэ тогтолцоог бий болгож чадсан байна. Үүний үр дүнд ӨАБНУ-д гэрч, хохирогч хамгаалах олон хөтөлбөрүүд амжилттай хэрэгжсээр иржээ.

Бүгд найрамдах Итали улс

Итали орон эртнээс зохион байгуулалттай гэмт бүлэглэл буюу “мафигаар” алдартай гэдгийг бид мэднэ. Мафитай хийх тэмцлийг амжилттай хэрэгжүүлэх нь үе үеийн засгийн газрын өмнө томоохон асуудал болсоор ирсэн. Ийм ч учраас судлаачид гэрч, хохирогчийг хамгаалах Италийн хөтөлбөр нь дэлхийн хамгийн эртний хөтөлбөрийн нэг гэж үздэг.

Итали улсад гэрчийг хамгаалах асуудал нь терроризм болон зохион байгуулалттай гэмт хэрэгтэй хийх тэмцлийг эрчимжүүлэх арга хэмжээний хүрээнд бий болжээ. Гэрчийг хамгаалах хөтөлбөр 1984 онд албан ёсоор хэрэгжих эхлэл нь тавигдсан гэж

[107] Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 12. https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf

үздэг. Энэ нь тухайн үеийн гэмт бүлэглэлийн гишүүн байсан Томмаза Бушетта мафийн томоохон бүлэглэлийн эсрэг мэдүүлэг өгч үүний үр дүнд гэмт бүлэглэлийн толгойлогч, гишүүд нийт 350 хүнийг илчлэн, баривчилж шоронд хорьсноос үүдэлтэй. Бушеттаг мэдүүлэг өгсний дараа түүнийг хамгаалалтанд авч улмаар бичиг баримт болон гадаад төрхийг өөрчлөх зэрэг хамгаалалтын арга хэмжээг авсан байна.

1988 онд баталсан “Мафиудаас үйлдэж байгаа гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг зохицуулах талаар авч хэрэгжүүлэх хойшлуулашгүй арга хэмжээний тухай” №726 хуулиар мафийн эсрэг хамтран ажилласан буюу тэдний үйл ажиллагаатай холбоотой баримт, сэлтийн тухай мэдүүлэг өгсний улмаас ноцтой аюулд учирч байгаа этгээдийг хамгаалалтанд авч, шаардлагатай бүх арга хэмжээг хэрэглэж байх зөвшөөрлийг мафитай тэмцэх комиссараас зохих эрх бүхий байгууллагад өгч байхыг зөвшөөрсөн байдаг[108].

Энэхүү үйл явдлын үр дүнд 1990-ээд оны эцэст гэмт бүлэглэлийн 1000 гаруй гишүүд зохион байгуулалттай гэмт хэргийг илрүүлэхэд хууль хяналтын байгууллагатай хамтран ажилласан ба томоохон үр дүнд хүрчээ[109]. Гэсэн хэдий ч Италийн гэрч хамгаалах хөтөлбөр нь гарал үүсэл, сонгосон арга барил болон гэрчийг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжилт, удирдлага зохион байгуулалт буруу байсан зэргээс шалтгаалан багагүй шүүмжлэлд өртсөн юм. Тухайлбал гэрчийн гэр бүлийн гишүүд халдлагад өртөх, зарим гэрч худал мэлээлэл өгч бусдыг гүтгэх зэрэг сөрөг үзэгдэл гарах болсон байна.

1991 оны Италийн №82 хуульд “хуулийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа этгээдүүд, мөн тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалах” тухай хэм хэмжээг шинээр тусгасан. Тухайлбал энэ хуулийн 9 дүгээр зүйлд хэрэв мафитай тэмцэх ерөнхий комиссарын зөвшөөрсөн арга хэмжээ хангалттай бус гэж тооцвол, тусламжийн арга хэмжээг багтаасан хамгаалалтын тусгай хөтөлбөр хэрэгжүүлэхийг заасан юм. Улмаар Италийн №82 хуулийг 2001 онд шинэчлэн боловсруулсан байна. Үүнд орсон томоохон өөрчлөлт нь гэрч хамгаалах хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бие даасан бүтцийг бий болгосон бөгөөд дараах заалтыг шинээр тусгасан. Үүнд:

а/ хамгаалалтанд авах эрх бүхий хүнд:

1. мафи, мансууруулах бодистой холбоотой эсвэл хүн амины гэмт хэргийн гэрч, мэдээллэгч

2. 5-20 хүртлэх жилийн хорих ялаар шийтгүүлэхээр заасан гэмт хэргийн гэрч

3. Аюулд өртөж болзошгүй гэрч, мэдээлэгчийн ойр дотны хүмүүс

b/ Хамгаалалтын төрөл:

---

[108] Ч.Нямсүрэн. Гэмт хэргийн виктимологи. УБ., 2005. 511 дэх тал.

[109] Good Practices for the Protection of Witnesses in Criminal Proceedings Involving Organized Crime. UN. New York 2008., page 14.
https://www.unodc.org/documents/organized-crime/Witness-protection-manual-Feb08.pdf

1. "Түр зуурын төлөвлөгөө" (temporary plan)-ний дагуу амьдрах зардлыг оролцуулан 180 хоног өөр газарт нүүлгэн суурьшуулах

2. Нүүлгэн шилжүүлж буй хүмүүст зориулсан хамгаалах, нийгэмшүүлэх төлөвлөгөөний "Тусгай арга хэмжээ"

3. Нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан түр үнэмлэх бичиг баримт олгох, санхүүгийн болон хууль, эрх зүйн туслалцаа үзүүлэх "Тусгай хамгаалах хөтөлбөр" хэрэгжүүлэх

c/ Хорих ял эдэлж буй мэдээлэгч, гэрчийг хамгаалалтанд авахад эдлэх ялын 4/1 ээс доошгүй хувийг эдэлсэн байх, эсхүл 10 буюу түүнээс дээш, бүх насаараа хорих ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн хэргээ өөрөө хүлээсэн байх шаардлагатай

d/ Төв комисс хамгаалалтанд авах талаар шийдвэр гаргахдаа дараах этгээдийн зөвшөөрлийг үндэслэнэ:

1. Дотоод яамны Төрийн нарийн бичгийн даргын орлогч

2. Хоёр шүүгчийн болон прокурор

3. Зохион байгуулалттай гэмт хэргийн чиглэлээр ажилладаг таван мэргэжилтний тодорхойлолт

е/Бичиг баримтын өөрчлөх хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тухайн бичиг баримтыг Төв комисс баталгаажуулна гэсэн заалтууд тус тус шинээр оржээ.

Тайланд улс

Гэрч хамгааллын тухай 2003 оны хууль батлагдаж гэрчийг нүүлгэн шилжүүлэх, байнгын хамгаалалтанд авах, иргэний бичиг баримтыг нь өөрчлөх зэрэг тусгай хамгаалалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж бүрдсэн. Уг хуулиар дараах төрлийн гэмт хэргүүдэд дээрх арга хэмжээг хэрэгжүүлэхээр заажээ. Үүнд: хар тамхи худалдаалах; Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг; зохион байгуулалттай гэмт хэрэг; авилга, албан тушаалын гэмт хэрэг; мөнгө угаах; хилээр хууль бусаар эд зүйл нэвтрүүлэх; хүн худалдаалах гэмт хэрэг болон ял шийтгэлийн доод хэмжээ нь 10 жилээс дээш байх гэмт хэргийн гэрчийг хамгаалалтад авахаар тус тус хуульчилсан байна.

Бусад улсын эрх зүйн зохицуулалтын чиг хандлагыг судлан үзвэл гэрч, хохирогчийг хамгаалах, тэдэнд туслалцаа үзүүлэх зорилгоор эрх зүйн бие даасан зохицуулалтыг бий болгож, үүний үр дүнд гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо бүрэлдсэн байна.

Манай орны хувьд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг олон нийтэд сурталчилхаас гадна шүүх, прокурор, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар, цагдаагийн алба, тахарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон холбогдох яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах зайлшгүй шаардлагатай. Мөн гэрч, хохирогчид туслалцаа үзүүлдэг мэргэжлийн байгууллагууд, нийгмийн бүлгүүдийн үүрэг, оролцоо тодорхой бус байгаа бөгөөд гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хадгалах, тэдэнд нийгмийн үйлчилгээ үзүүлэх нэгдмэл систем үгүйлэгдэж байна.

2013 онд УИХ-аас батлан гаргасан “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийн бодит хэрэгжилтийг хангах тусгай хөтөлбөрийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо үүсэх боломж бүрдэх юм.

Эцэст нь гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлэх нь хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас ихээхэн хамаарах зүйл билээ.



Б.БЯМБАБААТАР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ЧИГ ХАНДЛАГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрх зүйн шинжлэх ухаанд “Цагдан хорих” ойлголтыг хэрхэн тодорхойлсныг манай орны зарим эрдэмтэн, судлаачдын ном зохиолоос авч үзэхэд: академич С.Нарангэрэл (латин-arrestum: англи- confinement under guard: орос-заключение под стражу) – эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг[110] юм гэж бичсэн байх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлтэй холбон дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан байдаг.

Мөн хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугаацаагаар нийгмээс тусгаарлаж эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”[111] гэж тодорхойлжээ.

---

[110]С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2дахь хэвлэл. УБ. 2008 он. 552 дахь тал

[111]Б.Бат-Эрдэнэ .“МУ-ын ЭБШЭЗ-н Ерөнхий анги” УБ. 2004 он 265 дахь тал.

2013 онд УИХ-аас батлан гаргасан “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай” хуулийн бодит хэрэгжилтийг хангах тусгай хөтөлбөрийг батлан, үр дүнтэй хэрэгжүүлснээр гэрч, хохирогчийг хамгаалах, туслалцаа үзүүлэх нэгдсэн тогтолцоо үүсэх боломж бүрдэх юм.

Эцэст нь гэрч, хохирогчийг хамгаалах хөтөлбөрийг үе шаттайгаар амжилттай хэрэгжүүлэх нь хууль хэрэгжүүлэгчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвараас ихээхэн хамаарах зүйл билээ.



Б.БЯМБАБААТАР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Харуул хамгаалалтын тэнхимийн ахлах багш, хошууч

ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ, ЧИГ ХАНДЛАГА, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Эрх зүйн шинжлэх ухаанд “Цагдан хорих” ойлголтыг хэрхэн тодорхойлсныг манай орны зарим эрдэмтэн, судлаачдын ном зохиолоос авч үзэхэд: академич С.Нарангэрэл (латин-arrestum: англи- confinement under guard: орос-заключение под стражу) – эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хэрэг бүртгэх мөрдөн байцаах, эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх явцад, мөрдөн байцаалтын тусгаарлах байранд албадан хязгаарлах таслан шийдвэрлэх арга хэмжээний нэг[110] юм гэж бичсэн байх бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 68 дугаар зүйлтэй холбон дэлгэрэнгүй байдлаар тайлбарласан байдаг.

Мөн хууль зүйн ухааны доктор, профессор Б.Бат-Эрдэнэ “Цагдан хорих гэдэг нь сэжигтэн, яллагдагчийг шүүгчийн зөвшөөрлөөр, тодорхой хугаацаагаар нийгмээс тусгаарлаж эрх чөлөөг нь хязгаарлах албадлагын арга хэмжээ мөн”[111] гэж тодорхойлжээ.

---

[110]С.Нарангэрэл. “Эрх зүйн эх толь бичиг” 2дахь хэвлэл. УБ. 2008 он. 552 дахь тал

[111]Б.Бат-Эрдэнэ .“МУ-ын ЭБШЭЗ-н Ерөнхий анги” УБ. 2004 он 265 дахь тал.

Өнөөгийн байдлаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай” хууль, “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хууль, “Эрүүгийн байцаан шийтгэх” хуулийн холбогдох заалтын хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа хорих анги, цагдан хорих байрууд нь сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хорих, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэн, хүний эрхийн хангах, хорих байрны ахуй нөхцөлийг олон улсын жишиг, стандартад нийцүүлэх арга хэмжээг идэвхтэй зохион байгуулан ажиллаж байна.

Манай орны хууль тогтоох байгууллага “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн шинэчилсэн найруулгыг 2002 оны 01-р сарын 10-нд баталж, 2002 оны 09-р сарын 01 нээс түүнийг улс орон даяар мөрдөж эхэлсэн бөгөөд хуулийг хэрхэн нэг мөр ойлгож хэрэглэж, ялангуяа цагдан хорих таслан сэргийлэх ажиллагааг яаж хэрэглэж байгааг судлан, илэрсэн зөрчил, дутагдлыг давтан гаргуулахгүй байх арга хэмжээг тууштай зохион байгуулахад онцгойлон анхаарал хандуулж ирсэн.

Эрүүгийн байцаан шийтгэх энэ хуулийн 68 дугаар зүйлд: “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн бол түүнийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сэргийлэх зорилгоор цагдан хорьж болно”[112] гэж заасан.

Өмнө нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтнаас оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан бол хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорьж болно. Цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч энэ тухай үндэслэл бүхий тогтоол үйлдэж, прокурорт танилцуулах бөгөөд прокурор нь шүүхэд танилцуулж батлуулна[113]... гэж заасан нь сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн гол эх сурвалж болон хуулийн дагуу хэрэгжүүлэх үндэслэлийн нэг болж байдаг. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дээрх заалтаас... хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтнаас оргон зайлж болзошгүй, эсхүл оргон зайлсан бол... гэсэн энэхүү заалт нь практикт зөрүүтэй байдлаар ойлгон хэрэглэсний улмаас хүний эрх эрх зөрчигдөх, тодорхой бус үндэслэлээр цагдан хорьж эрх чөлөөг нь хязгаарлах эрсдэлтэй тул ихээхэн маргаан дагуулдаг.

Шүүгч цагдан хорихоос татгалзсан бол сэжигтэн яллагдагчийг дахин цагдан хорих саналыг зөвхөн цагдан хорих шинэ, үндэслэл шалтгаан бий болсон тохиолдолд шүүхэд ирүүлнэ. “Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах, түүнийг хүчингүй болгох,

---

[112] “Төрийн мэдээлэл” эмхэтгэл. 2002 он, 12 дугаарт

[113] “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 2002 оны, 12 дугаарт.

өөрчлөх талаар гаргасан шүүхийн шийдвэрт, тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид , түүний эзгүйд томилсон шүүгчид гаргана. Иймм гомдлыг 48 цагийн дотор хянан шийдвэрлэнэ” гэсэн заалт нь Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хүний эрхийг хангах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн зүгээс сэжигтэн, яллагдагчийг хууль бусаар хорих, хуулийг буруу хэрэглэх явдлаас сэргийлсэн шинжтэй заалт боловч сэжигтэн яллагдагчийг цагдан хорих хуулийн үндэслэл шаардлагыг илүү чангатгах, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх процессыг боловсронгуй болгох шаардлага байсаар байна.

Өнөөдрийн байдлаар 2002 онд батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль” болон 1999 онд батласан “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль”-ийн хүрээнд цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа зохицуулагдаж байгаа бөгөөд цаашид эдгээр хуулийн бүтэц, агуулга, зохицуулалтын хүрээнд нилээдгүй өөрчлөлт, шинэчлэлт хийгдэх нь тодорхой болоод байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хэмжээнд сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд цагдан хорих байрны албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, шуурхай, энэрэнгүй, хараат бус, хариуцлага хүлээдэг, сонор сэрэмжтэй, мэдрэмжтэй, шударга байх зарчмыг удирдлага болгон ажиллах байдлыг хэвшил болгох шаардлага зүй ёсоор гарч ирнэ. Мөн алба хаагчдын мэдлэг ур чадвараас гадна тэнд ажиллагчдын ажлын дотоод зохион байгуулалт, техник хэрэгслийн хүрэлцээ, өдөр дутмын хэрэгжүүлэх ажил үүргийн хувиар, хөтлөгдөх баримт бичгийн жагсаалт, тодорхой нэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх аргачлал зэргийг тодорхой болгон журамлах зэрэгт гол анхаарлаа хандуулж, тодорхой ач холбогдол өгөн эрчимтэй ажил, арга хэмжээг авах болсон юм. Тухайлбал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас цагдан хорих болон бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тодорхой стандарт тогтоох үүднээс хэд хэдэн журмыг шинээр баталж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

<u>ШШГЕГ-аас Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд холбогдох журам, :</u>

1. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/209 дугаар тушаалаар батласан “Баривчлах цагдан хорих байрны дотоод журам”[114];

2. Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн А/230 дугаар тушаалаар батласан “Хорих ангийн дотоод журам”[115];

3.Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн сайд, эрүүл мэндийн

[114] Баривчлах цагдан хорих байрны дотоод журам

[115] Хорих ангийн дотоод журам

сайдын хамтарсан 2005 оны 03 сарын 25 өдөр 7/64 дугаар тушаалаар батласан "Цагдан хоригдсон этгээдэд эмнэлгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх, цагдан хорих байранд эмнэлгийн мэргэжилтэн ирж үйлчлэх журам"[116];

4. Хууль зүйн сайдын 2014 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/229 дугаар тушаалаар батласан "Сахилгын байр, тусгаарлах тасалгааны нөхцөл, журам"[117];

5. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан 2008 оны өдрийн 205/94 дугаар тушаалаар батласан “Жишиг норматив тогтоох тухай”[118];

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар:

1.“Тогтоол гүйцэтгэх газрын Нэгдсэн эмнэлгээс хорих анги, цагдан хорих болон тусгай мэргэжлийн эмнэлгүүдийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах журам”[119];

2. Сэжигтэн, яллагдагч, ялтны нийтийн хоолны “Үлгэрчилсэн загвар”[120];

3.”Чанга, онцгой дэглэмтэй хорих анги, гяндангийн болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам” [121] зэргийг батлан үйл ажиллагаандаа мөрдөн ашиглаж байна.

Мөн хорих байгууллагын албан хаагчдын өдөр тутам үүрэг гүйцэтгэх ажлын байранд тавигдах нийтлэг шаардлага, шаардлагатай техник хэрэгслийн шалгуур үзүүлэлтийг тогтоосон, түүнчлэн хоригдогч, албан хаагчдын хоорондын харилцааны хэм хэмжээг тодорхойлсон нийт 8 төрлийн стандартыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Байгууллагын хэмжээнд хууль, эрхийн актийн шинэтгэл, бүтэц тогтолцооны томоохон өөрчлөлтүүд хийгдэж, түүнийг дагаад хоригдогсдын болон албан хаагч, иргэдийн аливаа хандлага хувьсан өөрчлөгдөж, эрх зүйн мэдлэг дээшлэх хандлагатай болсон. Иймд дээрх журам заавар, үйл ажиллагааны стандартууд нь цагдан хорих болон бусад төрлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэхэд нэн шаардлагатай байсан юм.

Нөгөөтэйгөөр цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд материаллаг нөхцөлийг сайжруулан хорих байрны барилга байгууламж, эрүүл ахуйн зэрэг бусад хэм хэмжээ, стандартыг дагаж мөрдүүлэх ажил чухал хүчин зүйл болдог. Иймээс цагдан хорих шийдвэр гүйцэтгэх

---

[116] Цагдан хоригдсон этгээдэд эмнэлэгийн тусламж үзүүлэх, түүнийг эрүүл мэндийн байгууллагад эмчлэх. цагдан хорих байранд эмнэлэгийн ажилтан ирж үйлчлэх журам

[117] Сахилгын байр болон тусгаарлах өрөөний нөхцөл журам

[118] Хууль зүй, дотоод хэргийн сайд. Нийгмийн хамгаалал. хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаал

[119] Тогтоол гүйцэтгэх газрын нэгдсэн эмнэлгээс хорих анги цагдан хорих болон тусгай мэргэжлийн эмнэлгүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллах журам

[120] Сэжигтэн. яллагдагч. ялтны нийтийн хоолны үлгэрчилсэн загвар

[121] Чанга. Онцгой дэглэмтэй хорих анги болон Гяндангын болон цагдан хорих төвийн гадна хамгаалалтыг зохион байгуулах журам

ажиллагаанд холбогдох стандартуудыг батлан мөрдөж ажиллаж байна:

1.“Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт” /CS 11-0238-2013/ [122] . Уг стандартын төслийг Улсын ерөнхий прокурорын газар, Хүний эрхийн үндэсний комисс, “Эмнэсти интэрнэшнл” зэрэг байгууллагад хүргүүлэн, санал дүгнэлтийг нь авч боловсруулсан.

2.“Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт”/CS 11-0237:2013/ [123] зэрэг батлагдсан байна.

Дээрх стандартуудыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих анги, баривчлах, цагдан хорих байр тэдгээртэй адил дэглэм бүхий байгууллагууд дахь мэргэжлийн үйл ажиллагааны төлөвлөлт, хэрэгжилт болон судалгааны арга, хэлбэрийг тодорхойлох зэрэг үндсэн чиглэлийг хамарч, ажлын үр дүнг үнэлэх, холбогдох байгууллагаас үйл ажиллагаанд нь хяналт тавихад ашиглана. Улмаар хорих байгууллагын бүх албан тушаалтан мөрдөх нэгдсэн дүрэм тогтоож хорих анги, албаны болон мэргэжлийн онцлогийг тусгасан үйл ажиллагааны баримтжуулалтыг нэмэлтээр тогтоож, баталгаажуулан мөрдүүлэх нь практикт чухал ач холбогдолтой юм.

Цаашид харуул хамгаалалтын болон бусад албан хаагчдын албан үүргээ зохих хэмжээнд хэвийн гүйцэтгэх нөхцөл боломжийг бүрдүүлэн хоригдсон этгээдийг олон нийтээс тусгаарлах, тэднээс үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, түүнчлэн тэдний аюулгүй байдлыг хангах, хорих байгууллагын албан хаагчдын өдөр тутам гүйцэтгэх үйл ажиллагааг тодорхойлсон хууль, журам, хэм хэмжээг нэг мөр хэрэгжүүлэх, хөтлөгдөж буй баримт бичгийн агуулга,загварыг батлах, бүрдлийг сайжруулах, үйл ажиллагааны баримтжуулалтад тавигдах нийтлэг шаардлагыг тогтоож, мөрдүүлэх зорилготой ажлыг тогтмол зохион байгуулах ёстой.

Эдгээр онолын болон практик шинжтэй ажиллагаануудыг тодорхой судалгаанд үндэслэн цогц байдлаар авч хэрэгжүүлснээр сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зорилго хангагдах боломжтой юм. Ингэснээр сэжигтэн яллагдагчийн эрх зүйн байдлыг хуульд заасан хэмжээнд хангаж ажиллахаас гадна, албан хаагчдын ажлын нөхцөл боломжийг дээшлүүлэх, эрх ашиг, аюулгүй байдлыг хангах тухай асуудал хурцаар тавигдах хандлагатай байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хүний эрхийг хангах, хорих нөхцөл, журмыг сайжруулах шат дараалсан олон арга хэмжээг авч хэрэгжүүлж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдийн байдлаар зөвхөн цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр зохион байгуулалтын дараах ажлуудыг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

---

[122] Хоригдогсдын эрхийг хангахад чиглэсэн цагдан хорих, хорих ял эдлүүлэх ажиллагааны стандарт

[123] Цагдан хорих төвийн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандарт

2013-2015 онд шинээр Өвөрхангай аймгийн Хархорин дахь шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг хорих 423 дугаар ангийн хамгаалалтын бүсэд шилжүүлэн байршуулсан. Булган аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны цагдан хорих байрыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дотоод орлогын эх үүсвэрээр 272 сая төгрөгийн өртөг бүхий 50 хоригдогчийн багтаамжтай, 16 хорих өрөөтэй олон улсын жишигт нийцсэн цагдан хорих байр Орхон аймаг дахь Шийдвэр гүйцэтгэх албаны 250 хоригдогчийн багтаамжтай цагдан хорих, хорих ял эдлүүлэх байр Увс, Дорнод, Дундговь, Говь-алтай, Зүүнхараа дахь Шийдвэр гүйцэтгэх албадууд 200- 650 сая төгрөгийн өртөгтэй 80-100 хоригдогчийн багтаамж бүхий цагдан хорих байруудыг ашиглалтанд оруулсан зэрэг олон төрлийн бүтээн байгуулалт, цагдан хорих байрны орчин нөхцлийг дээрдүүлэхэд чиглэгдсэн ажлуудыг эрчимтэй өрнүүлж байгаа нь цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн чухал ач холбогдолтой ажил болж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд Цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хүрээнд хийгдэж буй зарим ажлуудын /Нийт 25 цагдан хорих байр/ 2015 оны жилийн эцсийн тоон үзүүлэлтийг авч үзэхэд:

2013-2015 онд цагдан хорих 461 дүгээр анги болон аймгуудын цагдан хорих байрны баривчлах байранд шинээр 7767 хоригдогчийг хүлээн авч, хорих ангид 2061, баривчлах ял эдлүүлэх байранд 774 ялтныг шилжүүлж, 923 хоригдогч суллагдаж, 1759 батлан даалтанд гаргаж ажилласан бөгөөд 2015 оны хагас жилийн байдлаар 1188 сэжигтэн, яллагдагч хоригдож байна [124] . Хоригдсон этгээдийн гаргасан гэмт хэрэг, зөрчлийг авч үзвэл 2011-2013 онд буурч 2014 онд өсч 2011-2015 онд буурсан үзүүлэлттэй байна.

№	Зөрчил	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	Нийт
1	АХ-ын хууль ёсны шаардлага эсэргүүцсэн	24	7	10	3	20	64
2	Бусдыг зодож дарамталсан	13	8	10	18	12	61
3	Гар утас ашигласан	17	8	2	17	16	60
4	Хориотой эд зүйл хадгалсан	12	16	15	2	1	46
5	Эд зүйл булаасан, дээрэмдсэн	8	0	2	0	1	11
6	Бусдын биед гэмтэл учруулсан	0	6	0	0	1	7
7	Архи уусан	0	0	0	0	0	0

Дүгнэлт

Манай улсын цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тулгамдаж буй дараах асуудлууд байна. Үүнд:

А. Хоригдогчдын эрх зүйн байдал

Б. Хорих хугацаа

В. Хорих нөхцөл

[124] Н.Гантулга “Хүний эрх ба хорих ял” УБ хот 2015он 192-р тал


Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, албан хаагчдыг идэвхжүүлэн алдаа дутагдал, ололт амжилтыг дүгнэн, ажлын харилцан уялдаа холбоог нягтруулж, харуул хамгаалалтын хяналт сул цэгт телекамер нэмж суурилуулан, ашиглалт, эвдрэл гэмтлийг засварлуулж, цагдан хоригдогч, ялтны хоол, хүнс, ахуй нөхцөлд анхаарч ажилласнаар хоригдогчийн үйлдэх зарим төрлийн зөрчил тодорхой хувиар буурсан үзүүлэлт гарч байна.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад сэжигтэн яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажил үүргийн чухал хэсэг болжээ.


Санал

1. Őууль зżй, доňоод őэđăčйн ńŕйд, Нčййăĕčйн őŕĕăŕŕлŕл, őşдşлĕşđčйн ńŕйдűн 2008 онű 205/94 дугаар хамтарсан тушаалаар батласан “Жčř čă нođĕŕńčв” нэг мөр баримтлан цагдан хорих байрны орон тоог тогтоож бие бүрэлдэхүүн орон тоогоор ажиллуулах. Мөн орон нутгийн цагдан хорих байранд нийгмийн ажилтан, эмч, сэтгэл зүйчийн орон тоог бий болгох.

Хоригдогсдоос гарсан зөрчлийн тоон үзүүлэлт



Хоригдогсдоос гарсан зөрчил



Үүнээс албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн



2. Албан хаагчдын ажлын байрны орчин нөхцлийг сайжруулах, үйл ажиллагааг нь журамлан тодорхойлсон эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгох, хөтлөх баримт бичгийн нэгдсэн стандартыг тогтоон мөрдүүлэх болон хоригдогчдыг олон нийтээс тусгаарлах, үйлдэж болзошгүй гэмт үйлдэл, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, аюулгүй байдлыг хангах чиглэлээрх судалгааны ажил, практик ажилтнуудын санал санаачлагыг дэмжин ажил хэрэг болгох.



О.БАЯРЖАРГАЛ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажлын тэнхимийн багш, ахлах дэслэгч

ШИНЭЭР ИРСЭН ЯЛТАНД ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН АЖЛЫН ГАДААДЫН ОРНУУДЫН ТУРШЛАГА

Түүхэн хугацааны туршид гяндан, шорон, колони, хорих анги хэмээн нэрлэгдэж ирсэн байгууллагад шинээр хорих ял эдлэхээр ирсэн хоригдогчдын хувьд хорих ангид ямар орчин нөхцөл хүлээж байгаа бол, албаны болон ялтны зүгээс харилцах харилцаа ямар байх бол, ард үлдсэн амьдрал хэрхэх бол гэх мэт олон бэрхшээлтэй тулгардаг тиймээс энэ асуудлыг шийдвэрлэх мэргэжилтэн шаардлагатай төдийгүй хорих байгууллагын нийгмийн ажил цаг үеээ даган хэрэгцээ шаардлага нь өсөн нэмэгдсээр байна. Мөн ялтныг хорих ангид ирсэн цагаас суллагдан гартал нийгмийн ажлын үйлчилгээг тасралтгүй хүргэх нь чухал бөгөөд үүнийг энэхүү илтгэлийн хүрээнд гададдын зарим орны туршлагуудыг харьцуулан авч үзлээ:

Швейцарийн хорих байгууллага дахь нийгмийн ажил

Швейцарийн хорих байгууллагын нийгмийн ажил нь дотроосоо болон гаднаас гэсэн хоёр хэлбэрээр явагдах бөгөөд тэдний үйл ажиллагааны туйлын зорилго нь ял эдэлж байгаа хүмүүсийг дахиад хорих ангид эргэж ирэхгүй байхаар хүмүүжүүлэхэд оршдог.

Швейцарийн хорих байгууллагын нийгмийн ажил хоёр төрлийн загвараар явагддаг.

Нэгдүгээр загвар:

Хүн амын нийгмийн асуудлыг бүхэлд нь хариуцсан ажилтнууд хоригдогчдыг давхар хариуцах буюу хорих ангид тогтмол ирж хоригдогчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэдэг хэлбэр юм. Энэ загварын сайн тал нь тухайн ажилтан хот, орон нутгийн нийгмийн асуудал эрхэлсэн байгууллага хүмүүстэй байнга харилцаж байх бололцоотой учраас хоригдогчдын нийгэмшилт, нийгэмд дасан зохицох талаарх үйл ажиллагаанд илүү үр дүнтэй байдаг.

Энэхүү нийгмийн ажлын төвлөрсөн бүтэц нь хувийн компани, олон нийтийн болон шашны байгууллага зэргийг хоригдогчдод туслуулахаар татан оролцуулахад ч илүү дөхөм байдаг. Жишээ нь Базель мужийн нийгмийн албанд хоригдогчидтой ажилладаг байнгын 5, түр 1 ажилтантай байх жишээтэй. Тэд өдөрт 500-600 үйлчлүүлэгчтэй ажиллах бөгөөд нийгмийн тусламжийн асуудал эрхэлсэн 4 хувийн байгууллагатай хамтран ажилладаг байна. Сүүлийн жилүүдэд үйлчлүүлэгчиддээ дээд зэргийн итгэл хүлээлгэж нийгэмшүүлэх арга амжилттай хэрэгжиж байна. Ингэхдээ хоригдогчтой эхнээс нь авхуулаад гаран гартал нь, тэр тусмаа нэг ажилтан дагнан ажиллаж байнга уулзаж ярилцдаг байна.

Ердийн нөхцөлд хоригдол нийгмийн ажилтантай уулзах

хүсэлтийг хорихын захиргаагаар уламжлан тавих ба гадуур ажилладаг нийгмийн ажилтан нь 10 хоногийн дотор ирж уулзан тулгарсан асуудлыг хамтран шийдвэрлэх төлөвлөгөө гаргаж ажилладаг.

Нийгмийн албаны үйл ажиллагааг үр дүнтэй явуулахад ажилтнуудын сонголтыг зөв хийх нь чухал ач холбогдолтой. Нийгмийн албанд дээд болон тусгай дунд боловсролтой, мэргэжлийн дагуу нэмэлт сургалт хийсэн буюу ажиллаж байх хугацаандаа гурван жилийн сургалтад хамрагдсан мэргэжилтнүүд ажилладаг. Түүнчлэн урьд өмнө ял шийтгэл хүлээж байгаагүй хүмүүс ажиллах шаардлага тавигддаг.

Хоёрдугаар загвар

Асуудлыг шийдвэрлэхэд тусалдаг. Мөн хоригдогчдын байгаа газраар явж ажиллана. Хоригдогчдыг анх ирж карантинд 2-3 сар байхад нь нэг бүрчлэн уулзаж тэднийг судалдаг байна. Швейцарьт 600 хоригдолтой ангид 5-6 нийгмийн ажилтан буюу нэг ажилтанд 60-80 үйлчлүүлэгч ноогддог.

Нийгмийн ажилтны албан үүрэгт шинээр ирсэн ялтанд үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

1. Хоригдогчийг судалж дүгнэлт хийх, түүний нийгмийн хэлхээ холбоо, нийгмийн хэм хэмжээг зөрчсөн байдал, тулгамдсан асуудал, нийгмийн бэрхшээлүүдийг судлах,

2. Түүний нийгмийн асуудлыг ял эдлэх хугацаанд шийдвэрлэх төлөвлөгөөг хамтран гаргах,

3. Дээрх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж шаардлагатай туслалцаа үзүүлэх,

4. Хоригдогчтой холбогдолтой бүхий л баримт бичгийн бүрдлийг хөтлөх (сайшаал, шийтгэл гэх мэт),

5. Хоригдлын гэр бүл, санхүү, эд хөрөнгө, тэтгэврийн зэрэг асуудлыг шийдвэрлэх,

6. Ар гэрийнхэнтэй нь холбоо бариулах, ажил, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулах,

Нийгмийн ажилтан хоригдогчийн зөвхөн өөрөө хүсэлт тавьсны дагуу үйл ажиллагаа явуулдаг, нэг үгээр хэлбэл шаардлага гарсан үед ажилладаг гэсэн үг юм.

АНУ-ын хорих байгууллагын нийгмийн ажил

АНУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагууд нэг талаас хууль зүйн сайд, нөгөө талаас тухайн оршин буй нутаг дэвсгэрийн засаг захиргаанд давхар харьяа-лагддаг. АНУ-д дараах гурван төрлийн хорих байдаг.

1. Дээд зэргийн хамгаалалтын түвшинтэй буюу хоригдлууд бусдаас, түүний дотор албан хаагчдаас тусгаарлагдсан.

2. Хамгаалалтын дунд түвшний буюу хоригдлууд хорих дотроо салхинд гарах, номын сан, усанд орох газар зэрэгт очих боломжтой.

3. Хамгаалалтын хялбаршуулсан түвшний хорих буюу хоригдлууд нэгдсэн байранд байрлаж хорих дотроо бараг чөлөөтэй явах боломжтой, гадна хашаа, торгүй.

Хамгаалалтын дунд болон хялбаршуулсан түвшнийхэн нийгмийн

ажилтан, өмгөөлөгч, сэтгэл мэдрэлийн эмчийн туслалцааг авч болох бөгөөд дунд сургуулийн болон их сургуулийн хөтөлбөрөөр боловсрол эзэмших, мэргэжил эзэмших сургалтанд хамрагдах, согтуурах болон мансуурлын хамаарлаас гарах эмчилгээ хийлгэх, шашны зан үйл гүйцэтгэх боломжтой.

АНУ-д нийгмийн ажилтан сэжигтнийг урьдчилан хорих байгууллагад байхад нь ажиллаж эхлэх бөгөөд шүүхийн даалгавраар тухайн хүний талаар болон ойр дотных нь хүмүүсийн тухай лавлагаа бэлтгэж, шүүх хуралд танилцуулна. Энэ мэдээлэл шүүх хурлын явцад болон тухайн хоригдолтой цаашид ажиллахад хэрэгтэй зүйл болдог.

Хорих байгууллага дахь нийгмийн ажлын зорилго нь хоригдогч бодит байдлыг сайтар ойлгож хувь заяагаа өөрчлөх шаардлагатайг мэдрүүлэхэд оршино. Үүний тулд хоригдогчтой үр ашигтай агуулга бүхий харилцаа тогтоож, зөв оношлон ажиллах бэлтгэл хийх хэрэгтэй.

Хорихын доторх төрөл бүрийн гаж үзэгдлээс хоригдогчийг сэргийлэх, шаардлагатай үед түүнд туслах үүргийг нийгмийн ажилтан гүйцэтгэнэ. Мөн хоригдогчийн ар гэртэй ажиллах, гэр бүлд тулгамдсан сэтгэл зүйн асуудлууд, нийгмийн болон эдийн засгийн асуудлыг даван туулахад тэдэнд туслахад нийгмийн ажилтан чухал үүрэгтэй.

АНУ-ын шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудад гэмт хэргийг бууруулахад чиглэсэн олон хөтөлбөр байдаг бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд нийгмийн ажилтан шууд оролцоотой. Хоригдогчийг ирэнгүүт бусад ажилтны хамт хүн тус бүрээр судалж нэг бүрчлэн ажиллах хөтөлбөр боловсруулдаг. Тухайлбал:

1. Сэтгэл зүйн хөтөлбөр – шийтгэгдсэн ялаа үндэслэлгүй гэх буюу үүнээс хөнгөн ял авах байсан гэж үзэх, эсхүл ялын хугацаа богиноос бусад хөтөлбөрт оролцох хугацаа хүрэлцэхгүй хүмүүс хамрагдана.

2. Эрчимжүүлсэн буюу удаан хугацааны хөтөлбөр – бэлгийн хүчирхийлэл үйлдсэн, давтан гэмт хэрэгтэн, мансууруулах бодис хэрэглэгчид хамрагдана.

3. Дамжлагын хөтөлбөр – суллагдахад 9 сар үлдээд байгаа хүмүүс хамрагдана.

4. Өргөтгөсөн хөтөлбөр – Оюуны хомсдолтой хүмүүст зориулагдсан болно.

АНУ-д сүүлийн үед эрх чөлөөг нь хэсэгчлэн хязгаарлах, тухайлбал хорих байгууллагаас гадуур байж сурч, ажиллахаа хэвийн үргэлжүүлэх шийтгэлийн хэлбэр нэлээд түгээмэл болж байгаа бөгөөд үүнд нийгмийн ажилтны оролцоо чухал аж.

АНУ-ын хувьд нийгмийн ажилтан шүүхэд ч, хорих байгууллагад ч, мөн туршилтын хугацаанд ч байнга оролцоотой байгаа нь тухайн хоригдогчдын засрал хүмүүжилд хяналттай, тасралтгүй нөлөөлөх, хорихын өмнөх болон суллагдсны дараа ч гэсэн хараа хяналттай байлгадаг туршлагатай.

Германы хорих байгууллага дахь нийгмийн ажил

Германы шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомж нь хоригдлыг нийгмийн өмнө хариуцлага хүлээхүйц нийгэмшүүлэхээр засан хүмүүжүүлэх зорилго агуулсан байна. Энэ зорилтын үндсэн ачааллыг хорих байгууллагын нийгмийн алба үүрдэг. Иймээс Хууль зүйн яамнаас хорих байгууллагуудад нийгмийн ажилтан, лам, сэтгэл зүйч ажилладаг байна.

Нийгмийн ажилтан нь хорих байгууллага болон нийгмийн хооронд орших амьд гүүр болдог байна.

Нийгмийн ажилтнууд хоригдогчдыг анх ирэхэд захиргааны зүгээс хамгийн түрүүнд уулздаг бөгөөд ар гэртэй нь холбоо барих, ямар нэгэн асуудал байвал түүнийг шийдвэрлэж өгөхийг санал болгодог. Тэдний үйл ажиллагааны нэг үндсэн зарчим бол өнөөгийн хоригдол хэзээ нэгэн цагт нийгэмд эргэн орж бүрэн эрхт гишүүн болно гэдгийг ухамсарлаж байдагт оршдог.

Германы хорих байгууллагын нийгмийн албанд нийгмийн ажилтан, сурган хүмүүжүүлэгч багтдаг бөгөөд энэ алба нь тус байгууллагын салшгүй хэсэг юм. Тус албаны үйл ажиллагаа нь шийдвэр гүйцэтгэлийн хууль тогтоомжийн хэм хэмжээгээр зохицуулагддаг. Герман улсад нэг нийгмийн ажилтанд 70-80 хоригдол байхаар зохицуулагдсан. Нийгмийн ажилтны тоо багш, эмч, сэтгэл зүйчийн тооноос 2,5 дахин, санваартнуудын тооноос 4 дахин илүү байхаар зохицуулагдсан байна. Эдгээр мэргэжилтнүүд нийгмийн штаб буюу албанд багтдаг бөгөөд аюулгүй байдал болон дэглэмийн гэсэн албадтай зэрэгцэн ажилладаг.

Германы хорих байгууллагын нийгмийн ажлын зохион байгуулалтад хэд хэдэн онцлог байдаг. Тухайлбал, шашны үүрэг нэлээд их байдаг. Хорих байгууллага бүрт католик юмуу протестант шашны санваартнууд хоригдлуудтай ажилладаг ба бүр суллагдсаны дараа нь хүртэл холбоотой байдаг байна.[125]

Хоригдогчдыг хорих ангид ял эдлэх хугацаанд хэд хэдэн үе шатанд хуваан авч үздэг.

Нэгдүгээрт: Хорих байгууллагын нөхцөлд дасах үе

Хоёрдугаарт: Засран хүмүүжих

Гуравдугаарт: Суллагдахад бэлтгэгдэх

Ял эдлэх бүхий л үе шатанд тэднийг нийгмийн ажилтан судалж үе шат бүрт төлөвлөгөө гарган ажиллаж дүгнэж байдаг. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдах зүйл нь:

1. Хаалттай болон нээлттэй хорихын аль нөхцөлд байх
2. Эн тэнцүү харьцаа бүхий хэсэгт бусадтай хамт байх эсэх
3. Ажил хийх, мэргэжил эзэмших, мэргэшил дээшлүүлэх болон давтан бэлтгэхэд хамрагдах
4. Ерөнхий боловсролын мэдлэгээ дээшлүүлэх
5. Тусгайлсан тусламж үзүүлэх
6. Ял эдлэх нөхцлийг хөнгөрүүлэх
7. Суллагдахад бэлтгэх шаардлагатай ажил гүйцэтгэх.

[125] Лузгин С.А, Кузнецов М.И, Казанцев Б.Н “Хорих байгууллагын нийгмийн ажил” УБ 2009 он

Хоригдогчийн өөрчлөлтийн байдал болон түүнийг судлах явцад гарч болзошгүй нэмэлт зүйлийг үндэслэн төлөвлөгөөг засварлаж болох бөгөөд ял эдлэх хугацааг харгалзан төлөвлөх ёстой.

Хоригдол оршин сууж байгаа байрандаа өөрийн эд зүйлээ зохих хязгаартайгаар байрлуулах эрхтэй.

Ойр дотных нь хүмүүсийн гэрэл зураг, мөн өөрт нь чухал зүйлсийг байлгахыг зөвшөөрдөг. Энэ нь сэтгэл зүйн хувьд хоригдол нь хүнийхээ хувьд өөрийгөө хадгалан үлдэх, ар гэрийнхэнтэйгээ холбоотой байх зэргээр нийгмийн ажлын хувьд туйлын чухал зүйл юм.

Нийгмийн ажилтны үүрэг нь хоригдолд нийгмийн дэмжлэг үзүүлэхэд оршдог. Тухайлбал: Хоригдлуудад тулгараад байгаа нийгмийн асуудлыг гаргаж тавих, хувь хүний тухайд болон хүмүүс хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэх, харилцааны соёл, харилцан зөвшилцөл, тэвчээртэй байхыг хэвшүүлэх, нийгмийн тусламжийн эх үүсвэрийг эрж хайх, боловсрол олоход нь туслах гэх мэт. Энэ утгаараа нийгмийн ажилтан хоригдогчийг эхнээсээ аваад ялаа дуусан дуустал хамт явна гэсэн үг юм.

Францын хорих байгууллагын нийгмийн ажил

Шинээр ирсэн ялтныг ирсэн өдөр нь хүлээн авч эмчийн үзлэгт оруулан, үзлэг нэгжлэг хийж холбогдох анкетыг бүрдүүлдэг. Энэ нь тухайн ялтныг сэтгэл зүйн хямралыг үүсгэдэг гэж үзэн хямралыг даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ирснийх нь маргааш нийгмийн ажилтан ярилцлага хийдэг. Мөн гэр бүлийн мэдээллийг авч, хэзээ яаж уулзах болон зөвшөөрөгдсөн эд зүйлсийг нь танилцуулдаг байна. Долоо хоног тусгаарлах байранд байлгаад өрөөнд хувиарлана.

Нийгмийн ажлын алба нь шинээр ирсэн ялтныг долоо хоног ажиглаад сэтгэл зүйн болон орчны ямар дэмжлэг хэрэгтэй байгаа талаар ярилцаж төлөвлөгөө гаргаж ажилладаг байна. Үйлчлүүлэгч өөрөө нийгмийн ажилтнаас дэмжлэг авах, уулзахыг хүсэхгүй тохиолдолд хорих ангиас гарах хүртэл нь үйлчилгээ үзүүлэхгүй ч байж болдог байна. Нэг нийгмийн ажилтан 90-150 ялтантай ажилладаг байна.

Дүгнэлт

Гадаадын зарим орны хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын бүхий л арга, хэлбэр нь тэдэнд зан үйлийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээлт явуулах, хорих байгууллагад дасан зохицох, нийгмийн амьдралд бие даан оролцох, гэмт хэрэг, зөрчилд холбогдохгүй байхад чиглэгдэж, энэ ажилд ялтны гэр бүлийн гишүүд, найз нөхөд, асрамжийн болон нийгмийн халамжийн, шашны, боловсролын, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих байгууллагууд, түүнчлэн хууль сахиулах зэрэг төрийн болон төрийн бус, олон нийтийн оролцоо, хамтын ажиллагааг чухалчлан үздэг байна.

Бусад улс орны туршлагаас харахад шинээр ирсэн ялтанд үзүүлэх нийгмийн ажлын үйлчилгээнд ялтныг хүлээн авах үйл ажиллагаа, ялтныг байрлуулах, зөвшөөрөгдөх эд зүйлсийн

жагсаалт зэрэг нь манайд хийгддэг үйл ажиллагаатай холбоотой ижил төстэй асуудлууд нэлээдгүй байна. Тухайлбал: Ялтанд зөвшөөрөх эд зүйлсд боловсруулсан хүнсний болон гурилан бүтээгдэхүүн, ариун цэврийн болон ахуйн хэрэгцээний зүйлс, бугуйн цаг, аллага, хүчирхийлэл, садар самууныг сурталчилснаас бусад сонин, ном, сэтгүүл, нормын болон ээлжийн дотуур хувцас, спортын хувцас, хөлөгт, тоглоом, гэр бүлийн гишүүдийн гэрэл зураг, засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн 10 хувьтай тэнцэх хэмжээний бэлэн мөнгө зэрэг нь ижил төстэй зүйлийг эрх зүйн актуудаар зохицуулсан нь ажиллагдаж байна.

Харин шинээр ирсэн ялтны орчны нөлөөллөөс үүсэх сэтгэл зүйн хямрал, тэдний ар гэрийнхний сэтгэл зүйн таагүй байдал, тасралтгүй үргэлжлэх харилцаа холбоог нь хадгалах талаар анхаарал хандуулан ажиллах нь илүү чухал. Мөн орон нутгийн болон засаг захиргааны байгууллага, итгэл үнэмшлээр нь дамжуулан шашны байгууллагуудын оролцоо хорих байгууллагын нийгмийн ажлын үндсэн үйл ажиллагаанд сууж өгсөн байна. Тэд зөвхөн мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг орчин нөхцөл нь ч тийм байдлаар хангагдсан, нэг нийгмийн ажилтанд оногдох жишиг норматив нь харьцангуй цөөн байгаагаараа давуу талтай байна.

Ашигласан материал:

1. ШШГЕГ-ын даргын 2010 оны А/107 дугаар тушаалаар батласан “Хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны нийгмийн ажилтны ажлын заавар”

2. Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/230 дугаар тушаалаар батласан “Хорих ангийн дотоод журам”

3. Лузгин С.А, Кузнецов М.И, Казанцев Б.Н “Хорих байгууллагын нийгмийн ажил” УБ., 2009 он

4. Мягмар.О “Хувийн дасан зохицохуй” УБ., 2000 он

5. Мягмар.О “Сэтгэл судлал” УБ., 2007 он

6. Мягмар.О “Судлаач багшийн гарын авлага” УБ., 2009 он

7. Нямдорж.Н, Түмэннаст.Г, Мягмарсүрэн.Б “Нийгмийн ажлын сургалтын гарын авлага” УБ., 2006 он



Б.ЭРДЭНЭ-ОЧИР
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн ахлах багш, хошууч

ҮНЭТ ЗҮЙЛСИЙН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТ

Шийдвэр гүйцэтгэгч эд хөрөнгийг хураан авсанаараа түүний бүрэн бүтэн байдал хадгалалт хамгаалалт элэгдэл хорогдол зардалыг шууд хариуцдаг. Мөн нэгэнт хураагдсан эд хөрөнгийг төлбөр авагчид шилжүүлэх эсвэл үнэ хүргэн худалдан борлуулах шаардлагтай байдаг тул эд хөрөнгө хураан авахдаа анхаарах хэрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38.6 дугаар зүйлд: “Төлбөр төлөгчөөс хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг банкинд хадгалуулна” гэж заасан байдаг. Эдгээр эд хөрөнгийн үнэлгээ өндөр, ховор, дахин давтагдашгүй гэх мэт чанарыг агуулж онцгой хадгалалт, хамгаалалт шаардах учраас хуулинд заалт болгон оруулсан боловч шийдвэр гүйцэтгэгчид банкинд хадгалуулсан практикт байхгүй байгаа нь анхаарал татаж байна. Ингээд ямар эд хөрөнгийг хадгалуулах шаардлагатай талаар судалгаа хийж үзлээ.

Үнэт зүйл: Үнэт зүйлд үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валют шиг нэгдсэн ойлголт өгөх боломжгүй юмаа. Үнэт зүйлс гэдэгт археологи, түүхийн өмнөх үе, түүх, утга зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үзэж байгаа шашны буюу шашны бус шинж чанартай бөгөөд дор дурдсан ангилалд хамаарна. Үүнд:

1. Ургамал, амьтан, эрдэс, анатомын ховор дээжис, цуглуулга болон палентологийн ач холбогдолтой үнэт зүйлс;
2. Түүхийн үнэт зүйлс, тухайлбал, шинжлэх ухаан болон техникийн түүх дайн болон нийгмийн түүх, түүнчлэн үндэсний нэрт зүтгэлтэн, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчид болон үндэсний томоохон үйл явдалд холбоотой үнэт зүйлс;
3. Археологийн (ердийн болон нуугдмал) олдворууд буюу археологийн нээлтүүд;
4. Урлагийн болон түүхийн хөшөө дурсгал, археологийн ач холбогдол бүхий газрын бүрэлдэхүүн хэсгүүд;
5. 100 жилээс өмнөх үеийн бичээс, цутгамал, зоос, тамга, тэмдэг хуучны эд юмс;
6. Угсаатны зүйн материалууд;

Урлагийн дараах үнэт зүйлс

1. Юугаар үйлдсэнийг үл харгалзан бүхэлд нь гараар үйлдсэн бүх төрлийн зураг, уран зураг, зураасан зураг (барааны тэмдэг болон гараар үйлдсэн үйлдвэрийн бүтээгдэхүүнийг оруулахгүй);
2. Аливаа эдээр хийсэн баримал, уран баримлын эх бүтээлүүд;
3. Сийлбэр, бар, цутгамлын эх бүтээлүүд;
4. Аливаа эдээр хийсэн уран сайхны сонгомж, эвлүүлэг;
5. Ховор гар бичмэлүүд, хэвлэмэл зүйлс, эртний ном, судар, баримт бичиг

болон онцгой сонирхол татаж байгаа дангаараа буюу цуглуулгаараа байгаа хэвлэмэл бүтээл;

6. Дангаараа буюу цуглуулгаараа байгаа шуудангийн марк, татварын буюу түүнтэй адилтгах марк;

7. 100 жилээс өмнөх үеийн эртний модон тавилга болон хөгжмийн эртний зэмсгүүд;

8. Үндэсний нутаг дэвсгэрт олдсон соёлын үнэт зүйлс;

9. Соёлын үнэт зүйлсийн гарлын улсын эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр археологи, угсаатны зүй, байгалийн шинжлэх ухааны экспедицүүдийн олсон соёлын үнэт зүйлс;

10. Сайн дурын солилцоогоор олж авсан соёлын үнэт зүйлс6

Үнэт зүйлс нь овор хэмжээгээр жижиг ч, том ч, ямар ч материалаар хийгдсэн байж болох тул банкинд тэр бүр хадгалаад байх боломжгүй юм.

Үнэт металл

Металлыг зэврэлтэд онцгой тэсвэртэй физик, химийн шинж чанараар нь өнгөт, газрын ховор, хар, үнэт гэх мэтээр ангилдаг бөгөөд эдгээрээс үнэт металлын бүлэгт алт, мөнгө, платина, палладий, иридий, родий, рутений, осмий гэсэн найман металл багтдаг байна. Металлын агуулгыг аливаа металл хайлш биетийг 1.000 тэнцүү хэсэгт хуваахад хэдэн хэсгийг нь үнэт металл эзэлж байгааг тодорхойлдог бөгөөд үүнийг сорьц гэж нэрлэдэг байна. Монгол улсад алтан эдлэлийг 333, 375, 585, 750, 916, 960 мөнгөн эдлэлийг 875, 925,гэсэн сорьцоор үйлдвэрлэдэг юм байна.

Эрдэнийн чулуу

Эрдэнийн чулуу гэдэг бол байгалийн эрдсүүд бөгөөд хүн төрөлхтөн эрт дээр үеэс нүд баясгам өнгө үзэмжийг нь ашиглаж байсан бол одоо үед техник, технологийн хөгжилд өргөнөөр ашиглах болсон байна. Эрдэнийн чулууг гарал үүслийнх нь хувьд байгалийн, таримал /синтетик/, дууриамал, харин үнэлгээний талаас нь үнэт, хагас үнэт, гоёл чиэглэлийн, өнгөлгөөний гэж ангилдаг бөгөөд дотор нь: тунгалаг, хагас тунгалаг, тунгалаг биш гэж ангилдаг байна. Тунгалагийг дотор нь: өнгөтэй, өнгөгүй гэж ангилах бөгөөд өнгөгүй чулуун дотор доржпалам /алмаз/, циркон, цагаан индраанил, молор эрдэнэ, усан болор зэрэг нь зонхилдог.

Үнэт чулуу

1. Доржпалам /алмаз/
2. Улаан өнгөт бадмааараг /рубин/
3. Цэнхэр өнгөтэй Индраанил /сафир/
4. Ногоон өнгөтэй маргад /Изумруд/
5. Сувд гэсэн 5 төрөл байдаг.

Эрдэнийн чулууны жинг каратаар хэмжих бөгөөд энэ үг нь 2 өөр ойлголтыг илэрхийлдэг. Карат гэж бичсэн байвал үнэт металлын сорьц гэж ойлгодог бөгөөд К үсгээр тэмдэглэдэг. Хэрвээ 14К гэсэн тэмдэглэгээ байвал 585 сорьцтой алт байна гэж ойлгоно. Харин Carat гэж бичсэн байвал үнэт чулууны жин гэж ойлгох бөгөөд “ct” гэж тэмдэглэнэ. 1ct нь 0,2 гр буюу 200 мг-тай тэнцдэг аж. Томоохон чулуунуудыг грамм, килограммар хэмжих нь бий Харин сувдыг гран гэдэг нэгжээр хэмжих бөгөөд 1 гран нь 50 мг болдог байна.

Мөн доржпалам чулууг 57-58 ширхэг талст гарган зассан дугуй хэлбэрийн одлог засалтыг бриллант гэдэг.

Үнэт чулуунууд нь үл хөдлөх хөрөнгөөс дутахааргүй банкны баталгаа болох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч нар энэ талын наад захын мэдлэгтэй байх зайлшгүй шаардлагатай байна. Учир нь жинхэнэ чулуу, хуурамч эд, урлагийн бүтээлийг ялгаж сайн мэддэг байх нь ажиллагаанд сайнаар нөлөөлнө.

Банк

Энэ нэр томьёо нь banco /итали-мөнгө солих ширээ/ гэдэг үгнээс гаралтай гэж үздэг бөгөөд энэ нь дундад зууны үед италичууд өөрийн мөнгийг солилцдог байсан газрыг хэлдэг байжээ. Эртний Ассир, Вавилон, Герег, Ромын эзэнт улсын үед банкны үйл ажиллагааны анхны хэлбэр болох үнэт зүйлс хадгалах, гадаад орны зоосон мөнгө солих, арилжаа наймааны зориулалтаар зээл олгох зэрэг үйл ажиллагаа явуулж байжээ. Банк нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, эрсдэлгүй үйлчилгээ үзүүлэх, дэвшилтэт технологиор дамжуулан харилцагч иргэд, байгууллагын санхүүгийн хэрэгцээг найдвартай, түргэн шуурхай хангах замаар итгэлцлийг бий болгох үндсэн үүрэгтэй ажилладаг.

Валют

(итал. Valuta) гэдэг итали хэлнээс гаралтай үнэ өртөг гэсэн утгатай үг бөгөөд нэгээс нөгөөд хөрвөх хэлбэрээр улс хоорондын эдийн засгийн харилцаанд үйлчлэгч өндөр хөгжилтэй орнуудын мөнгөн нэгж юм. Валютыг тодорхойлбол үндэсний, гадаад, улс хоорондын худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөрт хэрэглэгдэж буй тооцооны нэгж, мөнгөжсөн алт болон валютын үнэт зүйлсийг хэлнэ.

Үндэсний валют

Эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий тухайн Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, түүгээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ.

Гадаад валют

Эргэлтэд байгаа төлбөрийн чадвар бүхий нэг буюу хэд хэдэн гадаад улсын мөнгөн тэдгээрээр илэрхийлэгдсэн бөгөөд олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг хэлнэ. Гадаад валютыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрснөөр чөлөөтэй хөрвөдөг ба чөлөөтэй хөрвөдөггүй гэж ангилна.

Мөнгөжсөн алт

Олон улсын жишигт хүргэн цэвэршүүлж, олон улсын санхүүгийн аль 1 төвд хадгалуулж байгаа, гадаад валютаар борлуулахад бэлэн болсон алтыг хэлнэ.

Валютын үнэт зүйлс

Мөнгөжсөн алттай адилтгах үнэт металл, үнэт металл, эрдэнийн чулууг хэлнэ.

Цэвэршүүлсэн алт

Алтны агуулгыг нь нэмэгдүүлж цэвэршүүлсэн боловч гадаад валютаар шууд борлуулах нөхцөл хангагдаагүй алтыг хэлнэ.

Дараах арилжааны банкнууд хадгалалтын үйл ажиллагааг хүссэн иргэн, хуулийн этгээдэд хүргэж байна.

Голомт банк:

№	Хайрцагны хэмжээ, урт, өргөн, өндөр	Шимтгэл
1.	600х 296х76 /хоногт/	300 төгрөг
2.	600х 298х 139 /хоногт/	400 төгрөг
3.	600х 298х 234 /хоногт/	500 төгрөг
5.	565х 306х 126х76 /хоногт/	350 төгрөг
6.	565х 306х 273 /хоногт/	500 төгрөг
7.	565х 306х 564 /хоногт/	700 төгрөг

Хадгалалтын гэрээний хугацааг сунгах бүрт 1000 төгрөгний шимтгэл авна. Түлхүүр гээгдүүлбэл хохирлыг нөхөн төлүүлнэ. Хадгалах хайрцагны түлхүүрийн барьцаа 100,000 төгрөг байна. 24 цаг хүртэл хугацааг нэг хоногт тооцно.

Хаан банк

№	Хайрцагны хэмжээ /мм-ээр/	Хадгалуулах хугацаа		
	өргөн 245,урт 550	1-ээс 30 хоног хүртэл	31-180 хүртэл хоног	181 хоногоос дээш
1 хоногт ноогдох хураамжаар				
1	Өндөр 65 мм	500 төгрөг	400 төгрөг	300 төгрөг
2	Өндөр 118 мм	600 төгрөг	500 төгрөг	400 төгрөг
3	Өндөр 220 мм	700 төгрөг	600 төгрөг	500 төгрөг
Түлхүүрийн барьцаа		100,000 төгрөг		
Түлхүүр үрэгдүүлсний торгууль		100,000 төгрөг		

Худалдаа хөгжлийн банк

Хайрцагны хэмжээ /см-ээр/	Хадгалуулах хугацаа			
Урт 60, өргөн 29,8	1-15 хүртэл хоног	15-30 хүртэл хоног	1-6 сар хүртэл	6 сараас дээш
Өндөр 7,6 см	400 төгрөг	300 төгрөг	250 төгрөг	200 төгрөг
Өндөр 13,9 см	500 төгрөг	400 төгрөг	350 төгрөг	300 төгрөг
Өндөр 23,4 см	600 төгрөг	500 төгрөг	450 төгрөг	400 төгрөг
Өндөр 35,1 см	700 төгрөг	600 төгрөг	550 төгрөг	500 төгрөг
Өндөр 70,6 см	800 төгрөг	700 төгрөг	650 төгрөг	600 төгрөг

Түлхүүрийн барьцаа 30,000 төгрөг
Түлхүүр үрэгдүүлсний торгууль 30,000 төгрөг, дээрх хуулийн заалттай холбогдуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монгол банк, эсвэл аль 1 арилжааны банктай хамтран ажиллах хадгалалтын гэрээ одоогоор хийгдээгүй байна. Шийдвэр гүйцэтгэгч нар хуулийн дагуу банкны үйлчилгээг авдаггүй нь доорх байдлаар тайлбарлагдана.

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, банкны хооронд хуулийн заалтыг дагасан журам байхгүй.

2. Аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг заавал банкинд хадгалуул гэж шахаж шаарддаггүй.

3. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц удааширсан, бага үнэлгээтэй эд зүйл, валют хураагдсан нөхцөлд хадгалалтынхаа зардлыг төлж дийлэхгүй хураагдах магадлалтай. Иймд энэхүү хуулийн заалтыг дагасан журмыг яаралтай батлах, хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын хамрах асуудлын хүрээнд тэжээн тэтгэх, тэр дундаа хүүхдийг тэтгэхтэй холбогдсон харилцаа онцгой байр суурийг эзэлдэг. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална гэж заажээ.[126]”

Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүртэл хамгаалахад энэ хуулийн үйлчилдэг.

---

[126] Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

2. Аймаг нийслэлийн шийдвэр гүйцэтгэх алба хураасан үнэт зүйл, үнэт металл, эрдэнийн чулуу, гадаад валютыг заавал банкинд хадгалуул гэж шахаж шаарддаггүй.

3. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны явц удааширсан, бага үнэлгээтэй эд зүйл, валют хураагдсан нөхцөлд хадгалалтынхаа зардлыг төлж дийлэхгүй хураагдах магадлалтай. Иймд энэхүү хуулийн заалтыг дагасан журмыг яаралтай батлах, хуулийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.



Б.БОЛОР-ЭРДЭНЭ
ХСИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн багш, ахлах дэслэгч

ХҮҮХДИЙН ТЭТГЭЛЭГ ГАРГУУЛАХ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЧИГ ХАНДЛАГА

Гэр бүлийн эрх зүйн зохицуулалтын хамрах асуудлын хүрээнд тэжээн тэтгэх, тэр дундаа хүүхдийг тэтгэхтэй холбогдсон харилцаа онцгой байр суурийг эзэлдэг. Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.11-д “Улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн эрх ашиг сонирхлыг төр хамгаална гэж заажээ.[126]”

Монгол улсад хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг Үндсэн хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль, Иргэний хууль, Гэр бүлийн тухай хууль болон бусад эрх зүйн баримт бичгээр зохицуулдаг. Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль хүүхдийг төрсөн цагаас нь эхлэн 18 нас хүртэл хамгаалахад энэ хуулийн үйлчилдэг.

---

[126] Монгол Улсын Үндсэн хууль – “Төрийн мэдээлэл” эмхтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн

Энэ хуулиар хүүхдийн хөгжих, хамгаалуулах, нийгмийн амьдралд оролцох, хүүхдийн эрхийг хамгаалахад төр, олон нийт, иргэд, байгууллагын оролцоо, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүрэг, хүүхдэд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээний талаар нарийвчлан зохицуулсан.

Мөн тус хуулийн 25 дугаар зүйлд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар заасан зохицуулалтын 4 дэх хэсэгт: Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн иргэнээр төлбөл зохих тэтгэлгийг төлүүлж, түүнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох буюу 30 хүртэл хоногоор баривчлахаар заажээ.

Гэр бүлийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-д “Эцэг, эх нь насанд хүрээгүй болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдээ тэжээн тэтгэх үүрэгтэй.” [127] Тэжээн тэтгэх харилцаа нь эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх, төрөл, садангийн хүний тэжээн тэтгэх, насанд хүрсэн хөдөлмөрийн чадвартай хүүхдийн эцэг, эхээ тэжээн тэтгэх гэсэн үүргүүдэд хуваагддаг.

Хүүхдийг тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаа үүсэх хууль зүйн үр дагавар нь гэрлэлт дуусгавар болсонтой холбоотойгоор үүсдэг. Гэрлэлтийг дараах тохиолдолд дуусгавар болгохоор хуульчилсан [128]. Үүнд:

1. Гэрлэгч нас барсан болон түүнийг нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн,

2. Гэрлэлтийг захиргааны буюу шүүхийн журмаар цуцалсан, эсхүл хүчин төгөлдөр бус гэж тооцсон дуусгавар болно.

Гэрлэлтийг захиргааны журмаар цуцлахад бол гэрлэлт гэрлэгчид нь гэрлэлтээ цуцлуулахыг харилцан зөвшөөрсөн, 18 хүртэлх насны хүүхэдгүй, эд хөрөнгийн маргаангүй гэрлэгчдийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн 30 хоногийн дотор гэр бүлийн бүртгэлийн байгууллага гэрлэлтийг цуцалдаг.

Харин бусад тохиолдолд шүүхийн журмаар шийдвэрлэдэг. Дээрх нөхцөлөөр гэрлэлтийг захиргааны журмаар цуцалхаас гадна дараах 2 тохиолдолд захиргааны журмаар гэрлэлтийг цуцлаж болно[129].

- Гэрлэгчдийн аль нэг нь 3 жилээс дээш хугацаагаар хорих ялаар шийтгүүлсэн бол нөгөө тал нь гэрлэлтээ цуцлуулах өргөдлөө гаргаж болох бөгөөд хорих ял эдлэх болсныг гэрчлэх шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолыг үндэслэн сум дүүргийн засаг дарга гэрлэлтийг цуцалж болно.
- Гэрлэгчдийн аль нэгийг шүүхээс иргэний эрх зүйн бүрэн

---

[127] Гэрлэгсдийн хэн нэг нь гэрлэлтээ цуцлуулах болон гэрлэлт хүчин төгөлдөр бус болсонд тооцогдохоос өмнө, эсхүл гэрлэлтээ цуцлуулснаас хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн чадвараа түр алдсан нь гэр бүлийн хүчирхийлэл болон гэрлэлт цуцлахаас өмнө болсон нөхцөл байдалтай шууд холбоотой үүссэн, хүндэтгэх шалтгааны улмаас хөдөлмөр эрхлэх боломжгүй болсон, гэрлэлт цуцлахаас өмнө тэтгэвэрт гарсан бол салсан нөхөр буюу эхнэрээрээ тэжээн тэтгүүлэх эрхтэй.

[128] http://www.legalinfo.mn/law/details/226?lawid=226

[129] С.Боловсон.Гэр бүлийн эрх зүй.2006 он. 58-р тал

чадамжгүй гэж тооцсон бол эхнэр нөхрийн аль нэгний хүсэлтээр шүүхийн шийдвэрийг үндэслэн захиргааны журмаар гэрлэлтийг цуцалж болдог байна.

Гэр бүлийн харилцаа дуусгавар болоход хүүхдийг тэжээн тэтгэх, асран хамгаалах асуудал үүсэх бөгөөд хүүхдийг эрүүл аюулгүй, сурч боловсрох, эрүүл өсөн торних бололцоо, ёс суртахууны байдал, хүчирхийлэл үйлдсэн эсэх зэрэг олон хүчин зүйлсийг харгалзан асран хамгаалагчийг томилдог. Гэр бүлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д Хүүхэд долоо ба түүнээс дээш настай бол асрамжийн асуудлыг шийдвэрлэхэд түүний саналыг харгалзан үзнэ гэж заасан.

Тэжээн тэтгэх харилцаа нь амины шинжтэй, хариу төлбөргүй, харьцангуй удаан үргэлжилсэн байдгийн дээр тэжээн тэтгэх үүргээ бусдад шилжүүлэх, эрх залгамжлуулах тухай асуудал байдаггүй.

Гэр бүлийн тухайн хуулийн 26 дугаар зүйлд: Хүүхдээ хүмүүжүүлэх эрх, үүргийг зааж өгсөн байдаг. Энэ зүйлийн 26.2-т эцэг, эх хүүхдээ хүмүүжүүлэхэд тэгш эрх эдэлж, адил үүрэг хүлээнэ гэвд

1. хүүхдээ эрүүл чийрэг өсгөн бойжуулах, сэтгэхүйн хувьд төлөвшүүлэх,

2. хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх,

3. хүүхдээ үндэсний ёс заншил, уламжлалаа дээдлэх үзлээр хүмүүжүүлэх, түүнд суурь боловсрол эзэмшүүлэх, хөдөлмөрийн анхны дадлага олгох гэж заасан байна.

Хүүхдийн тэтгэлэг гаргуулах ажиллагаа нь иргэний шийдвэр гүйцэтгэлийн бусад ажиллагаанаас дараах онцлогоор ялгагдана.

❖ Хүүхдийн тэтгэлэг нь сар бүр тодорхой мөнгөн дүнгээр төлөгдөж байдаг.

Хүүхдийн тэтгэлэг нь хүүхдийн насны байдлаас хамааран өөрчлөгддөг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийг шүүхээс тогтоосон бол жил бүрийн амьжиргааны түвшнээс хамааран өөрчлөгдөж байдаг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс өөр төлбөрийг суутгахыг хориглодог.

❖ Хүүхдийн тэтгэлэг бусад бүх төлбөрөөс тэргүүн ээлжинд төлөгддөг.

❖ Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс урамшуулап тооцохыг хориглодог ба зардлаас чөлөөлдөг.

❖ Хүүхдийн тэтгэлэг гаргуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь хэрэв тэтгэлэг төлөгч хэд хэдэн төлбөр авагчид төлбөр төлөх үүрэг хүлээсэн бол хүүхдийн тэтгэлэгийг дараалал харгалзахгүй тэргүүн ээлжинд олгоно.

Хүүхдийн тэтгэлийг гаргуулах ажиллагаа нь иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зарчим, процессын дагуу явагддаг. Шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлэгийн материалыг хүлээн авмагц хувийн хэрэг нээн тэтгэлэг төлөгчид тэтгэлэг төлөх хугацаатай мэдэгдэлийг дуудан ирүүлж гардуулах, эсвэл баталгаат шуудангаар хүргүүлнэ.

Тэтгэлэг төлөгч заасан хугацаанд тэтгэлэгийг төлөөгүй буюу биелүүлэхээс татгалзвал шийдвэр гүйцэтгэгч шийдвэрийг албадан

биелүүлэхээр дараах арга хэмжээ авна. Үүнд:

1/ тэтгэлэг төлөгчийн хөрөнгө, биед үзлэг, нэгжлэг хийх, эд хөрөнгийг битүүмжлэх, барьцаалах, хураах, худалдан борлуулах;

2/ тэтгэлэг төлөгчийн цалин, бусад орлогоос суутгал хийлгүүлэх;

3/ тэтгэлэг төлөгчийн бусдад байгаа эд хөрөнгө, мөнгөнөөс төлбөр гаргуулах;

4/ тэтгэлэг төлөгчийн банк дахь хадгаламжийн болон харилцах дансанд хасалт хийх

5/ хуульд заасан бусад арга хэмжээ.

Бусад төрлийн төлбөр гаргуулах ажиллагаанаас ялгагдаж буй дээрх онцлогуудаас харвал хүүхдийн эрх ашгийг төрөөс хамгаалж буйн нэгэн илрэл гэж үзэж болно. Тэтгэлэгийг төлбөр төлөгч, төлбөр авагч нар харилцан тохиролцож мөнгөн ба эд хөрөнгийн хэлбэрээр барагдуулж болно. Хэрэв эд хөрөнгийн хэлбэрээр барагдуулах бол тэтгэлэгт тооцох эд хөрөнгийг тэтгэлэг төлөгч, авагч талууд харилцан тохиролцох буюу тохиролцоогүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тухайн үеийн зах зээлийн ханшаар үнэлж тэтгэлэг авагчид олгоно.

Бусад төрлийн төлбөрийг гаргуулахдаа төлбөр төлөгч иргэний өмчлөлийн эд хөрөнгө болох бэлэн мөнгө банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө үнэт цаас түүнчлэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгөнөөс гаргуулдаг. Өөрөөр хэлбэл, төлбөр төлөгчийн эд хөрөнгөнөөс төлбөр гаргуулах дараалал нь

-бэлэн мөнгө

-банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгө

-банк, банк бус санхүүгийн байгууллага дахь хадгаламжийн болон харилцах дансанд байгаа үнэт цаас

-Төлбөр төлөгчийн хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө байна.

Дээрх эд хөрөнгө төлбөрийг төлөхөд хүрэлцэхгүй бол төлбөр төлөгчийн дундаа хэсгээр болон хамтран өмчлөх эд хөрөнгийн түүнд оногдох хэсгээс төлбөрийг гаргуулна.

Харин хүүхдийн тэтгэлэгийг тэтгэлэг төлөгчийн дараах орлогоос гаргахыг хориглодог. Үүнд[130]:

-Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, гэнэтийн аюул, онцгой байдлын улмаас үзүүлж буй тусламж, хандив

-Илүү цагийн хөлс, нэг удаагийн урамшил, ажлаас халагдсаны хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны Донор болон эхийн сүүнд олгож буй нөхөн олговрын мөнгө

-Нэмэгдэл хоол, амралт сувиллын эмчилгээ, хиймэл эрхтэн хийлгэхэд олгосон зардал

-Тахир дутуугийн тэтгэвэр

Хүүхдийн тэтгэлэгийн мөнгөнөөс бусад орлогоос төлбөр гаргуулж болдог.

Гэхдээ шүүхийн шийдвэрийн үндсэн тэтгэвэр, тэтгэмжээс төлбөр гаргуулж болдог. Уг харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр,

---

[130] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. 2002 он. 56 дугаар зүйл

тэтгэмжийн тухай[131] хуулийн 29 дүгээр зүйлд заасан. **Тэтгэвэр, тэтгэмжээс дараах тохиолдолд суутгал хийж болно.**

1/ Тэтгэвэр, тэтгэмж авагч хуурамч бичиг баримт бүрдүүлснээс болон энэ хуулийн 28 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргээ өөрийн буруугаас болж биелүүлээгүйгээс үндэслэлгүй буюу илүү авсан тэтгэвэр, тэтгэмжийг төлүүлэх тухай шүүхийн эсхүл нийгмийн даатгалын байгууллагын шийдвэр гарсан бол;

2/ Тэтгэвэр, тэтгэмж авагчийн төлбөл зохих энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаас бусад төлбөрийг түүний тэтгэвэр буюу тэтгэмжээс нь төлүүлэхээр шүүхийн шийдвэр гарсан бол суутгал хийж болно.

Гэр бүлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлд тэтгэлэг олгох хэлбэр, хугацааг дараах байдлаар зохицуулсан байна.

41.1. Тэтгэлгийг дор дурдсан хэлбэрээр олгож болно.

41.1.1. мөнгөн хэлбэрээр;

41.1.2. эд хөрөнгөөр.

41.2. Тэтгэлгийг дараах хугацаагаар олгож болно:

41.2.1. сар, улирал, хагас жил, жилээр;

41.2.2. нэг удаа.

41.3. Тэтгэлгийг хариуцагчийн цалин хөлснөөс суутгал хийх буюу хамтран өмчлөх эд хөрөнгөөс оногдох хэсгийг тодорхойлох үед болон бусад байдлаар олгож болно гэжээ.

Шийдвэр гүйцэтгэгч нь тэтгэлэг төлөгчийн ажиллаж байгууллага, хуулийн этгээд, эрх бүхий албан тушаалтанд цалин орлогоос суутгал тухай мэдэгдлийг хүргүүлдэг.

Мэдэгдэлд суутгал хийх тухай хувь хэмжээ болон суутгал хийгээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлж бичих ба мэдэгдэл хүлээн этгээд нь суутгалыг хийж мөнгийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын дансанд төвлөрүүлдэг.

Шийдвэр гүйцэтгэгч нь төлбөр төлөгчөөс бэлэн мөнгө хүлээн авахдаа хүлээн авах, мөн хураан авсан мөнгийг төлбөр авагчид олгохдоо тусгай дугаартай нэгдсэн маягтанд баримтыг ямар нэгэн засваргүйгээр 2 хувь үйлдэж, үйлдсэн огноог бичиж, гарын үсэг зуруулан, төлбөр төлөгчид 1 хувийг өгч, 1 хувийг нь хувийн хэрэгт хавсаргадаг. Шийдвэр гүйцэтгэгч нь хүлээн авсан бэлэн мөнгийг төв суурин газарт 24 цагийн, хөдөө орон нутагт 7 хоногийн дотор төлбөр авагчид олгох буюу шийдвэр гүйцэтгэх албаны дансанд шилжүүлэх бөгөөд гадаад валютын ханшийг шүүхийн шийдвэр гарсан өдрийн Монгол банкнаас зарласан албан ёсны ханшаар бодож олгодог.

Харин хүүхдийн тэтгэлгийн мөнгийг олгоход тэтгэлэг төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогоос суутгал хийсэн иргэн, хуулийн этгээд түүнийг төлбөр авагчид бэлнээр олгох буюу хадгаламжид нь шилжүүлдэг, эсхүл шийдвэр гүйцэтгэх албаны дансаар дамжуулан олгож болох бөгөөд орж ирсэн тэтгэлгийн мөнгийг банкаар дамжуулан тэтгэлэг авагчид бэлнээр

131 http://www.legalinfo.mn/law/details/383?lawid=383

олгох буюу түүний хадгаламжийн дансанд, эсхүл өөрийнх нь заасан дансанд шилжүүлэн олгодгоороо онцлогтой.

Хэрвээ тэтгэлэг төлөгч нь ямар нэг цалин орлогогүй тохиолдолд төлбөр гаргуулах дарааллыг баримтлан төлбөрийг гаргуулна.

Хүүхдийн тэтгэлэг төлөхөөс санаатайгаар зайлсхийх, хугацаанд нь төлөөгүйн хариуцлагыг хууль тогтоомжид хэрхэн тусгасныг үзвэл:

1. Эрүүгийн хуулийн[132] 120 дугаар зүйлд: Эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн буюу үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэхээс ноцтой зайлсхийх

“Хөдөлмөрийн чадваргүй эцэг, эх, эхнэр, нөхөр, төрүүлсэн болон үрчилж авсан хүүхдээ тэжээн тэтгэх талаар гарсан шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.”

Тайлбар: Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.[133]

Хүүхдийн тэтгэлэгийн төлбөр барагдуулах шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь удааширч байгаа шалтгаан нь доорх хүчин зүйлс нөлөөлөж байгаагаас тэтгэлэг төлөгдөхгүй удааширч, хүүхдийн эрх ашиг зөрчигдөх асуудал гарч байгаа юм. Үүнд:

1. Төлбөр төлөгчийн хаяг тодорхойгүй
2. Төлбөрийн чадваргүй / ажил, хөдөлмөр эрхэлдэггүй /
3. Тэтгэлэг төлөгч ял эдэлж байгаа
4. Эрэн сурвалжлагдаж байгаа
5. Эд хөрөнгөө бусдад шилжүүлэх зэргээс хамааран төлбөр авагч болон түүний төлөөлөгч нар өргөдөл, гомдол гаргах үндсэн нөхцөл нь болж байгаа юм. Хэдийгээр шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хууль, журмын хүрээнд явагдаж байгаа ч дээрх хүчин зүйлээс хамааран удааширч байгаа юм.

Мөн 1 шийдвэр гүйцэтгэгчид ноогдох гүйцэтгэх баримт бичгийн тоо их байгаагаас нийт гүйцэтгэх баримт бичигт бүрэн хүрч ажиллаж чадахгүй байдал үүсч байгаа юм. Нөгөө талаас хархад одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуулийн эрх зүйн зохицуулалт буруугаас зарим төлбөр төлөгч нарт тэтгэлэг төлөхөд хэцүү байдал гардаг. Жишээ нь: 1 хүүхдийн тэтгэлэг төлдөг төлбөр төлөгч 3 хүүхэдтэй байхад 1 хүүхдийн тэтгэлэгийн асуудлаас 3 хүүхдийн эрх ашиг хөндөгдөж байгаа нь эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй болсныг харуулж байна.

Тэтгэлэг төлөхөөс зайлсхийсэн төлбөр төлөгчид хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг хууль эрх зүйн орчноор нь сайжруулан өгөх хэрэгтэй юм.

Санал:

1. Хаяг тодруулах ажиллагааг боловсронгуй болгох, шийдвэр

---

132 http://www.legalinfo.mn/law/details/50?lawid=50

133 Улсын дээд шүүхийн 2009.06.24-ний өдрийн 22 дугаар тогтоол

гүйцэтгэгчид нуугдмал эд хөрөнгө илрүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах

2. Хүүхдийн тэтгэлгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны талаар шийдвэр гүйцэтгэгч нарыг дадлагажуулах нэгдсэн сургалтыг тодорхой үе шаттайгаар зохион байгуулах

4. Тэтгэлэг төлөхөөс зайлсхийж байгаа төлбөр төлөгч нарт хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох зэрэг саналтай байна



Б.МӨНГӨННАХИА
Санхүү эдийн засгийн
дээд сургуулийн
Хүмүүнлэгийн ухааны
тэнхимийн багш,
хууль зүйн магистр

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Товч агуулга

“ХЭРЭГЛЭГЧ ХААН” гэсэн лоозонг та аль ч үйлчилгээний байгууллагын танилцуулга, сурталчилгаа дээрээс харж болно. Хэрэглэгч та хаан гэх лоозон нь дэлхий даяар түгэн тархаж буй өнөөгийн нийгмэд хэрэглэгч гэж хэн болох, түүний язгуур эрх ашгийг хэрхэн хамгаалж, энэ талаар дотоодын хууль тогтоомждоо тусгаснаас хамаарч улс орны хөгжлийн түвшин тодорхойлогддог. Хэрэглэгч хаан гэж өргөмжлөх нь зүй ёсны асуудал бөгөөд хэрэглэгчгүйгээр ямар ч бизнес урагшлахгүй нь тодорхой юм. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн харилцаа нь бүхий л цаг үеийн нийгмийн хамгийн чухал тулгуур ойлголт болж иржээ. Тиймээс ч хэрэглэгчийн эрхийг хамгаалахад туглгамдаж буй асуудал нь хууль эрх зүйн орчинтойгоо хэрхэн уялдаж буй талаар дүн шинжилгээ хийх үүднээс энэхүү сэдвийг сонгон судлав. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль нь хэрэглэгчийн бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршдог. Мөн хэрэглэгчийн эрх зөрчигдсөн тохиолдолд хэрхэн хамгаалах, зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын тухай хуульд тусгасан байдаг. Гэвч хэрэглэгчийн эрхийг хамгалах хууль, хууль эрх зүйн орчин нь хэрэглэгчийг хаан шиг байлгаж эрхэмлэн, эрхийг нь зөрчихгүй байж чадаж байна уу?, Монгол Улсын хууль тогтоомжууд нь хэрэглэгчийн эрхийг хамгаалахад хангалттай зохицуулалт хийж чадаж байна уу гэдэгт дотоодын хууль эрх зүйн орчин хийгээд гадаадын зарим улс орны сайн туршлагыг судлан, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад төр, засгийн цогц бодлого хэрэгтэй байгааг судалгааны ажлын үр дүнгээр илэрхийлэхийг зорилоо.

Түлхүүр үг

Хэрэглэгч, хэрэглэгчийн эрх, хэрэглэгчийн эрх зүйн зохицуулалт, ХЭАХН-Хэрэглэгчийн эрх ашигийг хамгаалах нийгэмлэг, ШӨХТГ-Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар

ОРШИЛ

Хэрэглэгч гэж хэн бэ?

Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 3.1.1-д “хэрэглэгч” гэж бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны бус, зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээгээ хангахад зориулан захиалж, худалдан авч, үйлчлүүлж байгаа, эсхүл хэрэглэж байгаа хувь хүнийг хэлнэ гэж

томьёолсон байдаг. Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан “Бизнесийн эрх зүй” 2014 он., сурах бичигт: “хэрэглэгч гэж нэгдүгээрт, хүн бүрийг хэлэхгүй ба гагцхүү бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан худалдан авахаар захиалж гэрээ хэлцэл байгуулсан үнийг төлсөн эсвэл урьдчилгаа мөнгийг өгсөн, ажил үйлчилгээ хүртсэн хувь хүнийг хэлж байгаа ойлголт юм. Хоёрдугаарт, бүх л төрийн бараа, ажил, үйлчилгээ бас биш юм. Энэ нь зөвхөн хувийн болон гэр бүл, ахуйн хэрэгцээнд зориулагдсан байх ёстой юм”. [1] гэж тодорхойлсон байна.

Хэрэглэгчийн эрх зүй гэдэг нь иргэдийн материаллаг, соёлын болон бусад хэрэгцээг хангахад чиглэсэн харилцааг зохицуулж буй хэд хэдэн салбар эрх зүйгээс /захиргааны, иргэний, эрүүгийн гэх мэт/ бүрдсэн цогцолмол эрх зүй юм. Хэрэглэгчийн эрх зүйн харилцааг манай орны хувьд 1990-ээд оноос эхлэн “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Хэрэглэгчдийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим”, “Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг” зэрэг эрх зүйн актуудаар баталгаажуулан, зохицуулж байна.

Хэрэглэгчийн эрхийг “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар”, “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг” ТББ зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын түвшинд хамгаалж байна. Мөн сүүлийн жилүүдэд хэрэглэгчийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалахад чиглэсэн бодитой ажлууд хийгдэж байгааг та бид хэвлэл мэдээллийн хэрэгслээр сонсож, анзаарч байгаа билээ.

Хэрэглэгчийн эрх нь хүний эрхийн хамгийн өргөн хүрээг хамаардаг бөгөөд хүн болж төрсөн хэн бүхэн хамаатай бүх хүнд заяасан төрөлх эрхийн төрөл юм. Иймээс хэрэглэгчийн эрхийг хамгаалах нь төр засгийн байгууллагын анхдагч үүрэг болохыг 1993 онд болсон Дэлхийн хүний эрхийн бага хурлаар баталсан Венийн тунхаглалд тодорхойлсон байдаг.

XX зууны 60-аад оноос эхлэн хэрэглэгчийн эрхийг хамгаалах хөдөлгөөн Америкийн нэгдсэн улсад хүчтэй өрнөж эхэлсэн бүюу “Consumerizm” гэдэг нэр томьёо нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэсэн агуулгаар хэрэглэгдэж иржээ. [2] 1962 оны 3-р сарын 15-ны өдөр Америкийн нэгдсэн улсын 35 дахь ерөнхийлөгч асан Дж.Кеннеди улсынхаа үндэсний эрх ашгийг хамгаалах үүднээс энгийн америк иргэн-хэрэглэгчийн эрхийг тэнцвэржүүлэн баталгаажуулж Америкийн хэрэглэгчийн үндсэн эрх болох *аюулгүй байх, сонголт хийх, мэдээлэл авах, санал бодлогоо чөлөөтэй илэрхийлэх, хэрэглэгчийн боловсролын эрх* хэмээх таван язгуур эрхүүдийг тунхагласан нь эдүгээ Хэрэглэгчийн олон улсын байгууллага /The consumers international/-ыг үүсгэн байгуулах суурь болсон төдийгүй НҮБ-ын 1985 онд баталсан “Хэрэглэгчийг хамгаалах дүрэм”-ийн эхлэл болжээ. Олон улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах 1960 онд үүсгэн байгуулагдсан Лондон хотод төвтэй “Хэрэглэгчийн олон улсын байгууллага” болон 1972 онд

---

[1] Б.Дэлгэрмаа, Д.Оюун, Ж.Хулан “Бизнесийн эрх зүй”., УБ. 2014 он.

[2] http://en.wikipedia.org/wiki/Consumerism


байгуулагдсан Брюссель хотод төвтэй “Европын хэрэглэгчийн эрхийн байгууллага”-ууд нь идэвхтэй ажиллаж байна. Дэлхийн 2-р дайны дараагаас хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хөдөлгөөн нь баруун европын орнуудад хүчээ авсан ба Их британи, Герман, Швед зэрэг орнуудад өрнөсөн. Европд анх 1954 онд Нидерландад “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах холбоо”, Англид 1975 онд “Их Британын хэрэглэгчийн үндэсний зөвлөл”, 1978 онд Финляндад хэрэглэгчийн эрхийг хамгаалах төрийн байгууллага тус тус байгуулагджээ. Оросын Холбооны Улсад 1980-аад оны дунд үеэс хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, холбоод байгуулагдсан байна.

Дээрх байдлаас үзэхэд хөгжингүй орнуудад хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг, холбоод эртнээс үүссэний сацуу хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр төрөл бүрийн хэрэглэгчийн нэвтрүүлэг явагддаг. Үүнийгээ дагаад хэрэглэгч гэж хэн байх, хэрэглэгчийн эрхийг хэрхэн хамгаалах тухай эрх зүйн зохицуулалт нь боловсронгуй болсоор ирсэн гэж ойлгож болно.

ҮНДСЭН ХЭСЭГ

1. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт

Монгол Улс хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг 1991 онд баталж, 1992 онд Монгол Улсын Засгийн Газар НҮБ-ын Ерөнхий Ассамблейгээс сайшаан дэмжсэн “Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад баримтлах үндсэн зарчим”-ыг ҳүлээн зөвшөөрч, “Монголын хэрэглэгчдийн эрхийн тухай тунхаг”-ийг 1993 онд батлан гаргажээ. 2003 онд Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан ба 2008 онд хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Харин 2009 онд Монгол Улсын Засгийн газраас хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлжээ. Одоогоор Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 500 гаруй хууль байгаагаас хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой 30 орчим хууль, эрх зүйн акт үйлчилж байна. Энэ дотроос хэрэглэгчийн хууль ёсны язгуур эрх ашиг /аюулгүй байх, сонголт хийх, мэдээлэл авах, санал бодлогоо чөлөөтэй илэрхийлэх, хэрэглэгчийн боловсролын эрх/-ийг хамгаалах зорилго бүхий дараах хууль



тогтоомжууд байна. Үүнд:

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль, Өрсөлдөөний тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Хүнсний тухай хууль, Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хууль, иргэний хууль, эрүүгийн хууль ... Түүнчлэн Монгол улсын үндсэн хуулийн 16-р зүйлийн 16.2 дахь хэсэгт эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй[1] гэж заажээ. Мөн Монгол Улсын үндсэн хуулийн 10-р зүйлийн 10.3-т Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ[2] гэж заасан нь “Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт”, “Хүний эрхийн түгээмэл тунхаглал” нь манай улсын хуулийн нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ гэсэн үг юм. Дээрх хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцод хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг зохицуулж байна. Үндсэн хуульдаа хэрэглэгчийн эрхийг баталгаажуулж хангахаар зааж, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульдаа энэ тухай нарийвчлан зохицуулсан боловч хэрэглэгчээс авсан судалгааг харахад,

Хэрэглэгчийн эрхийн тухай ойлголтыг бага зэрэг мэднэ, муу мэднэ, огт мэдэхгүй гэх хариултууд байгаа нь хэрэглэгчид эрхээ хэрхэн хэрэгжүүлэх, эрх нь зөрчигдсөн буюу хохирол учирсан тохиолдолд хэрхэн хаана хандахаа мэдэлгүй хохироод үлддэг гэж харж болохоор байна. Мөн ШӨХТГ-т ирсэн өргөдөл гомдлыг ангилж үзвэл барилга, орон сууц, СӨХ, банк, харилцаа холбооны салбаруудад иргэдийн гомдол зонхилж байгаа бол 2014 онд нийт 2569 өргөдөл, гомдол хүлээн авсны 60% нь хэрэглэгчийн эрхтэй холбоотой гомдол, 25% нь барилга, орон сууцны /метр квадратны зөрүү/ асуудлаар гаргасан байгаа нь дээрх салбаруудад хэрэглэгчийн эрх илүүтэйгээр зөрчигдөж байна. Эндээс 60% нь хэрэглэгчийн эрхтэй холбоотой гомдол байдаг гэж харахад энэ талын хэрэглэгчийн эрх нэлээд зөрчигдөж байна гэж хэлж болхоор байна. Тэгвэл хэрэглэгч зөрчигдсөн эрхээ хэрхэм хамгаалуулдаг, хохирлоо хэрхэн төлүүлдэг тухайд авч үзвэл:

Энэ тухайд нэгэн жишээ дурдахад: АНУ-ын иргэн Жесси Виллиамс гэгч эр Филип Морисс компанийн брэнд бүтээгдэхүүн болох Марлборо тамхийг худалдаанд гарснаас хойш 47 жилийн хугацаанд тасралтгүй хэрэглэсэн бөгөөд тэрээр уг тамхинд бие эрхтэн, оюун санааны хувьд бүрэн донтсон байна. Түүний эхнэр болон хүүхдүүд тамхины улмаас хүний бие махбодод ямар сөрөг үр дагавар учирч болохыг түүнд ойлгуулж, түүнийг тамхинаас гаргах гэж идэвхтэй оролдсон ч оролдлого бүр бүтэлгүйтжээ. Филип Морисс компани өөрийн зар сурталчилгаагаар Марлборо тамхи нь бусад шүүлтүүргүй тамхийг бодвол хүний биед сөрөг үр дагаваргүй, уушгины хорт хавдраас айх хэрэггүй хэмээн олон нийтэд танилцуулсан учир Жесси Виллиамс Филип Морисс компанийн хүний бие махбодод хортой бүтээгдэхүүн худалдаалахгүй гэдэгт

[1] Төрийн мэдээлэл эмхэтгэл №1
[2] Төрийн мэдээлэл эмхэтгэл №1

бүрэн итгэдэг байсан аж. Гэвч Жесси Виллиамсын биеийн эрүүл мэндийн байдал муудаж, эмнэлэгт үзүүлтэл тэрээр уушгины хүнд хэлбэрийн хорт хавдар туссан, энэ нь тамхи их хэмжээгээр татдаг байсантай холбоотой хэмээн шинжилгээний дүгнэлт гарчээ. 6 сарын дараа тэрээр нас барсан байна.

Жесси Виллиамсын эхнэр Филип Морисс компанийг хэрэглэгчийг хуурч мэхлэсэн, худал мэдээлэл өгсний умаас хүний амь насанд гэм хор учруулсан үндэслэлээр зарга үүсгэсэн бөгөөд шүүхээс хохирлын нөхөн төлбөр болгон 821,485.50 ам доллар, хэрэглэгчийн эрхийг зөрчсөний төлөө иргэний эрх зүйн залхаан цээрлүүлэх хариуцлага болгон 79 сая ам долларыг нэхэмжлэгчид олгон (punitive damage) шийдвэрлэж, 79 сая ам долларын 60 хувийг гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийн санд шилжүүлэхээр шийдвэрлэжээ.[1] Хэрэв манай улсад энэ төрлийн хэрэг маргаан гарч бизнесийн байгууллага гэм буруутай болох нь тогтоогдвол уг байгууллагад зар сурталчилгааны тухай хууль зөрчсөн үндэслэлээр 50,000-250,000 төгрөгийн торгууль, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8 “Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчид бараа, ажил, үйчигээтэй холбоотой худал мэдээлэл өгөхийг хориглоно”, 12.9 “Бараа, ажил үйлчилгээг хууран мэхлэх, төөрөгдүүлэх, хүч хэрэглэх замаар худалдах, гүйцэтгэх, хэрэглэгчийн эрхийг хохироосон гэрээ байгуулахыг хориглоно” гэсэн хуулийн заалтыг зөрчсөн үндэслэлээр 100,000-250,000 төгрөгийн торгууль ногдуулж, Иргэний хуулийн зөрчлийн улмаас үүсэх үүргийн эрх зүйн зохицуулалтаар хариуцагч этгээдээс зарим зардлыг гаргуулан нэхэмжлэгчид олгох үндэслэл байж болох ч нэхэмжлэлийн шаардлагыг хангах эсэх нь хууль хэрэглээний практикийн хувьд эргэлзээтэй. Хэрэглэгчийн эрхийн хамгийн чухал хөндөгдөж буй асуудал нь **үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх** юм. Худалдан авагч буюу хэрэглэгч нь **учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх** ямар эрхтэй болохыг тайлбарлая.

- Худалдан авагч нь эд хөрөнгийн доголдлыг өөрийнхөө зардлаар арилгаж өгөхийг худалдагчаас шаардах эрхтэй
- Худалдан авагч нь доголдолтой эд хөрөнгийг доголдолгүй эд хөрөнгөөр сольж өгөхийг худалдагчаас шаардах эрхтэй
- Худалдан авагч гэрээнээс татгалзах эрхтэй. Татгалзсан тохиодолд худалдан авагч эд хөрөнгийг буцаан өгч, худалдагч үнийг буцаан авах эрхтэй байна.

Юуны өмнө хэрэглэгч дээрх эрхээ хэрэгжүүлэхийн тулд хуульд заасан ямар хугацаанд гомдлын шаардлага гаргах эрхтэй болохыг тодруулбал: Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн **6 дугаар зүйлийн 6.2** Бараанд биет байдлын доголдол /тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу

[1] https://www.law.cornell.edu/supct/cert/07-1216

учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй гэж заасан байна. Эндээс харахад “...хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй” гэсэн заалт нь ойлгомжгүй, практик хуульчид харилцан адилгүй ойлгож хэрэглэх явдал ажиглагддаг. Иргэний хуулийн тайлбарт нэн даруй гэх хугацааг “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд гэж ойлгоно [1] гэжээ. Энэ нь мөн хуульчид, шүүгчид өөрсдийн үзэмжээр шийдэх асуудал болоод байна. Үүнийг нэг мөр болгож өмгөөлөгч, шүүгчид энэ хугацааны тухай нэг мөр ойлголтод хүрэх хэрэгтэй байна. Тухайлбал иргэн Ж нь гэрийнхээ ойролцоо байдаг нэгэн цахилгаан барааны дэлгүүрээс богино долгионы зуух худалдан авчээ. Гэтэл уг зуух нь 3 сар хэрэглэсний дараа ажиллахгүй болсон байна. Энэ үед хэрэглэгч тухайн зуухыг доголдолтой бараа гэж үзэн дэлгүүрт буцаан өгч болж байгаа юм. Гэхдээ иргэний хуулийн 254.6. Худалдагч эд хөрөнгийн баталгаат хугацаа тогтоосон бол энэ хугацааны дотор, баталгаат хугацаа тогтоогоогүй бол тухайн эд хөрөнгийг өмчлөх эрхийг шилжүүлэн авснаас хойш зургаан сарын дотор доголдлыг илрүүлсэн худалдан авагч энэ хуулийн 254.1-д заасан шаардлагын аль нэгийг гаргах эрхтэй. 254.7. Эд хөрөнгийн баталгаат хугацааг худалдан авагчид эрсдэл шилжсэн үеэс эхлэн тоолох бөгөөд хэрэв баталгаат хугацааны дотор гол доголдлыг илрүүлсэн бол худалдан авагчид эрсдэл шилжих үед уг доголдол байсан гэж үзнэ гэснийг хагалзан үзэх ёстой. Энэ тохиолдолд худалдагч шаардлагыг иргэний хуульд зааснаар хангах үүрэг хүлээдэг бол хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд, гэрээнд заасан хугацаагаар эсвэл нэн даруй гэж заасан хугацааны дагуу шаардлагыг хангах үүрэг хүлээнэ. Дээрх хуулийн шаардах эрхийн нэн даруй гэсэн хугацааг тодорхойлж, хэрэглэхэд хүндрэлтэй байна.

Мөн хуулийн 6-р зүйлийн 6.3. Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар шаардлагыг гаргах эрхтэй гэж хуульчилсан байна. Энэ нь мөн л ойлгож, тайлбарлахад хүндрэлтэй байдаг. Жишээ нь А нь нийслэлд байдаг нэгэн автомашин худалддаг газраас Тоёото маркийн авто машин худалдан авчээ. Хуулийн дагуу шилжүүлж авснаас хойш 3 сарын дараа дөрвөн хаалганы цахилгаан түгжээ нь сайн ажилладаггүй болохыг олж мэдсэн байна. Нэг хаалга нь байнга түгжигддэггүй үлддэг байж. Тэгсэн хэдий ч 3 сарын турш унасан байна. А нь 3 сарын дараа автомашин худалдаагаа газар очиж тухайн машинаа доголдолгүй авто машинаар сольж өгөхийг шаарджээ. Энд дээр дурдсан шаардлага гаргах хугацаа ярихаас гадна тухайн автомашиныг 3 сар унаж 4.000 км явсан А-аас мөнгөн

[1] http://www.supremecourt.mn/

төлбөр гаргуулах уу гэдэг асуудал үүснэ. Энэ тохиолдолд автомашин худалдааны газар Б-д доголдолтой автомашиныг сольж өгч байгаа тохиолдолд хэрэглэгдсэн хугацааны элэгдэлд нөхөн төлбөр төлөхийг шаардах эрхтэй гэсэн утгатай хуулийн заалт байхгүй байна. Энд худалдан авагч нь доголдолтой эд хөрөнгийг доголдолгүй эд хөрөнгөөр сольж өгөхийг худалдагчаас шаардах тохиолдолд өмнө нь шилжүүлсэн доголдолтой эд хөрөнгийг буцаан өгөхийг худалдан авагчаас шаардах эрхтэй байдаг. /Иргэний хууль 253.3/ Мөн хэрэглэгч тухайн барааны доголдлоо гуравдагч этгээдээр арилгуулсан бол хэрэглэгчид учирсан хохирлыг худалдагч хариуцах эсэх нь мөн л хуульд тусгагдаагүй, зохицуулалтгүй байна. Энэ нь хэрэглэгч болон худалдагч хоёрын хооронд үл ойлголцох асуудал үүсч болохоор, ойлголмжгүй заалт юм. Дээрхээс харахад үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухайд хэдийгээр иргэний хуулийг төсөөтэй хэрэглэж байгаа ч иргэний хуулийн зүйл заалт хангалттай зохицуулалт болж чадахгүй байна гэж дүгнэж болохоор байна.

Дээрх хуулийн зүйл заалтаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд гэм хороо хэрхэн нэхэмжлэх, учирсан хохирлыг хэрхэн хариуцах, сэтгэл санааны гэм хорыг арилгах тухай зохицуулалт байхгүй. Тухайлбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Бараа, ажил үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг иргэний хуулийн 18, 52 дугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заасан нь мөн л зохицуулалт хангалтгүй гэж үзэж байгаа юм. Энэхүү судалгааны ажилд зөвхөн ХЭХтХ-ийн 6-р зүйлд тулгамдаж буй асуудлын тухай сонгон судлагдсан бөгөөд тус хуульд үүнээс гадна тодорхойгүй, ерөнхий зохицуулалт байгааг үргэлжлүүлэн судлах болно. Мөн Монгол Улсын Эрүүгийн хуулийн Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх /169 дүгээр зүйл/, Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах /171 дүгээр зүйл/, Эрүүл мэндийн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалах /172 дугаар зүй/ гэсэн тусгай гэмт хэргүүдийг нэрлэсэн байдаг ба энэ тухай үргэлжүүлэн судлах болно.

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомж нийгмийн харилцааг бүрэн гүйцэд зохицуулж чадахгүй улмаар хуулийн хийдлийг бий болгож байвал бусад улс орны дэвшилтэд эрх зүйн зохицуулалтыг эх орын хууль, эрх зүйн хөрсөнд монгол хүний ухамсар хийгээд нийгмийн амьдалд зохицуулан буулгах шаардлага тулгардаг. Иймд бусад улс орнуудын дэвшилтэд зохицуулалтыг авч үзье.

2. Гадаадын зарим улсын сайн туршлага

Гадаадын зарим улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай

хуульд шинжилгээ хийж Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох сайн туршлага судаллаа.

Тухайлбал: Хятад улсад 1993 онд “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай хууль” анх батлагджээ[1]. Энэхүү хууль нь цахим худалдаан дахь олон талын зохицуулалтыг хийдэг байна. Үүнд:

- хуулийн дагуу гэм хор арилгах,
- хэрэглэгчийн харилцаа холбоог албан ёсоор хүлээн зөвшөөрөх,
- хувь хүний мэдээллийг хамгаалах,
- үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ташаа мэдээллийн улмаас хэрэглэгчид учирсан гэм хорыг хариуцах гэх зэрэг олон асуудлыг зохицуулжээ.

Эдгээрээс гадна цахим худалдааны журам хэрэгждэг байна. Худалдагч нар худалдан авагчдын сэтгэлд хүртэл бараа бүтээгдэхүүнийхээ тухай үнэн зөв мэдээллээр хангах, мөн худалдан авалт хийснээс хойш 7 хоногийн дотор хэрэглэгчид учирсан гэм хорыг тухайн байгууллага хариуцаж нөхөн төлөх ёстой байдаг байна.

Олон улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах байгууллагуудаас дурдвал:

- АНУ-д холбооны худалдааны комисс “Federal Trade Commission”
- Англи улсад Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг “Consumer Protection Association”
- Солонгос улсад Солонгос улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах агентлаг “Korea Consumer Agency”

[1] www.wikipedia.org

зэрэг манай улсын Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газартай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд байдаг. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах **тухай хуулийн** 6 дугаар зүйл. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийг Малайз, Канад улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн холбогдох зүйл заалттай нь харьцуулан үзэхэд. Малайз улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль[2] /Consumer protection act 1999/ **нь** Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухай нарийн зохицуулалт хийж өгсөн ба “...нийлүүлэгчээс урьдчилан товлосон хугацаанд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй” гэж хуульчилсан байдаг. Мөн хэрэглэгч “...гэм хорыг арилгуулахад гарсан бүх зардлыг нийлүүлэгчээс гаргахыг шаардах эрхтэй” байхаар хуульчилсан нь манай улсын хуульд маргаантай байдаг асуудлыг зохицуулахаар хуульчилсан нь сайн талтай юм. Канад улсад хэрэглэгчийн эрхийг хамгаалах олон төрлийн хууль байдгаас барааны аюулгүй байдлыг хамгаалах хууль нь /Canada Consumer Product Safety act/ түгээмэл хэрэглэгддэг бөгөөд 2010 онд батлагдсан[3] байна. Энэ нь хэрэглэгчийн эрхийг хамгаалах тал дээр манай улсын хуультай харьцуулахад нарийвчилсан зохицуулалтыг зааж өгсөн давуу

[2] http://www.aseanconsumer.org/
[3] http://www.canadianlawsite.ca/consumer-protection.htm

талтай. Монгол Улс нь одоогоор худалдааны тухай хуульгүй ба барааны аюулгүй байдлыг хангах асуудлыг хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулиар зохицуулж байна.

ДҮГНЭЛТ

Хууль амьдралаас тасрах ёсгүй бөгөөд тухайн хуулиар хамгаалагдах ёстой субьектын эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчих ёсгүй юм. Ингэж зөрчих нөхцөлийг бүрдүүлж улмаар эрх зүйн хийдлийг бий болгосноор хууль үнэ цэнээ алдаж, цагаан цаасан дээр хараар бичигдсэн бичээс болон хувирах, эрсдэлийг дагуулж байдаг. Дэлхий ертөнц дээрх 7 тэрбум гаруй хүнийг нийгмийн гарал үүсэл, үндэс угсаа, шашин шүтлэг, боловсролын байдлаас үл хамааран нэгэн нэрийн дор ХЭРЭГЛЭГЧ хэмээх нэрийг хууль зүйн талаасаа хэрэглэдэг. Чинээлэг хэрэглэгч, ядуу хэрэглэгч, гадаадын хэрэглэгч, дотоодын хэрэглэгч гэж хэнийг үл ялгаварлан тухайн улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль нь үйлчлэх учиртай. Тиймдээ ч судалгааны ажилдаа Монгол Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн зохицуулалтад тулгамдаад байгаа үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрхийн тухай асуудлыг гадаадын зарим орны хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотой хууль тогтоомжтой харьцуулан судалсан. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 6-р зүйл “Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх”-ийн эрх зүйн зохицуулалт нь төдийлөн хангалттай зохицуулалт болж чаддаггүйг *Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт* хэсэгт дурдсан болно.

Дүгнэн хэлэхэд манай улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль нь ёрөнхий зохицуулалт ихтэй, шинэчлэн найруулах шаардлагатай юм. Тухайлбал “...хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй” гэсэн нь хугацааны хувьд тодорхойгүй ба хуульч, шүүгчид нэн даруй гэх хугацааг нэг мөр ойлгодог болох шаардлагатай. Мөн иргэний хуулийн 254.1 нь доголдлыг арилгахтай холбогдон гарсан зардлыг худалдагчаас шаардах худалдан авагчийн эрхийн хувьд тодорхой бус байна. Магадгүй, хэрэглэгч хэдийд ч доголдлыг арилгахыг шаардаж болох ба энэ хугацаанд гарсан зардлыг хэн нь хэрхэн яаж төлөх нь тодорхойгүй, харилцан тохиролцож /Канад улсын хуульд ийм заалт бий/ болох заалт байхгүй нь хэрэглэгч болон үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн хооронд маргаан үүсэх, үл ойлголцох асуудал үүсч болохоор байна. Дээрх хуулийн зүйл заалтаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд гэм хороо хэрхэн нэхэмжлэх, учирсан хохирлыг хэрхэн хариуцах, сэтгэл санааны гэм хорыг арилгах тухай зохицуулалт байхгүй. Тухайлбал, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т “Бараа, ажил үйлчилгээний чанар, аюулгүй

байдлыг хангаагүйгээс хэрэглэгчийн амь насанд аюул, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд гэм хор учруулсны төлбөрийг иргэний хуулийн 18, 52 дугаар бүлэгт заасны дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлэх эрхтэй” гэж заажээ. Харин Монгол Улсын Эрүүгийн хуулийн Аж ахуйн эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт Хэрэглэгчийг хуурч мэхлэх, төөрөгдүүлэх /169 дүгээр зүйл/, Гологдол буюу чанар муутай бүтээгдэхүүн худалдах /171 дүгээр зүйл/, Эрүүл мэндийн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдаалах /172 дугаар зүй/ гэсэн тусгай гэмт хэргүүдийг нэрлэсэн байдаг ба энэ тухай үргэлжүүлэн судлах болно.

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна.

-Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хохирол нөхөн төлүүлэх, доголдол арилгуулах хугацааны тухай зүйл заалтад нэмэлт өөрчлөлт оруулж ойлгомжтой, тодорхой болгох нь үүнийг хуульч, судлаачид нэг мөр ойлгож хэрэглэхэд тустайгаас гадна хэрэглэгчийн эрхийг хамгаалах гэсэн утгыг бүрэн илэрхийлж өгнө.

- Иргэний хуулийн доголдлыг арилгахтай холбогдон гарсан зардлыг худалдагчаас шаардах худалдан авагчийн эрхийн хувьд тодорхой бус байгааг тодорхой болгох, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуультай уялдуулан хуульчлан тогтоох,

- Бизнес эрхлэгчид хэрэглэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн тохиолдолд хэрэглэгч хэдий хугацаанд хохирлоо барагдуулахаар гомдол гаргах эрхтэй болох тухай хууль эрх зүйн орчинг судлах,

- Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчинг судлан, судалгааг хуульд нэвтрүүлэх,

- Гадаадын зарим улс орны буюу Малайз, Канад, АНУ зэрэг хөгжилтэй улсуудын хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуульд заасан тодорхой хугацаа, тодорхой заалтуудыг Монгол Улсад зээлдэн авч нутагшуулах зэрэг болно.

Монгол Улс	Малайз Улс
6 зүйл. Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчийн буруугаас учирсан гэм хорыг арилгуулах, хохирлыг нөхөн төлүүлэх хэрэглэгчийн эрх	**5-р бүлэг** “Нийлүүлэгчдийн эсрэг гомдол гаргах хэрэглэгчийн эрх”
6.2. Бараанд биет байдлын доголдол /тоо, хэмжээ, чанар, хугацаа/ болон эрхийн зөрчил илэрвэл хэрэглэгч гэрээнд заасан хугацаанд буюу хугацаа заагаагүй бол нэн даруй уг гэм хорыг арилгах буюу учирсан хохирлыг нөхөн төлөхийг худалдагчаас шаардах эрхтэй.	**41.** Хэрэглэгч баталгааг хангаагүй бараа бүтээгдэхүүнд нийлүүлэгчийн эсрэг гомдол гаргах эрхтэй. Баталгаагааг хангаагүйгээс үүссэн гэм хорыг хэрэглэгч: 1. гэм хорыг арилгах боломжтой бол энэ хуулийн 42 заасны дагуу нийлүүлэгчээс урьдчилан товлосон хугацаанд гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй. Нөхөн төлбөр нь хэрэглэгчийн төлбөл зохих эсвэл төлсөн дүнгээс доогуур байна.

6.3.Хэрэглэгч согог гэмтэлтэй, иж бүрдэлгүй, тоо, хэмжээ, чанарын шаардлага хангаагүй бараа борлуулсан худалдагчид Иргэний хуулийн 254 дүгээр зүйлд заасны дагуу уг барааны доголдлыг арилгуулах, хохирлоо нөхөн төлүүлэх талаар шаардлага гаргах эрхтэй.	2. Гэм хорыг арилгах боломжгүй эсвэл их хэмжээний гэм хор байвал тус хуулийн 44 дугаар зүйлд заасны дагуу: а/ 43 зүйлд зааснаас бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүнээс татгалзах эрхтэй б/ учирсан гэм хороос үүдэн бүтээгдэхүүний үнэ цэнэ буурсан бол буурсан үнэ цэнэтэй тэнцэх хэмжээний нөхөн төлбөр нийлүүлэгчээс гаргуулах эсхүл үнийг бууруулах эрхтэй 3. Хэрэв нийлүүлэгч гэм хорыг арилгахаас татгалзсан эсхүл үл хайхарсан эсхүл тодорхой хугацаанд гэм хорыг арилгаагүй болон үл хайхарсан бол хэрэглэгч: а/ Өөр байдлаар гэм хорыг арилгахыг шаардах, гэм хорыг арилгуулахад гарсан бүх зардлыг гаргахыг нийлүүлэгчээс шаардах эрхтэй. б/ 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд бараа бүтээгдэхүүнээс татгалзах эрхтэй